



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АРГА ЗҮЙ

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР
2019 ОН

Энд илэрхийлсэн үзэл санаа нь зохиогчдынх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй.

Энэхүү арга зүйн гарын авлага, сургалтын хөтөлбөр нь НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд хэвлэв.

Боловсруулсан:

Д.Амаржаргал	Нийтийн эрх ашгийг хамгаалах хуульчдын санаачилга ТББ
В.Бэрцэцэг	Монголын Мэргэжлийн урлагийн сэтгэл заслын холбоо
М.Нямдорж	МУБИС, Боловсрол судлалын сургууль, Нийгмийн ажил арга зүйн тэнхим
Х.Өлзийтунгалаг	МУБИС, Боловсрол судлалын сургууль, Нийгмийн ажил арга зүйн тэнхим

Хянан тохиолдуулсан:

Б.Туяа	МУБИС, Боловсрол судлалын сургууль, Сэтгэл судлал арга зүйн тэнхим
Х.Өлзийтунгалаг	МУБИС, Боловсрол судлалын сургууль, Нийгмийн ажил арга зүйн тэнхим
Н.Баярмаа	ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга
Р.Нарантуяа	ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн шинжээч

Техникийн зөвлөх:

Х.Энхжаргал	НҮБ-ын Хүн Амын Сангийн зөвлөх
-------------	--------------------------------

Хэвлэлийн дизайнер: Б.Бүжидмаа

Хэвлэлийн хэмжээ: 210x297

Хэвлэлийн хуудас: 13.5 хх

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж-5, Улаанбаатар-15160

Факс: +(976) 11-328634

И-мэйл: info@mlsp.gov.mn

«Мөнхийн Үсэг» ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9519-9-3



ӨМНӨХ ЦГ

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулга нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудтай уялдан цогцоор хэрэгжиж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн томоохон дэвшил болсон юм.

Энэхүү хууль эрх зүйн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрүүл мэнд, нийгэм, сэтгэлзүй, хууль зүйн болон аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээг салбар дундын уялдаа холбоотой үзүүлэх боломжтой болсон.

Иймд тус яамнаас Хамтарсан баг, анхан шатанд ажилладаг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, Нэг цэгийн үйлчилгээ болон Түр хамгаалах байрны ажилтан албан хаагчдын нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, модулыг боловсруулж, үндэсний түвшинд ажлын байран дахь сургалтыг зохион байгуулаад байна.

Тус сургалтын гарын авлага, модул нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн хохирогч, даван туулагчдад нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөхөд баримтлах зарчим, орчин үеийн чиг хандлагууд, зөвлөгөөнд ашиглах суурь мэдлэг, чадвар, арга техникүүдийг нийгмийн ажил, сэтгэл зүйн шинжлэх ухааны хэрэглээний үүднээс боловсруулагдсан.

Уг сургалтын гарын авлага, модулыг судалснаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зөвлөгч, мэргэжилтнүүд хохирогчийн сэтгэл санааг тайвшруулах, тэдний нөөц боломж, давуу талд суурилан асуудал, бэрхшээлийг даван туулахад дэмжин туслах, цочрол гэмтлээс урьдчилан сэргийлэх, холбон зуучлахад чиглэсэн нийгэм сэтгэлзүйн дэмжлэг бүхий үйлчилгээнүүдийг өдөр тутмынхаа ажлын байранд үзүүлэх чадвартай болох төдийгүй Та бүхний ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү сургалтын гарын авлага, модулыг боловсруулсан зохиогчид болон техникийн зөвлөхүүд, техникийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын санд талархал илэрхийлье.

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Талархал

Монгол улсын хэмжээнд 2019 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 313 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 93 хэргээр буюу 42.3 хувиар өссөн байна. Нийт гэр бүлийн хүчирхийллийн үйлдэгдсэн гэмт хэргээс 43.8 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл, 0.6 хувь нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн байна (ГХУСЗ).

Иймээс хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг дэмжих хэрэгцээ шаардлага улам нэмэгдэж байгаа өнөө үед энэхүү гарын авлага Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны захиалгаар НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зөвлөгч нарт зориулагдан боловсруулагдаж, уншигч таны хүртээл болж байна.

Энэхүү сургалтын гарын авлага, модул нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зөвлөгч нарт жеңдэрт суурилсан хүчирхийлэл, хүчирхийллийн хохирогчийн онцлог шинжийн талаар ойлголт өгөх, хохирогчид зөвлөгөө өгөхдөө зөвлөгчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах, зөвлөгөөний үйл явцад анхаарах асуудлыг тодорхойлох, зөвлөгөөнд ашиглах урлагийн сэтгэл заслын арга, техникүүдийн талаар цогц мэдлэг, чадвар олгох зорилгоор боловсруулагдсан. Хохирогчид зөвлөгөө үзүүлж буй мэргэжилтэн та бүхэн өөрийн арвин мэдлэг, туршлагатайгаа холбон энэхүү сургалтын гарын авлага, модулыг судалж, өдөр тутам үзүүлж буй нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээндээ өргөнөөр ашиглахад тань тус дөхөм болно гэдэгт итгэлтэй байна.

Уг сургалтын гарын авлага, модулыг боловсруулахад үнэтэй санал зөвлөгөө өгч хамтран ажилласан нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зөвлөхүүд, техникийн дэмжлэг үзүүлсэн бүх талуудад талархал илэрхийлье!

Зохиогчид





АГУУЛГА

МОДУЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ	6
МОДУЛЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ.....	6
МОДУЛЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ	7
МОДУЛ 1. Хүчирхийллийн хохирогчийн нийгэм сэтгэлзүйн онцлог	8
1.1 Жендэрт суурилсан хүчирхийлэл, төрлүүд	8
1.2 Хүчирхийллийн хохирогч, хохирогчийн онцлог шинж.....	22
МОДУЛ 2. Нийгэм - сэтгэлзүйн зөвлөгөөний чиг хандлага	29
2.1 Нийгэм сэтгэлзүйн зөвлөгөөний тухай	29
2.2 Зөвлөгчийн ур чадвар, ёс зүй	40
МОДУЛ 3. Хохирогчдод нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй	49
3.1 Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйл явц.....	49
3.2 Хүчирхийллийн хохирогчид урлагийн сэтгэл заслын аргаар зөвлөгөө өгөх	61
3.3 Хүчирхийллийн хохирогчид урлагийн сэтгэл заслын аргаар зөвлөгөө өгөх техникүүд.....	68
3.4 Хүчирхийллийн хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах.....	90
НОМ ЗҮЙ	107



СУРГАЛТЫН МОДУЛЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

- “Сургагч багш “Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтыг явуулахын тулд тус гарын авлагыг уншиж судалсан байх;
- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын модул нь дээрх гарын авлагын агуулга, үзэл санааг хэрэгжүүлэх зорилгоор хийгдсэн учраас оролцогчдод өгөх үндсэн мэдээлэл, гүйцэтгэх дасгал, даалгавруудыг гарын авлагатай уялдуулан хэрэгжүүлэх;
- Гарын авлагын агуулгыг 16 цагийн сургалтын модулд багтаах боломжгүй учраас цагийн багтаамж, дасгал, даалгаврыг нэмэх шинэчлэхдээ гарын авлагад тусгагдсан бусад материалуудыг авч ашиглах боломжийг бүрдүүлэх;
- Сургагч багш тухайн модулыг заахдаа бусад нэмэлт материалуудтай танилцаж, бүтээлчээр хандах;
- Сургагч багш сургалтын арга зүйн талаар мэдлэгтэй байх, сургагчийн үүрэг, ёсзүйг сахин ажиллах талаар анхаарах.

МОДУЛЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Модулын зорилго:

Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөхөд шаардагдах мэдлэг, чадвар эзэмшиж, хохирогчтой ажиллахдаа зөвлөгчийн ёс зүй, зарчмыг мөрдлөг болгон ашиглах, зөвлөгөөний үйл явц, арга зүйд суралцах, дэмжлэг үзүүлэх зорилготой.

Модулаар судлах агуулга:

- Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай ойлголт
- Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд
- Хүчирхийллийн хохирогч, даван туулагчийн эрхүүд
- Нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө
- Зөвлөгчийн ур чадвар, ёс зүй
- Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зүйн зөвлөгөө өгөх үйл явц
- Хүчирхийллийн хохирогчид урлагийн сэтгэл заслын аргаар нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх
- Хүчирхийллийн хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээ

Модулаар эзэмших мэдлэг, чадвар:

- Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх цогц мэдлэгийг эзэмшинэ.
- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх цогц мэдлэгээ хүчирхийллийн хохирогчийн онцлогт тохируулан өдөр тутмын практикт хэрэглэх чадварт суралцана.





Арга зүй:

- Товч мэдээлэл
- Ярилцлага
- Кейс анализ
- Хэлэлцүүлэг
- Оролцооны аргууд

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Зөөврийн компьютер, проектор
- Сургалтын явцад хэрэглэх дасгал, даалгавар
- Цагаан самбар, дэлгэц цаас
- Наадаг өнгийн цаас
- Маркер, өнгийн харандаа
- Модул 3.3-д тусгайлсан хэрэглэгдэхүүн
- Тараах материал

Ашиглах үндсэн гарын авлага:

Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, В.Бэрцэцэг, Д.Амаржаргал (2019) Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй, УБ

Модулын сэдэвчилсэн төлөвлөгөө:

Сэдэв	Цаг
Сургалтын танилцуулга	
МОДУЛ 1. Хүчирхийллийн хохирогчийн нийгэм сэтгэлзүйн онцлог	
1.1 Жендэрт суурилсан хүчирхийлэл, төрлүүд	2
1.2 Хүчирхийллийн хохирогч, хохирогчийн онцлог шинж	2
МОДУЛ 2. Нийгэм - сэтгэлзүйн зөвлөгөөний чиг хандлага	
2.1 Нийгэм сэтгэлзүйн зөвлөгөөний тухай	2
2.2 Зөвлөгчийн ур чадвар, ёс зүй	2
МОДУЛ 3. Хохирогчдод нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй	
3.1 Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйл явц	2
3.2 Хүчирхийллийн хохирогчид урлагийн сэтгэл заслын аргаар зөвлөгөө өгөх	2
3.3 Хүчирхийллийн хохирогчид урлагийн сэтгэл заслын аргаар зөвлөгөө өгөх техникүүд	2
3.4 Хүчирхийллийн хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах	2
Сургалтын дүгнэлт	
Нийт цаг	16



МОДУЛ 1. ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙН НИЙГЭМ СЭТГЭЛЗҮЙН ОНЦЛОГ

СЭДЭВ 1.1 ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ, ТӨРЛҮҮД

Хичээлийн зорилго:

- Жендэрт суурилсан хүчирхийллийн мөн чанар, онцлогийн талаарх ойлголтоо нэмэгдүүлнэ
- Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд, тэдгээрийн ялгааг таньж мэдэх, ойлголт мэдлэгээ бататгана

Үндсэн ойлголтууд:

- Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай ойлголт
- Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд
- Гэр бүлийн хүчирхийллийн динамик шинж
- Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлүүд

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Хэлэлцүүлэг
- Асуулт хариулт

Унших материал:

- Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй сургалтын гарын авлага, Бүлэг I
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 он (<https://www.legalinfo.mn/>)

Хэрэглэгдэхүүн:

- Тараах материал 1. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэгдсэн баримт бичиг (цаашид Хуулийн түүвэр гэнэ)
- Тараах материал 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017





ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ, ТӨРЛҮҮД

Хүчирхийлэл гэдэг нь¹ бусад хүн, бүлэг хүний эсрэг амь насыг нь хохироох, хэвийн хөгжилд нь саад болох, бие махбод, сэтгэл санааны гэмтэл учруулах эрсдэлтэй байдлаар биеийн хүч юм уу эрх мэдлийг санаатайгаар ашиглах юм уу ашиглахаар заналхийлэх үйлдэл гэж тодорхойлдог.



Жендэрт суурилсан хүчирхийлэл

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах хорооноос эрхлэн гаргасан 19 дүгээр зөвлөмжид ЭАҮБХУТК-д тусгасан ялгаварлан гадуурхах бүх хэлбэр бол жендерт суурилсан хүчирхийлэл мөн гэж үзсэн.

Европын Зөвлөл нь (2012 он) жендерт суурилсан хүчирхийллийг тухайн хүний хүйстэй нь холбон түүнд чиглүүлэн хүчирхийллийн үйлдэл хийх, энэ нь тухайн хүний үндсэн эрх, эрх чөлөө болох амьд явах, аюулгүй амьдрах, хүний мөн чанарыг хүндэтгэх, эрэгтэй, эмэгтэй аливаа этгээдийн эрх тэгш байдал, бие махбод болон оюун санаа, сэтгэл зүйн бүрэн бүтэн байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байх үндсэн эрхүүдийг зөрчихтэй холбон тайлбарласан.

Истанбулын конвенц (Европын зөвлөл, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай конвенц) нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бие махбод, бэлгийн, сэтгэл зүйн болон эдийн засгийн гэсэн үндсэн 4 хэлбэртэй болохыг тодорхойлсон.

Монгол Улсад 2011 онд батлагдсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль анх удаа “жендерт суурилсан хүчирхийллийг” тодорхойлсон байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тодорхойлсноор жендэрт суурилсан хүчирхийлэл нь жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэл юм.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд хүйсээс нь шалтгаалан нийгмээс оноосон, хуваарилсан үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурийн талаарх хүлээлт, хандлага, шахалтад үндэслэн үйлдэгддэг. Хянах, эрх мэдлээ мэдрэхийн тулд хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, хянах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх зэрэг ямар ч аргаар үйлдэгдэж болох ба зовуурь шаналал, хор хохирол учруулах буюу учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэл юм.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба бусад төрлийн хүчирхийлэлтэй холбоотой (эрэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй гэх мэт).

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хувийн харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, сургуулийн орчинд, гудамж талбай зэрэг нийгмийн бүхий л хүрээнд, үйлдэгдэж, нийгмийн бүх анги, давхаргын дунд тохиолддог.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч өртөж болох ч ихэвчлэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж, гэр бүл, хамт олон, нийгэмд далд, нуугдмал байдлаар оршиж байдаг.

¹ Krug E, Dahlberg L, Mercy J, Zwi A, Lozana R (2002). World report on violence and health. Geneva: World Health Organization



Жендэрт суурилсан гэж тодотгохын учир²

Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд нийгмээс оноосон үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь, хүлээлтийг тодорхойлж, тэдний хувьд “зөв”, “зүйтэй” хэмээн тооцогдох зан үйл, юу хийж болох, болохгүйг тулгаж, хүлээлт, хандлага, шахалт үүсгэдэг ба түүн дээр үндэслэн үйлдэгддэг учраас жендэрт суурилсан хүчирхийлэл гэж нэрлэгддэг. Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалд үндэслэгдсэн байдаг ба суурь шалтгаан нь жендэрээс үүдэлтэй эрх мэдлийн тэнцвэргүй байдал юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хувийн, ойр дотнын харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, боловсролын орчинд, гудамж талбайд, ер нь нийгмийн бүхий л хүрээнд үйлдэгддэг. Эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа суурь шалтгаан нь учраас ихэвчлэн эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэгддэг. Нийгэмд хэвийн үзэгдэл болтлоо хүлээн зөвшөөрөгдөж, нийгэмд тогтсон хэм хэмжээ, хүмүүсийн үзэл хандлагаар дэмжигдэж байдаг. Жендэрт суурилсан хүчирхийлэлд олон хүчин зүйл нөлөөлдөг, тэдгээр хүчин зүйлс нь давхацдаг, өөр, өөр нөхцөлд янз бүрээр илэрдэг, олон талт асуудал юм. Энэ нь амьдралын турш тохиолдож болох ба амьдралын аль мөчлөгт тохиолдож болохоос шалтгаалан өөр өөр байдаг ч хоорондоо холбоотой.

Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд³

Манай улсад жендэрт суурилсан хүчирхийллийн дараах төрлүүд түгээмэл үйлдэгддэг.

ЖСХ-ийн төрлүүд Тодорхойлолт

Гэр бүлийн хүчирхийлэл	Гэр бүлийн харилцаатай хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ ⁴
Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл	Жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдэд бие махбодын, бэлгийн болон сэтгэлзүйн дарамт учруулсан болон учруулахыг завдах үйлдлийг хэлнэ. Үүнд: хувийн болон олон нийтийн орчинд ийм үйлдэл хийхээр заналхийлэх, хүний эрх чөлөөг хязгаарлах хүч хэрэглэсэн эсвэл шаардсан үйлдлийг багтаана ⁵ .
Бэлгийн хүчирхийлэл	Хүнийг эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ. Үүнд: гудамж, талбайд үйлдэгдэх хүчин, болзооны хүчин, ураг төрлийн хүчин, гэрлэгсдийн хүчин, бэлгийн халдлага зэрэг багтана.
Хүн худалдаалах	Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсвэл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олох зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буй хүлээж авах үйлдлийг хэлнэ ⁶ .
Бэлгийн дарамт (энэ нь боловсролын орчинд, бас ажлын байранд голчлон үйлдэгддэг)	Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл эс үйлдэхүйг хэлнэ ⁷

2 Д.Энхжаргал (2018) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдэд суурь мэдлэг, чадвар олгох сургалтын цөм хөтөлбөр, модуль

3 Д.Энхжаргал (2018) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдэд суурь мэдлэг, чадвар олгох сургалтын цөм хөтөлбөр, Модуль 3. Жендэрт суурилсан хүчирхийлэл

4 МУ, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 2 дугаар зүйл

5 НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал. Нэгдүгээр бүлэг

6 Палермогийн протокол (2000) 3 дугаар зүйл

7 МУ, Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль (2011) 4 дүгээр зүйл





Гэр бүлийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийлэл нь газар зүйн байршил, соёл, шашин шүтлэг, нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамаарах дэлхий нийтийн тулгамдсан асуудал бөгөөд хүний эрхийн хамгийн түгээмэл зөрчлүүдийн нэг юм. Хүчирхийллийн улмаас охид эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох эрхээ бүрэн эдэлж чадахгүйд хүрдэг. Түүнчлэн хүчирхийлэл нь хохирогчийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, зарим тохиолдолд амь насаа алдахад ч хүргэдэг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭХТ), Эмэгтэйчүүдийг Алагчлан Үзэх Бүх Хэлбэрийг Устгах тухай конвенц (ЭАҮБХУТК), Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пакт (ИБУТОУП), Эдийн Засаг болон Нийгэм Соёлын Эрхийн Олон Улсын Пактад (ЭЗНСОУП) гэр бүлийн хүчирхийллээс ангид байх эрх, ялгаварлан гадуурхалгүй эрх тэгш, эрх чөлөөг хангаж байх талаар тусгасан. 1990 оноос эхлэн Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийг Устгах тухай тунхаглал (1993) болон Эмэгтэйчүүдийн Ялгаварлан Гадуурхалтыг Устгах Хороо (1992) нь 19 дүгээр Ерөнхий зөвлөмжөөр⁸ дамжуулан гэр бүлийн хүчирхийллийн асуудалд анхаарлаа хандуулж эхэлсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) 19 дүгээр зөвлөмжид эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах нэг хэлбэр бол гэр бүлийн хүчирхийлэл мөн гэж тусгасан болно.

Гэр бүлийн хүчирхийлэл бол эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хамгийн нууцлаг хэлбэрүүдийн нэг юм. Энэ нь нийгмийн бүх түвшинд тархсан байдаг. Гэр бүлийн харилцааны хүрээнд бүх насны эмэгтэйчүүд уламжлалт хандлагаас үүдэлтэй хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны болон өөр бусад хүчирхийлэлд өртдөг. Эдийн засгийн хараат байдал нь олон эмэгтэйчүүдийг хүчирхийллийн харилцаанд ороход хүргэдэг. Эрчүүдийн зүгээс гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй байх нь хүчирхийлэл, албадлагын нэг хэлбэр байж болно. Хүчирхийллийн эдгээр хэлбэр нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндэд эрсдэл учруулж, гэр бүл, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бууруулдаг.

Ахмад настнуудад гэр бүл болон бусад хүмүүсийн зүгээс хүчирхийлэл дарамт учруулж болно. Ахмад настнуудын хувьд тулгарч буй асуудал бэрхшээл (эрүүл мэнд болон бусдаас авах дэмжлэг хязгаарлагдмал байх гэх мэт)-ээ бие даан шийдвэрлэх боломж нь хязгаарлагдмал байдаг тул тэдний эсрэг үйлдэгдэж буй дарамт хүчирхийллийг таних, шийдвэрлэх нь маш чухал юм. Ахмад настнуудад тулгардаг түгээмэл дарамт хүчирхийлэл нь үл хайхрах (амьдрахад шаардлагатай наад захын хэрэгцээг хангахгүй байх), бие махбодын хүчирхийлэл (алгадах, цохих, үстэх, түлхэх, сэгсрэх гэх мэт), сэтгэл санааны хүчирхийлэл (нэрээр нь дуудах, доромжлох, хараах, заналхийлэх, өрөөнд түгжих, тусгаарлах, бусад хүмүүстэй харилцах боломжийг нь хаах гэх мэт), эдийн засгийн болон материаллаг хэлбэрийн хүчирхийлэл (эд зүйлсийг нь зөвшөөрөлгүй авах, мөнгийг нь өмнөөс нь авах, гарын үсгийг нь хуурамчаар ашиглах, гэрээ хэлцэлд гарын үсэг зурахыг шаардах гэх мэт) зэрэг болно. Түгээмэл тулгардаг эдгээр дарамт хүчирхийллээс гадна дараах төрлийн асуудлууд тохиолдож байдаг. Үүнд: гэр бүлийн хүрээнд тохиолддог, бусдад төдийлөн мэдэгдээд байдаггүй, хүчирхийлэл дарамт тулгарсан тохиолдолд хэнд хандаж, хэрхэн тусламж дэмжлэг авахаа мэдэхгүй байх, нийгмийн харилцаа холбооноос тусгаарлагдмал байдаг тул доромжлогдсон, хүнд нөхцөл байдалд орсон тухайгаа бусдад ярихаас болгоомжлох зэрэг нь хүчирхийлэл дарамт бүхий харилцааг тэвчиж, хүлээн зөвшөөрөхөөс өөр арга замгүй болгодог. Байгууллагын орчинд ахмад настны эсрэг дарамт хүчирхийлэл нь ахмад настны асрамжийн газар, эмнэлэг зэрэг тэдэнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад тохиолддог. Тэдэнд дарамт учруулагчид гэр бүлийн гишүүн, ерөөний хамтрагч болон байгууллагын ажилтнууд байж болно.

⁸ Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, Ерөнхий зөвлөмж 19, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл (11 дүгээр чуулга уулзалт, 1992), НҮБ. Doc. A/47/38 at 1 (1993), дахин хэвлэсэн Хүний Эрхийн Гэрээ Хэлэлцээрийн Газар, НҮБ. Doc. HRI/GEN/1/Rev.6 at 243 (2003), Cit.09/09/2019. Retrieved from <http://www1.umn.edu/humanrts/gencomm/gener119.htm>



Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд бусдаас өөр хүмүүст тулгардаг дарамт, хүчирхийлэл

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд бусдаас өөр хүмүүс мөн дарамт хүчирхийллийн хохирогч болж байдаг. Эдгээр хүмүүст дараах төрлийн хүчирхийлэл дарамт тулгардаг. Үүнд:

- Өөрийнх нь зөвшөөрөлгүй гэр бүл, ажил олгогч болон олон нийтэд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийг нь илчлэх
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийг нь шүүмжлэх, буруутгах
- Бусдад буруу зан үйл сурталчилж байна гэж үзэж ятган үнэмшүүлэх, итгүүлэхийг оролдох
- Өөрийн биеийн хүсээгүй хэсгийн талаар ярих буюу дарамт учруулах
- Гадаад үзэмжээр нь шүүмжлэх буюу бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийг нь өөрчлөхийг ятгах, тулгах

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр⁹

Хэлбэр	Тодорхойлолт
Бие махбодын хүчирхийлэл	Хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, учруулж болзошгүй аливаа үйлдлийг хэлнэ.
Сэтгэл санааны хүчирхийлэл	Хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрийн сэтгэл санааны шаналал үүсгэхийг хэлнэ.
Эдийн засгийн хүчирхийлэл	Хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг хэлнэ.
Бэлгийн хүчирхийлэл	Хүнийг эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

Гэр бүлийн хүчирхийллийн динамик

Гэр бүлийн хүчирхийлэл нь дарамт хүчирхийлэл үзүүлэгчийн зүгээс хохирогчийг эрхшээлдээ оруулах зорилгоор айлган сүрдүүлэх, хүчирхийлэл үйлдэх орчин нөхцөлийг аажмаар бүрдүүлэх цогц, нарийн төвөгтэй харилцаа холбоо болон үйлдлийн шинжтэй байдаг. Нөгөө талаас хохирогчийн хувьд дарамт хүчирхийлэл бүхий харилцаанаас холдох арга замыг олоход хэцүү болсоор байдаг.

Хүчирхийлэл бүхий харилцааны хохирогч хэд хэдэн үе шатыг туулдаг. Энэ нь:

- Хүчирхийлэл үйлдэгчтэй хамт амьдрах
- Хүчирхийлэл бүхий харилцааг орхихын тулд тусламж дэмжлэг эрэлхийлэх
- Хүчирхийлэл бүхий харилцааг орхисны дараах амьдрал

Хүчирхийлэл нь сэтгэл санааны хүчирхийллийн хөнгөн хэлбэрээс эхэлдэг. Энэ үед хохирогч хүчирхийлэл гэдгийг ойлгож ухамсарладаггүй. Дараа нь хүчирхийлэл давтагдах тусам шинж чанарын хувьд илүү даамжирч, бага багаар хүнд нөхцөл байдалд шилждэг. Хохирогч бага багаар дасан зохицож, хүчирхийлэл үйлдэгчийн олон тооны үйлдлүүдийг хүлээн зөвшөөрч эхэлдэг. Хүчирхийлэл нэмэгдэхийн хэрээр хүчирхийлэл үйлдэгчийн эрх мэдэл, хяналтыг мэдрэх хэрэгцээ мөн өсөн нэмэгдэж байдаг.

⁹ Монгол Улсын Гэр бүлийн Хүчирхийлэлтэй Тэмцэх тухай хууль, Нэгдүгээр бүлэг, 6 дугаар зүйл, (2017)





Зарим хүчирхийлэл үйлдэгч хохирогчоос өршөөл эрж, дахин хүчирхийлэл үйлдэхгүй гэж амлалт өгдөг. Энэ үед хүчирхийлэл үйлдэгч анх харилцаа холбоо эхэлж байсан үеийн адил хохирогчид анхаарал халамж тавьж, эелдэг харилцаж эхэлдэг. Хохирогч амлалтад итгэж, уучилдаг учир энэ үеийг “Бал сар” хугацаа гэж нэрлэдэг. Хохирогч хүчирхийлэл дарамт бүхий харилцаа дууссан гэдэгт итгэдэг. Харин зарим хохирогчийн хувьд “Бал сар” гэж байдаггүй бөгөөд тэд хүчирхийлэл дарамт бүхий харилцаанд тогтмол байдаг. Тайван байх хугацаанд хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг өөрчлөгдөнө гэдэгт итгэж, харилцаа холбоогоо хадгалж үлдэхийг хичээдэг. Тогтмол дарамт хүчирхийлэлд байдаг хохирогчийн хувьд хүчирхийлэл ирэхийг хүлээж, айдастай амьдарч, байнгын хяналт, тусгаарлалтад амьдарч дассан байдаг. Үр дүнд нь хүчирхийлэл дарамт бүхий харилцааг орхих чадвар, давуу тал, өөртөө итгэх итгэл нь буурсаар байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлүүд

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн хамтрагчаа бүрэн хяналтдаа байлгах гэсэн хүсэл зорилгын улмаас үүдэлтэй байдаг бөгөөд олон эрсдэлт хүчин зүйл гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлдөг.

Эрсдэл үүсгэгч зарим хүчин зүйлс:

- Хүчирхийлэл бүхий харилцаанд байсан өнгөрсөн үеийн туршлага
- Асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга зам бол дарамт хүчирхийлэл гэсэн итгэл үнэмшил
- Хамтрагчаа өөрийн бүрэн хяналтад байгааг мэдрэх хэрэгцээ шаардлага
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд
- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондох эрх мэдэл, хүчний ялгаатай байдал
- Бусдыг захирах, эрхшээлдээ байлгах гэсэн хандлага
- Хүүхдийг зодож өсгөх нь зөв гэсэн итгэл үнэмшил
- Жендерийн тэгш бус байдал

Гэр бүлийн хүчирхийлэл нь арьсны өнгө, шашин шүтлэг, нийгмийн анги давхаргаас хамаарахгүй ямар ч гэр бүлд тохиолдох боломжтой. Гэхдээ гэр бүлийн хүчирхийлэл тохиолддог гэр бүлийг таньж мэдэх нийтлэг онцлог шинжүүд байдаг. Хүчирхийлэл үйлдэгчийн үндсэн хоёр хэв шинж нь өндөр хяналтаа тогтоох болон дарамт бүхий харилцаа байдаг. Эдгээрээс гадна ийм гэр бүлд тохиолддог дараах хэдэн хэв шинжүүд байдаг. Үүнд:

- Тухайн гэр бүл тусгаарлагдмал, бусадтай харилцаа холбоо бага буюу нийгмийн сүлжээ нь хөгжөөгүй байдаг. Гэр бүлийн гишүүд найз нөхөд, хамаатан садан, хөршүүдтэйгээ хамт цагийг өнгөрүүлээд байдаггүй.
- Хамтран амьдрагчийн зүгээс өндөр хяналтад (бие махбод, сэтгэлзүй, санхүүгийн хувьд) байдаг.
- Хүчирхийллийн хохирогч дарамт хүчирхийлэл бүхий харилцааг үгүйсгэх, хүчирхийллийг бууруулахыг хичээх, хүлээн зөвшөөрөх зэргээр даван туулах харилцан адилгүй стратеги ашигладаг.
- Хурцадмал, түгшүүртэй уур амьсгал ноёлсон байдаг.



Тараах материал 1.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ЧИГЛЭГДСЭН БАРИМТ БИЧИГ (Хуулийн түүвэр)

Нэр	Тайлбар	ЖСХ-тэй тэмцэхэд чиглэгдсэн байдал
<p>Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ-1948)</p>	<p>ХЭТТ нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, хүний суурь эрхийг бүх нийтээр хамгаалахад үйлдсэн анхны баримт бичиг мөн. Энэ бол гэрээ биш, заавал даган мөрдөхгүй, гэхдээ олон улсын хуульчдын үзэж байгаагаар энэ нь олон улсын зан заншлын хэм хэмжээний хуулийн нэг хэсэг болжээ.</p>	<p>ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦУУД</p> <p>2 дугаар зүйл Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.</p> <p>4 дүгээр зүйл Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.</p> <p>5 дугаар зүйл Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.</p> <p>16 дугаар зүйл 16(б) 2. Нөхөр, эхнэр болох хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно.</p> <p>26 дугаар угаар зүйлийн 26 (1) Хүн бүр сурч боловсрох эрхтэй.</p>
<p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТТЭОУП-1976)</p>	<p>ИБУТЭОУП нь иргэний болон улс төрийн багц эрхүүдийг агуулдаг. Үүний "сөрөг эрх" гэж зарамдаа нэрлэдэг. Засгийн газар нь ИБУТЭОУП тусгасан эрхийн хангалтыг хүндэтгэх (эрхийг зөрчихгүй), хамгаалах (бусад нь зөрчихийг хориглох) үүрэгтэй.</p>	<p>2 дугаар зүйл 1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.</p> <p>6 дугаар зүйл Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй.</p> <p>7 дугаар зүйл Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно.</p> <p>8 дугаар зүйл 8 (1) Хэнийг ч боол болгож болохгүй; аливаа төрийн боолчлол болон боолын худалдааг хориглоно. 2. Хэнийг ч бусдын эрхшээлд байлгаж болохгүй. а) хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэх буюу заавал ажилд тулгаж болохгүй.</p> <p>9 дугаар зүйл Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй.</p> <p>23 дугаар зүйл 23 (3) Гэрлэгчид өөрсдөө чөлөөтэй бөгөөд харилцан бүрэн зөвшөөрөлцөөгүй аливаа гэрлэлт байж үл болно.</p>
<p>ИБУТЭОУП-ын Ерөнхий дүгнэлт 28 (2000)</p>	<p>Хүний эрхийн хороо нь ИБУТЭОУП-ын 3-р зүйлийг (эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг хангах) тайлбарлах, тодруулах, өргөжүүлэх зорилгоор Ерөнхий дүгнэлт 28 -ыг гаргажээ.</p>	<p>Дотоодын болон олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед ялангуяа эмэгтэйчүүд эмзэг байдалд ордог. Оролцогч улсууд эдгээр нөхцөл байдалд эмэгтэйчүүдийг хүчин, хулгайлах болон жендэрт суурилсан бусад хүчирхийллээс хамгаалахад авсан бүх арга хэмжээний талаар Хороонд мэдээлж байх ёстой "(Хуудас 8).</p>





<p>ЭЗНСӨУП нь эдийн засаг, нийгэм, соёлын багц (амьдралын чанар илэрхийлсэн) эрхүүдийг агуулдаг. Төрийн бодлого, нийгмийн хөтөлбөрөөр дамжуулан тодорхой үүргийг биелүүлэх засгийн газрын үүрэг хариуцлагыг хэлдэг тул эдгээр эрхүүдийг заримдаа "эрэг эрх" гэж нэрлэдэг.</p>	<p>2 дугаар зүйлийн 2(2) Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчлахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй.</p> <p>3 дугаар зүйл Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцлийг хангах үүрэгтэй.</p> <p>10 дугаар зүйлийн (1) Гэрлэгсэд чөлөөтэй, харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гэрлэнэ.</p> <p>12 дугаар зүйлийн (1) Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө.</p> <p>13 дугаар зүйлийн 13(1) Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. These rights are sometimes referred to as "positive rights" because they refer to governments' responsibility to fulfill certain obligations through public policy and social programmes</p>
<p>Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСОУП-1976)</p>	<p>Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (ЭАБХУИК-1981)</p> <p>ЭАБХУИК-ийг Эмэгтэйчүүдийн конвенц гэдгээр танигдсан бөгөөд иргэний болон улс төр, эдийн засаг болон нийгэм соёлын эрхийн хүрээнд эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах асуудлыг таслан зогсоох чиг үүрэгтэй. Энэхүү конвенц нь <i>de jure</i> (албан ёсны бичгээр үйлдсэн хууль тогтоомж) ба <i>de facto</i> (хуулийн тайлбар, хэрэгжилт) хооронд жендэрийн ялгаварлан гадуурхалтын ялгаатай байдлыг тусгасан бөгөөд зөвхөн хуулийг өөрчлөх нь ялгаварлан гадуурхалтыг зогсооход хангалтгүй байж болохыг зарласан. ЭАБХУИОУК-н эх хувьд ЖСХ-н асуудлыг тодорхой тусгаагүй ч уг конвенцын хэд хэдэн зүйлд ЖСХ-ийн хэлбэрүүдийг тусгасан.</p>

ийл өлрө хөлө өөлөө нийлүүлс-мэлийн
гн-годох нийллийнх

<p>ЭАБХУТК-ийн Ерөнхий Зөвлөмж 12 "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл" (1989)</p>	<p>ЭАБХУТК-ийн 2, 5, 11, 12, 16-р зүйл эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй шууд холбоотойг Ерөнхий тайлбар 12-т онцолж өгчээ.</p>	<p>"... Конвенцын 2, 5, 11, 12, 16-р зүйлд Эмэгтэйчүүдийг гэр бүл, ажлын байр эсвэл бусад нийгмийн амьдралын хүрээнд гарч буй аливаа хүчирхийллээс хамгаалах арга хэмжээ авахыг оролцогч улс орнуудад үүрэг болгосон.</p>
<p>ЭАБХУТХ Ерөнхий Зөвлөмж 19</p>	<p>Ерөнхий Тайлбар 19 нь ялгаварлан гадуурхалтыг илүү өргөн хүрээнд тодорхойлон тайлбарласан бөгөөд үүнийг ЭАБХУТХ болон өөр бусад олон улсын хуульд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эх сувалж болж өгдөг байна.</p>	<p>Энэхүү Ерөнхий тайлбар нь дараах зүйлсийг уриалж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн улс хүчирхийллийн асуудлаар зохих хариу тайлбар өгөх үүрэгтэй (хүчирхийллийн хэргийг хянан мөрдөн шалгах ажиллагаа хийгээгүй тохиолдолд) - Хүчирхийлэл хувь хүнд хувийн хэвшлийн салбарт байгаа эсэхийг төр хариуцна. - ЖСХ-ийн даван туулагчдад урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, нөхөн төлбөр авах эрхийг нь хангах - Хүчирхийлэл үйлдсэн бол төр болон бусад хэвшлүүдэд хариуцлага оногдуулах шийтгэх, арилгах үүрэг хүлээсэн
<p>Хүүхдийн эрхийн тухай конвенци (ХЭТК, 1990)</p>	<p>ХЭТК нь 18 нас хүрээгүй хүүхдийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, эрүүл мэнд, соёлын эрхүүдийг хамарна.</p> <p>Түүнчлэн, охид, хөвгүүд янз бүрийн хүчирхийлэлд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, засгийн газарт нөхөн сэргээх, нийгэмшүүлэх хөтөлбөр төлөвлөх үүрэгтэй.</p>	<p>9дүгээр зүйл Оролцогч улсууд ... хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг эхээс нь салгахгүй байх үүрэг хүлээнэ.</p> <p>12 дугаар зүйлийн 12 (1) Оролцогч улсууд өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө.</p> <p>19 дүгээр зүйл 1. Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран халамжлагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.</p> <p>24 дүгээр зүйлийн 24(3) 3. Оролцогч улсууд хүүхдийн эрүүл мэндийг хохироох уламжлалт дадлыг устгах зорилгоор үр нөлөөтэй бөгөөд зохистой бүх арга хэмжээг авна.</p> <p>34 дүгээр зүйл Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна:</p> <p>35 дугаар зүйл Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна.</p> <p>37 дугаар зүйл Оролцогч улсууд: (а) хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх;</p> <p>39 дүгээр зүйл Оролцогч улсууд хүүхдийг үл хайхрах, мөлжих, зүй бусаар ашиглах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага, зэвсэгт мөргөлдөөний хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөлд хэрэгжих ёстой.</p>



<p>Ромын Дүрэм бол Олон Улсын Эрүүгийн Шүүх байгуулах тухай гэрээ юм. Уг шүүх нь нэг буюу хэд хэдэн гэмт хэрэг болох геноцид, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдаж байгаа хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх юм.</p> <p>Олон улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм (2002)</p>	<p>7 дугаар зүйлийн “Энэхүү Дүрмийн зорилгоор “хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг” нь энгийн аливаа хүмүүст өргөн хүрээтэй буюу байнга халдах байдлаар санаатай үйлдэж байгаа дараах үйлдлийн аль нэг болно: (g) хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, биеэ үнэлэхэд тулган хавчих, албадан жирэмслүүлэх, хүчээр засаж хөнгөлөх буюу адилтган үзэж болох бусад хүнд хэлбэрийн бэлгийн аливаа хүчирхийлэл;</p> <p>1 дүгээр бүлэг 1. Энэхүү Конвенцын зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.</p> <p>Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц нь харгис хэрцгий хандах хандлагыг хориглодог. Хүний эрхийн байгууллагууд ЖСХ-ийг зарим төрлийг эрүүдэн шүүхийн тодорхойлолтод багтах эсэх талаар маргаантай хэвээр байгаа.</p> <p>Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987)</p>
---	---

ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	
Үндсэн хууль	<p>Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй иргэд түүнийг баталгаатай эдлэх тогтолцооны үндсийг тавьсан.</p> <p>16 дугаар зүйлийн 11 дэх хэсэг “үлс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн нь эрх тэгш байдлыг хангах</p> <p>16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг “эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...хууль зүйн туслалцаа авах... шударга шүүхээр шүүлтэх” нь хамгаалалтын арга хэмжээг хангах,</p> <p>19 дүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх” үүргийг иргэнийхээ өмнө хариуцах үүргийнхээ дагуу, ялангуяа жендэрийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчийн сэтгэлзүйд учирсан хохирлоо арилгуулах эрхийн үндэслэл эрх зүйн суурь тавигдсан юм.</p> <p>4.1.1. “жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;</p> <p>4.1.2. “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;</p> <p>4.1.4. “жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг;</p> <p>4.1.8. “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг;</p>
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	<p>Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаас гадна жендэрийн хамрах хүрээ, жэндэрт суурилсан хүчирхийл, ялгаварлан гадуурхалтыг хорьсон.</p>
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	<p>5 дугаар хэсэг (5.1.1) “гэр бүлийн хүчирхийлэл” гэж (3.1.1) эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, (3.1.2) тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү эсвэл (3.2) гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарах ба хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг;</p> <p>(5.1.2) “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл тогтолцоо, үйл ажиллагааг хангах юм.</p>





<p>Эрүүгийн хууль</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь гэмт хэрэг гэж тооцон жэндерт суурилсан хүчирхийллийг эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эсрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага ногдуулна.</p>	<p>11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл үйлдэх</p> <p>1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:</p> <ol style="list-style-type: none"> 1.1. зодсон; 1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <p>2. Энэ гэмт хэргийг:</p> <ol style="list-style-type: none"> 2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; 2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; 2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
<p>Зөрчлийн тухай хууль</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл хүний эрхийн ноцтой зөрчил учир гэмт хэрэгт тооцсон. Гэмт хэрэгт тооцогдохооргүй үйлдлүүдийг захиргааны зөрчил гэж үзсэн юм.</p>	<p>5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих</p> <p>1. Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2. Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3. Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:</p> <ol style="list-style-type: none"> 4.1. зодсон; 4.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албасан; 4.3. бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна. <p>Тайлбар: Энэ хуулийн тусгай ангид заасан “хууль зөрчих” гэж Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгоно.</p>

Гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, тусалцаа үзүүлэх асуудлыг зохицуулах юм.

7 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

- 7.1.1. урьдчилан сануулах;
- 7.1.2. тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 7.1.3. биечилсэн хамгаалалт;
- 7.1.4. мэдээллийн нууцлалыг хангах;
- 7.1.5. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;
- 7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;
- 7.1.7. нүүлгэн шилжүүлэх;
- 7.1.8. баримт бичгийг солих;
- 7.1.9. гадаад төрхийг өөрчлөх.
- 7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
- 7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

17 дугаар зүйл. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

- 17.1. Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.
- 17.2. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:
 - 17.2.1. гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;
 - 17.2.2. гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;
 - 17.2.3. шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;
 - 17.2.4. шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;
 - 17.2.5. шаардлагатай бусад арга хэмжээ.
- 17.3. Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх тусалцаа

- 18.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах тусалцаа үзүүлж болно:
 - 18.1.1. хууль зүйн тусалцаа;
 - 18.1.2. сэтгэл зүйн тусалцаа;
 - 18.1.3. эрүүл мэндийн тусалцаа.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль 2013,





<p>Иргэний хууль</p>	<p>Иргэний журмаар хамгаалалт авах тухай нэхэмжлэл, хүсэлт, гомдлоо иргэний шүүхэд гаргах эрхтэй.</p> <p>230 дугаар зүйлийн 230.2. Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.</p> <p>511 дугаар зүйлийн 511.1. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.</p> <p>511 дугаар зүйлийн 511.2. Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.</p> <p>Иргэний шүүх хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног дотор шийдвэрлэнэ. Иргэний журмаар олгогдсон хуулийн хугацаа хэт удаан буюу амиа алдах гэмтэж бэртэх эрсдэл үүсэх боломжтой.</p>
<p>Гэр бүлийн тухай хууль</p>	<p>30 дугаар зүйл. Эцэг, эх байх эрх хасах</p> <p>30.1. Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасах болно.</p> <p>30.2. Эцэг, эх байх эрх хасуулах тухай нэхэмжлэлийг эцэг буюу эх нь, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага тухайн эцэг, эхийн оршин суугаа газрын шүүхэд гаргах эрхтэй.</p> <p>30.3. Эцэг, эх байх эрх хассан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор шүүх улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад явуулна.</p> <p>32 дугаар зүйл. Эцэг, эх байх эрхийг сэргээх</p> <p>32.1. Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний эцэг, эх байх эрхээ сэргээх тухай хүсэлтийг шүүх хянан үзэж, эцэг, эх байх эрхийг хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс сэргээж болно.</p> <p>32.2. Хүүхэд үрчлэгдсэн бол эцэг, эх байх эрхийг сэргээхгүй.</p> <p>32.3. Эцэг, эх байх эрх сэргээх нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшилж байгаа нь тогтоогдсон бол энэ хуулийн 30.1-д заасны дагуу эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний эцэг, эх байх эрхийг шүүх нь долоон нас хүрсэн хүүхдийн саналыг харгалзан сэргээхгүй байж болно.</p>

СЭДЭВ 1.2 ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ, ХОХИРОГЧИЙН ЭРХҮҮД

Хичээлийн зорилго:

- Хүчирхийллийн хохирогч, даван туулагчийг тодорхойлох мэдээлэлтэй болно.
- Хүчирхийллийн хохирогчийн эрхийн талаар мэдлэгтэй болно.
- Хүчирхийллийн хохирогчийн нийгэм-сэтгэлзүйн онцлогийн талаар ойлголттой болно.

Үндсэн ойлголтууд:

- Хохирогч уу, даван туулагч уу
- Хүчирхийллийн хохирогч, хохирогчийн эрхүүд
- Хүчирхийллийн хохирогчийн нийгэм сэтгэл зүйн онцлог, илрэх шинж тэмдэг

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Бүлгээр ажиллах арга
- Кейс дүн шинжилгээ
- Хэлэлцүүлэг

Унших материал:

- Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй гарын авлага, бүлэг I

Хэрэглэгдэхүүн:

- Тараах материал 1: Хохирогчийн эрхүүд (хуудас 24)
- Тараах материал 2: Хохирогчийн нийгэм сэтгэлзүйн онцлог, гарах өөрчлөлтүүд (хуудас 26,27)
- Дэлгэц цаас, маркер





ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ, ДАВАН ТУУЛАГЧ

... Хохирогч уу эсхүл даван туулагч уу?

Хувь хүн хүчирхийлэл, заналхийлэлд өртсөн бол тэдгээр хүмүүсийг гэмт хэргийн “хохирогч” гэсэн нэрээр томъёолдог байна. Жишээлбэл “Хохирогч” гэж “гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсэн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ” гэсэн тодорхойлолтыг 1985 оны НҮБ-ын Ерөнхий Асамблейн 40/43 тогтоолоор баталсан “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай тунхаглал”- д нарийвчлан тусгаж өгсөн ба Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрмийн¹⁰ заалтуудад болон практикт өргөн хэрэглэдэг байна.

Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг иргэний байгууллага, идэвхтнүүд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд охидыг “хохирогч” гэхээсээ илүү “даван туулагч” гэсэн нэр томъёо ашигладаг нь хүчирхийллийн гэмт хэргийн эсрэг сөрөн зогсож чадсан хүмүүсийг хэлж байгаа юм. Тэдгээр хүмүүс тайлбар хийхдээ “хохирогч” гэдэг томъёо нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрсөн, иргэний идэвхгүй байдлыг илэрхийлсэн үг юм гэж үздэг. Зарим тохиолдолд энэ хоёр нэр томъёог хоёуланд нь ашиглахад зохимжтой ч гэж үзсэн байна. Яагаад гэвэл “Даван туулагч” бол тэрхүү хүчирхийллийг давж гарсан хувь хүний ялалт, харин “Хохирогч” гэдэг нь тогтолцооны гажуудал буюу жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн нэр томъёо юм гэжээ.¹¹

Харин бид сургалтын энэхүү гарын авлагын хүрээнд Монгол Улсын Эрүүгийн Хэрэг Хянан Шийдвэрлэх тухай хуулийн (ЭХХШТ) 8 дугаар бүлгийн (8.1) болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 5 дугаар зүйлийн (5.1.2)- т тусгасан хуулийн нэрээр “хохирогч” гэсэн нэр томъёог цаашид хэрэглэх болно.

ЭХХШТ хуулийн 8 дугаар бүлгийн 8.1-т “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ”

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн (5.1.2) “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг” хэлнэ гэжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрх

Гэр бүлийн хүчирхийлэл бол хүний эрхийн ноцтой зөрчил мөн. Иймд Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхүүд, түүний дотор хүүхэд эмэгтэйчүүдийн халдашгүй эрхүүдийг эдлэхийн зэрэгцээ хуулийн тусгай хамгаалалт, нэмэлт эрхийг эдэлдэг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах баталгааг Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1976), Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт (1976), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990) зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт тусгаж өгсөн. Манай улс эдгээр гэрээ конвенцод нэгдэн орсон учраас хохирогчийн эрхийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн.

¹⁰ Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрэм, Дөрөвдүгээр хэсэг, 43 дугаар зүйл, (2002).

¹¹ Рахила Гапта, (2016, 6 сарын 16). Хохирогч уу Даван туулагч уу: феминизм түүний хэл зүй www.opendemocracy.net Cit.08/20/2019. Retrieved from <https://www.opendemocracy.net/en/5050/victim-vs-survivor-feminism-and-language/>



Монгол улсад Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүмүүс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹² (8.2), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд¹³ (3.2) заасан хохирогчийн адил эрх, үүрэг, хариуцлага эдэлнэ. Үүнээс гадна Гэр бүлийн хүчирхийлэлтТТ хуулийн хүрээнд энэ хэргийн онцлог шинж тэмдэгт тулгуурлан дараах нэмэлт эрх эдлэхийг заасан.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрх

Нэн тэргүүнд эдлэх эрх

- Цагдаагийн байгууллага болон ойр байгаа бусад хүмүүсээс тусламж авах эрх
- Эрүүл мэндийн шуурхай үйлчилгээ авах эрх
- Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх
- Сэтгэлзүйн үйлчилгээ авах эрх
- Хүчирхийлэгчтэй уулзахгүй байх эрх
- Мэдээллийн нууцлалтай байх эрх
- Байршлаа бусдад мэдэгдэхгүй байх эрх
- Хамгаалалтын арга хэмжээг сонгон авах эрх. Үүнд:
 - Аюулгүй байдлын хамгаалалт авах эрх
 - Сэтгэл зүйн хамгаалалт авах эрх
 - Аюулгүй газар түр байрлуулах эрх
 - Хүчирхийлэгчийг нүүлгэн шилжүүлэх, саатуулах, баривчлуулах эрх
 - Хүчирхийлэгчид зохих хариуцлага тооцуулах эрх

Дунд хугацааны үед

- Эрх зүйн зөвлөгөө, хууль зүйн туслалцаа авах эрх
- Хохирогчоор тогтоолгох эрх
- Нэхэмжлэгчээр тогтоолгох эрх
- Аюулгүй байдал эрсдэлийн үнэлгээ хийлгэх эрх
- Сэтгэл санааны хохирлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх эрх
- Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангуулах эрх
- Биечилсэн хамгаалалт хүсэх эрх
- Хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах эрх
- Хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэл авах эрх
- Шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх эрх
- Шүүх хуралдааны танхимд сэтгэл зүйчтэй хамт байх эрх
- Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйл өөрчлөх сургалтад хамруулах эрх
- Гэмт этгээдээс байрыг орхихыг шаардсан тогтоол хүсэх эрх

Урт хугацааны үед

- Хохирол арилгуулах эрх
- Нөхөн төлбөр авах эрх
- Гэрлэлтээ цуцлуулах эрх
- Нийгмийн халамж, тэтгэмж авах эрх
- Баримт бичгийг солих эрх
- Гадаад төрхийг өөрчлөх эрх

12 Төрийн мэдээлэл эмхтгэл, № 23, (2017)

13 Төрийн мэдээлэл эмхтгэл, №24, (2017)



“Дэмжлэг, нийгмийн сүлжээ нь хохирогчийг хүчирхийлэл дарамт бүхий харилцааг орхих шийдвэр гаргахад чухал нөлөөтэй байдаг”

Хүчирхийлэл үйлдэгчийг орхиж, харилцаа холбоогоо төгсгөх нь ихэнх тохиолдолд хэцүү байдаг. Энэ тохиолдолд сэтгэлзүй, сэтгэл хөдлөл, зарим тохиолдолд бие махбодын хувьд хохирол амсах эрсдэл ч үүсдэг байна. Дарамт хүчирхийлэл үйлдэгч хүүхдэд халдаж эхлэх үед эсвэл хүүхдүүд нь том болж биеэ даах үед зарим эмэгтэйчүүд хүчирхийлэл бүхий харилцааг орхидог. Хүчирхийлэл бүхий харилцааг орхих нь үнэндээ аюултай нөхцөл байдлыг үүсгэдэг бөгөөд хохирогч эмэгтэйчүүдэд алдах зүйл үлдээгүй гэсэн мэдрэмж үлдэх үед тэд амьдралаа эрсдэлд оруулж, энэхүү замыг сонгосон байдаг.

Судалгаагаар хохирогч эмэгтэйчүүд бие махбодын хувьд ихээхэн хэмжээний гэмтэл бэртэл авч, амиа хорлох оролдлого хүртэл хийсэн байдаг. Хохирогч өөрийг нь орхиж явахыг хүчирхийлэл дарамт үйлдэгч мэдсэн бол хохирогч илүү их эрсдэлд ордог.

“Хохирогч хамт амьдрахаа больсон ч хүчирхийлэл дарамт үйлдэгчийн дарамт, заналхийлэл үргэлжилсээр байдаг”

Хууль эрх зүйн харилцаа үргэлжлэх (өмч хөрөнгө хуваах асуудлаар гэх мэт) үед, хүүхдийн асуудлаар хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч хоорондоо харилцааг байх үед хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн амьдралд сөрөг нөлөө учруулсаар байдаг. Түүнийг айлгаж, сүрдүүлэхийн тулд хуулийн дагуу болон бусад хэлбэрийн дарамтыг учруулсаар байдаг.

“Зарим хохирогч эргээд хүчирхийлэл үйлдэгч болдог”

Хүчирхийлэл бүхий харилцааг орхисны дараа зарим хохирогч тулгарч болох зүйлсээс айх, тулгарч болох тодорхойгүй нөхцөл байдалд дасан зохицох итгэл дутагдсанаас эргээд хүчирхийлэл үйлдэгчтэй хамт амьдарч эхэлдэг. Түүнчлэн хэсэг хугацаа өнгөрсний дараа эргээд дарамт хүчирхийлэл бүхий харилцаа эхэлдэг. Хохирогч зөвлөгчөөс болон бусад хүмүүсийн зүгээс дахин дэмжлэг хүлээн авахаас санаа зовоходоо тусламж авахаас татгалздаг.

Хохирогчийн сэтгэцийн үйлийн онцлогийг тодорхойлох ерөнхий ангилал¹⁴

Хохирогчийн сэтгэцийн процессуудын онцлог	Хохирогчийн сэтгэл зүйн хувийн онцлог	Хохирогчийн сэтгэцийн тухайн үеийн байдал
<p>Танин мэдэх үйлийн онцлог: хүртэхүй, төсөөлөл, ой тогтоолт, анхаарал, сэтгэн бодох үйл, оюун ухааны хөгжлийн түвшин гэх мэт. Хохирогчийн зүгээс өгч байгаа дүгнэлт, эрэгцүүлэлт, хэрэг явдлыг бодитойгоор сэргээн санах, төсөөлөх чадвар, нөхцөл байдалд анализ хийх, эрэгцүүлэх чадвар зэрэг танин мэдэхүйн онцлогууд, оюун ухааны хөгжлийн онцлогуудыг энд багтаан үзнэ.</p>	<p>Мэдрэлийн системийн хэв шинж, темперамент, зан төлөв: Мэдрэлийн системийн хүч, тэнцвэр, уян хатан байдал, гэнэтийн эрсдлийг даах чадвар, ёс суртахуун, ноён нуруу, бусдад болон нийгэмд хандах хандлага, үзэл баримтлал үнэлэмж, баримжаалал гэх зэргийг энд авч үзнэ</p>	<p>Сэтгэлийн хөдөлгөөн, түгшүүр, айдас бачимдал гэх мэт . Хохирогчийн сэтгэл санааны байдал, айдас, түгшүүрийн түвшин, үргэлжилсэн хугацаа, түр зуурын саатал цочирдол гэх зэрэг түр зуурын шинжтэй сэтгэцийн шинж ба байдлуудыг энд авч үзнэ.</p>
<p>Сэтгэцийн эдгээр талууд нь хоорондоо нягт уялдаа холбоотой оршдог</p>		

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн нийгэм-сэтгэлзүйн онцлог

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд илрэх сэтгэл зүйн шинж тэмдэг	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд илрэх бие махбодын шинж тэмдэг
<ul style="list-style-type: none"> • Хэт их санаа алдах • Өөрийгөө буруутгах • Өөрийгөө хэт доогуур үнэлэх • Байнгын айдас түгшүүртэй байх • Хий юм сонсох, харах • Зүүдэндээ цочиж сэрэх • Хэт уйлах • Байнга сандарч тэвдэх • Ой тогтоолт муудах • Сурлагаар хоцрох, сурлагадаа муудах, хичээлдээ дургүй болох • Уур бухимдлаа барьж чадахгүй байх • Эцэг эх, асран хамгаалагч нь орхиод явахаас айх • Эцэг эхийнхээ хэнийг нь сонгохоо мэдэхгүй эргэлзэх • Болсон зүйлээс ичих • Тусгаарлагдаж орхигдсон мэт мэдрэх • Анхаарал халамж шаардах • Сахилгагүй, дүрсгүй болох • Ганцаардах, тусгаарлах • Архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх • Асран хамгаалагч, эцэг эх, найз нөхөд, багш нарынхаа үгэнд орохгүй, дүрсгүйтэх • Цочрол гэмтлийн дараах стресс эмгэгийн шинж тэмдэг илрэх • Сэтгэлээр амархан унах • Стрессийн шинж тэмдэг илрэх • Дасан зохицож чадахгүй байх 	<ul style="list-style-type: none"> • Нойргүйдэх • Хэт их нойртой болох • Хоолны зуршил буурах • Хоолны зуршил ихсэх • Зүрх дэлсэх • Гар салгалах • Булчин чангарах • Булчин сулрах • Толгой өвдөх • Ходоод өвдөх • Шээс хүрэх • Гэдэс базалж өвдөх • Биеийн бүх хэсэг тодорхойгүй өвдөх • Бага насны хүүхэд жингийн дутагдалтай байх • Бусад хүүхэдтэй харьцуулахад өсөлт хөгжлийн хувьд сааталтай эсвэл хоцрогдолтой (жижиг, намхан)

Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй





Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөөр хүүхэд, өсвөр үеийнхэн, насанд хүрэгчдэд гарах үр дагаврууд

Хөгжлийн үе шатууд	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинж тэмдгүүд
Нярай, нялх нас (0-12 сар) Э.Эриксон: Итгэх ба үл итгэх Б.Боулби: Амьд үлдэх Ж.Пиаже: Тархины хөгжил Хүртэх хөдөлгөөний шат	Бие нь өвдөх Унтах цаг нь өөрчлөгдөх Халамж, асрамж дутагдсанаас наад захын хэрэгцээ нь хангагдаагүй Тархины хөгжлийн өөрчлөлт Хөгжлийн хоцрогдолтой болох: Суух, мөлхөх, алхах гэх мэт
Балчир нас (12 сар- 3нас) Э.Эриксон: Тусгаар байдал ба ичих эргэлзэхийн зөрчил Ж.Пиаже: Хүртэх хөдөлгөөн, үйлдэл төлөвшихөөс өмнөх үе	Тархины хөгжлийн хоцрогдол Ярих болон харилцааны ур чадвар тааруу байх Сэтгэл зүйн болон бие махбодын хэвийн үйл ажиллагаа алдагдах Унтах болон бие засахад хүндрэлтэй байх
Сургуулийн өмнөх үе (3-6 нас) Э.Эриксон: Санаачилга ба гэмших буруугаа мэдрэхийн зөрчил Ж.Пиаже: Үйлдэл төлөвшихөөс өмнөх үе	Орилох, хашхирах Бухимдсан, цухалдсан зан авир гаргах Нуугдах Чичрэх Сэтгэл санаагаар унах Бие нь өвдөх Хөгжлийн хоцрогдол Гэр бүлийн асуудлаа өөртөө хамаатуулах
Сургуулийн нас (6-12 нас) Э.Эриксон: Хөдөлмөрлөх дур сонирхол ба дутуу дулимгийн зөрчил Ж.Пиаже:Тодорхой үйлдлийн шат	Үе тэнгийнхэнтэйгээ харилцах, бусад хүүхэдтэй үерхэл нөхөрлөлийн харилцаа тогтоох хүсэлгүй Сурлагаар хоцрох, Сургуулиас айх Бие нь өвдөх Хөгжлийн хоцрогдол Айдас түгшүүртэй болох Маш хүчтэй уурлах Бухимдах, стресстэх
Өсвөр үе (12-17 нас) Э.Эриксон: “Би”-гийн адилтгал ба үүргүүдийн холилдолтын зөрчил Ж.Пиаже: Хийсвэр үйлдлийн шат	Үе тэнгийн харилцаа сул, үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны хүрээ хязгаарлагдмал Асуудлыг шийдвэрлэхдээ хэрцгий түрэмгий байх Бусад руу орилох Бусадтай харилцахдаа айж түгших, Ээждээ худлаа хэлэх, Ээждээ уурлах Болзооны хүчирхийлэл: Гэмт хэрэгтэн, хохирогч Зугтах Гэмт хэрэг үйлдэж болзошгүй зан авиртай байх Хичээл таслах, Сургууль завсардах Мансууруулах бодис хэрэглэх
Залуу насны эхэн үе (18-20 нас) Э.Эриксон: Дотносох ба зожгирахын зөрчил Ж.Пиаже: Хийсвэр үйлдэл, Эцэг эхийн шийдвэр	Үерхэл,болзооны хүчирхийлэл Хүчирхийлэл, дарамттай харилцаа Харилцааны болон гэр бүлийн зөрчил Өрх тусгаарлахтай холбоотой асуудал бэрхшээл Эцэг эх байхтай холбоотой асуудал, бэрхшээл Ажил хөдөлмөртэй холбоотой асуудал бэрхшээл Мансууруулах бодисын хэрэглээ Хүүхэдтэйгээ зүй бусаар харилцах



<p>Насанд хүрсэн үе (20-40 нас) Э.Эриксон: Үр ашигтай ажиллагаа ба зогсонги байдлын зөрчил</p>	<p>Гэр бүл төлөвлөлттэй холбоотой асуудлууд Гэр бүлийн маргаан, зөрчил Гэр бүлийн эдийн засагтай холбоотой асуудлууд Амьдралын хэв маягаас үүдэх асуудлууд Мэргэжлийн өсөлт хөгжлөөс үүдэх асуудал Хүүхэд өсгөх хүмүүжүүлэхтэй холбоотой асуудал Мансууруулах бодисын хэрэглээ Нийгмийн харилцаанаас зугтах, ганцаардах Асуудлыг даван туулахтай холбоотой асуудлууд</p>
<p>Дунд нас (40-60 нас) Э.Эриксон: Үр ашигтай ажиллагаа ба зогсонги байдлын зөрчил</p>	<p>Гэр бүлийн харилцаанаас үүдэх зөрчил Гэр бүлийн бусад гишүүдэд тоогдохгүй байх, ганцаардах Нийгмийн харилцаанд бүрэн орж чадахгүй байх Эрүүл мэндтэй холбоотой асуудлууд Сөрөг сэтгэлийн хөдөлгөөн Амьдралын хэв маяг Бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хүрээнд гарах гэнэтийн өөрчлөлтүүд Архины хэрэглээ</p>
<p>Хижээл нас (60 түүнээс дээш) Э.Эриксон: "Би" -гийн цогцолбор тодрол ба аргаа баран самгардахын зөрчил</p>	<p>Ганцаардах Туулж өнгөрүүлсэн амьдралдаа харамсах Нийгмийн дэмжлэг үгүйлэгдэх Бусдаас хамааралтай болох Бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хүрээнд гарах гэнэтийн өөрчлөлтүүд Архины хэрэглээ</p>





МОДУЛ 2. НИЙГЭМ СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЧИГ ХАНДЛАГА

СЭДЭВ 2.1 НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?

Хичээлийн зорилго:

- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөний орчин үеийн чиг хандлагын талаар мэдлэгтэй болно.
- Сэтгэц нийгэм хоёрын ялгааг таньж мэднэ.
- Нийгэм-сэтгэлзүйн дэмжлэгийн талаар ойлголттой болно
- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөний зарчмыг мэдэж, зөвлөгөөнд ашиглах чадварт суралцана.

Үндсэн ойлголтууд:

- Нийгэм- сэтгэл зүйн зөвлөгөө
- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөний хэлбэрүүд
- Зөвлөгөөний үндсэн зарчмууд
- Зөвлөгчийн үүрэг, үйл ажиллагаа

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Санаа цуглуулах
- Дүрд тоглох
- Хэлэлцүүлэг
- Мэдлэг бататгах асуулт

Унших материал:

- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, Бүлэг II

Хэрэглэгдэхүүн:

- Тараах материал 1: Зөвлөгөөний үндсэн зарчмууд (хуудас 37)
- Тараах материал 2: Зөвлөгчийн үүрэг, үйл ажиллагаа, ёс зүй (хуудас 38, 39)
- Дэлгэц цаас, маркер



НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА

Орчин үеийн зөвлөгөөний чиг хандлага олон хэлбэрээр хөгжиж байна (Bernard, 1994). Энэ чиг хандлагаас тасралтгүй суралцаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлж байх нь зөвлөгчийн нэг гол үүрэг юм.

Хүмүүнлэгийн чиг хандлага

Энэ хандлагын онцлог нь хохирогч өөртөө итгэх итгэлдээ тулгуурлан, өөрийн нөөц боломжийг ашиглан, тулгарч буй бэрхшээлийг өөрөө даван туулах боломжийг олж авахад нь туслахад оршино. Зөвлөгч нь хохирогчид тулгамдсан асуудал бэрхшээлээ шийдвэрлэхэд нь туслах бөгөөд хохирогч өөртөө бий болгосон ур чадвараа ашиглан асуудал бэрхшээлийг шийдвэрлэнэ.

Хүмүүнлэгийн хандлагад суурилж зөвлөгөө өгөхөд анхаарах зүйл:

- Тухайн хүний зан үйлийг "тайлбарлахгүй" байх
- Асуудлыг шийдвэрлэх арга замыг өөрөө олоход нь хохирогчийг идэвхжүүлэх, урамшуулах
- Хүн бүр өөрийн үйл, үйлдлийн төлөө тодорхой хэмжээгээр хариуцлага хүлээдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Зөвлөгч нь хохирогчийг чин сэтгэлээсээ ойлгох, халуун дотно байдал, эерэг сэтгэлгээтэй байх

Психодинамикийн хандлага

Энэхүү хандлагын онцлог нь хохирогчийн сэтгэлийн түгшүүрийг багасгах, асуудлаа даван туулахын тулд оновчтой шийдвэр гаргахад туслахад оршино. Шийдвэр гаргах чадвартай болохын тулд хохирогчийн амьдралын түүхийг нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд энэ нь хохирогчийн одоогийн зан үйлийг ойлгох боломжийг зөвлөгчид олгодог гэж үздэг. Психодинамикийн үүднээс зөвлөгөө өгөх үйл явцыг ямар нэгэн зүйлийг эвлүүлэхтэй адилтгаж болно. Олон жижиг санаа, хэсгүүдийг нэгтгэж нэг бүхэл дүгнэлт гаргана. Практикт Психодинамикийн хандлагад суурилж зөвлөгөө өгөхдөө дараах зүйлийг анхаарна:

- Тухайн хохирогчийн амьдралд тохиолдож байсан болон тохиолдож байгаа (өнгөрсөн ба одоо үеийн) үйл явдлуудын хоорондын харилцаа холбоонд анхаарлаа хандуулах
- Хохирогчийн зан үйлд гэнэтийн ухамсаргүй үйлдлүүд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Хохирогчийн илэрхийлээгүй байгаа далд сэтгэл хөдлөлийг нээхийг хичээх.

Зан үйлийн хандлага

Энэ хандлагын онцлог нь зөвлөгч хохирогчийн өнгөрсөн зовлонт үйл явдлыг аль болохоор бага хөндөж, бага сануулж, харин үүний оронд өмнө нь хохирогчид байгаагүй шинэ зан үйлийг бий болгоход анхаарлаа чиглүүлэхэд оршино. Зан үйлийн хандлагын гол зорилго бол зохисгүй зан үйлийг арилгах, шинэ зан үйлд суралцахад оршино.

Зан үйлийн хандлагыг баримталж зөвлөгөө өгөхдөө:

- Зөвлөгөөний практик зорилго, хүрээг тодорхойлох
- Зан үйлийн хүчин зүйлийн шалтгааныг бус, тодорхой зан үйлийн талаар илүү ярилцах
- Амьдралд тулгарч буй бэрхшээлийг даван туулахын тулд хохирогчийн хийж болох жижиг өөрчлөлтүүдийг тусгасан практик хөтөлбөр боловсруулах





Трансакц хандлага

Хүмүүс бүгд бие биеэсээ ялгагдах өөр өөр «эго»той байдаг. Эдгээр эго төлөвүүдийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Эцэг эх: Эцэг эхийн зан үйл, бодол санаа, хандлагыг тусгадаг бөгөөд шаардлага, шүүмжлэл, үнэлгээ, сайшаал, зэмлэл, анхаарал, халамж, сургамж зэргээр илэрдэг.
- Хүүхэд: Хүүхэд насны туршлага, зан үйл, сэтгэл мэдрэмжийг тусгадаг бөгөөд гэнэн томоогүй зан, бусдаас хараат байдал, өөрт төвлөрсөн сэтгэлгээ зэргээр илэрдэг.
- Насанд хүрэгч: “Энд ба одоо”-д хариулт өгөх зан үйл, бодол санаа, сэтгэл мэдрэмж. Насанд хүрэгчид шаардлагатай мэдээллийг цуглуулж, үнэлж, шийдвэр гаргадаг.

Арт терапи буюу урлагийн сэтгэл засал

Арт терапи буюу урлагийн сэтгэл засал нь сэтгэл заслын нэг хэлбэр болон хөгжиж байсан бөгөөд сүүлийн 50 гаруй жил бие даасан салбар болон хөгжиж байна. Урлагийн сэтгэл засал нь аливаа асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх, асуудалд орсон тохиолдолд хариу үйлдэл үзүүлэх, урлагийн төрөл бүрийн хэлбэр болон хэрэгслүүд, бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан хүний сэтгэл санаа, оюун ухаан, бие физиологийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлдэг мэргэжлийн үйл явц юм.



Урлагийн сэтгэл засал нь гоё сайхан эцсийн бүтээгдэхүүн бий болгох, түр зуур сайхан мэдрэмж төрүүлэх үйл ажиллагаа биш бөгөөд хүний хийж буй бүтээлд хөндлөнгөөс үнэлэлт өгч, оношилгоо хийдэггүй. Гагцхүү хүн өөрийн дотоод сэтгэл, мэдрэмжээ ойлгох, ухаарах, дүгнэлт хийх, асуудлыг олон өнцгөөс харж, шийдвэрлэх гарцыг олж мэдэх боломж олгодог процесс юм. Өөрөөр хэлбэл хүний дотоод сэтгэлийн асуудлыг хэн ч хараад үнэлэлт дүгнэлт өгч, шүүмжилдэггүй. Зөвхөн мэргэжлийн урлагийн сэтгэл засалчтай хамтран ажиллаж байхдаа үйлчлүүлэгч сэтгэл санаа, бие махбод, оюун санааныхаа сайн сайхан байдлыг цогцоор нь хангадаг үйл явц юм.

Урлагийг бүтээлчээр, оновчтой ашиглах нь хүний эрүүл мэндийг бэхжүүлэхээс гадна тэдний амьдралд эерэг нөлөө үзүүлдэг” (Малчиоди, 2012) гэжээ¹⁵. Урлагийн сэтгэл заслын үйлчилгээ нь хүнд асуудал тулгарсан бүх насны хүмүүст тохиромжтой. Бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн хохирогчдод асуудлыг давтан ярихад тун хүндрэлтэй байдаг учир мэргэжлийн хүний хамт урлагийн хэрэгсэлтэй ажиллаж байхдаа өөрийгөө илэрхийлдэг. Ингэснээр аюулгүй, тайван байх, өөртөө төвлөрөх боломж бүрддэг. Тухайлбал биеийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид, аюултай хүчирхийлэлтэй дарамттай орчинд амьдарч байгаа бүх насны хүн ам, ойр дотын хүмүүсээ нэг дор олноор нь алдах, гэнэтийн ослоор дотнын хүнээ алдах зэрэг нөхцөлд энэхүү үйл явдлыг үгээр хэлж илэрхийлэхэд хүнд байдаг.

Олон улсад арт терапи буюу урлагийн сэтгэл заслыг хувь хүн, гэр бүл, байгууллага олон нийттэй ажилладаг дараах байгууллагуудад өргөнөөр ашиглаж байна. Үүнд:

- Өнчин хүүхдийн асрамжийн газар
- Өндөр настны асрамжийн газар
- Тусгай хэрэгцээтэй насанд хүрэгчид, хүүхдийн асрах төв
- Эмнэлэг (гэмтэл, хорт хавдар, хүүхдийн, хөнгөвчлөх, урт хугацааны асаргаа)
- Сургууль, цэцэрлэг
- Хоргодох, хамгаалах байр

¹⁵ В.Бэрцэцэг “ Арт терапи буюу урлагийн сэтгэл засал” 2019 он хуудас 7-10



- Дүрвэгсдийн хуаран
- Гэрийн асаргаа
- Хувийн эмчилгээ
- Нээлттэй урлан
- Хорих, засан хүмүүжүүлэх төв

Сэтгэц нийгмийн хандлага нь:

- Сэтгэц нийгмийн хандлага нь хохирогч, түүний асуудлыг хүрээлэн буй орчинтой нь холбон тайлбарладаг. Нийгмийн орчинд нийгэм, гэр бүл, сургууль, үе тэнгийнхэн орно.
- Сэтгэлзүйн (логик) тал нь мэдрэмж, бодол санаа, зан байдал, сэдэл зэрэг сэтгэцийн үйл явцтай холбоотой байдаг.
- Хохирогчийн асуудалтай нөхцөл байдлыг түүний сэтгэлзүй, нийгэм, соёлын үүднээс судалж, тайлбарлана.
- Хохирогчийн дотоод боломж, чадвар, нийгэм, соёлын нөөц нь асуудлыг шийдэх шийдэл, өөрчлөлтөд нөлөөлдөг.

“Хохирогчийн асуудлыг тодорхойлж буй арга зам нь тухайн Хохирогчид тохирсон зөвлөгөө, үйлчилгээг тодорхойлдог. Зөвлөгч нар заримдаа зөвхөн тухайн хүн, үйл явдал эсвэл асуудал бэрхшээлтэй нөхцөл байдалд анхаарлаа хандуулдаг. Ингэснээрээ бид хохирогчийн мэдрэмж, зан үйл, орчны хүлээлтийг мартаж орхигдуулдаг.”

Сэтгэц нийгмийн үнэлгээний үйл явц:

- a) Шүүмжлэлтэй үйл явдал, стресс, нөхцөл байдал:

Эдгээр нь хохирогчийн амьдралын одоогийн нөхцөл байдалд ноцтой нөлөөлдөг зарим үйл явдлыг хэлдэг. Энэ нь сайн эерэг зүйл, аз жаргалтай нөхцөл байдал байж болно. Ийм тохиолдолд хохирогч эдгээр давуу тал нөхцөлийг ашиглан бэрхшээлийг даван туулж чадна.

- b) Мэдрэмж, зан үйл:

Аз жаргал, уйтгар гуниг, ганцаардал, уур уцаар, нойргүйдэл гэх мэт үйл явдлын дараа хүний үзүүлдэг хариу үйлдлүүд.

- c) Даван туулах зан үйл:


Хүн бие махбод, сэтгэлийн таагүй байдал, хүнд нөхцөл байдалтай хэрхэн харилцах, дасан зохицох, даван туулах үйлдлүүд

- d) Нөөц:

Хэрэгцээтэй болон хямралын үед хүний ашигладаг гадаад дэмжлэгийн тогтолцоог хэлдэг. Нөөц гэдэгт гэр бүл, найз нөхөд, өргөтгөсөн гэр бүл гэх мэт нийгмийн нөөц болон соёлын, оюун санааны нөөц орно (Жишээлбэл, сүмд очих гэх мэт)



Сэтгэц нийгэм гэж юу вэ?¹⁶



Сэтгэц нийгэм гэдэг нь хүмүүсийн амьдралын нийгмийн тал болон сэтгэл хөдлөл хоорондын динамик холбоосыг хэлнэ. Өөрөөр хэлбэл хувь хүний сэтгэл хөдлөлийн үйл явцыг нийгмийн талтай нь холбон тайлбарласан тайлбар юм. Энэ нь нэг талаас хувь хүний Би-үзэл баримтлал, сэтгэл хөдлөлийн өөрчлөлт, нөгөө талаас нийгмийн дадал, зан үйлийн загварын төлөвшил соёлын хамаарлыг авч үздэг.

Сэтгэц нийгмийн дэмжлэг гэдэгт жендэрт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүмүүст сэтгэл хөдлөл болон сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэх үйл явц орно¹⁷.

Сэтгэц нийгмийн сайн сайхан байдал гэж юу вэ?

Сэтгэц нийгмийн сайн сайхан байдал нь цогц ойлголт бөгөөд энэ нь бидний амьдралын туршид сэтгэцийн, сэтгэл хөдлөлийн, нийгмийн, оюун санааны болон бие махбодын тал бүгд бие биедээ харилцан нөлөөлдөг гэсэн үг юм.

Ерөнхийдөө сэтгэц нийгмийн сайн сайхан байдал гэдэгт дараах таван ойлголтыг оруулж үздэг.

1. Бие махбодын сайн сайхан байдал: Энэ бол хамгийн ил тодорхой харагдаж байдаг зүйл. Үүнд бие махбодын болон материаллаг хэрэгцээг хангах асуудал хамрагддаг.
2. Сэтгэцийн эрүүл мэндийн сайн сайхан байдал: Үүнд урам зориг авах, идэвхжүүлэх, шинэ зүйл сурах, сонирхолтой үйл ажиллагаанд оролцох танин мэдэхүйн чадварыг хөгжүүлэх зэрэг орно.
3. Нийгмийн сайн сайхан байдал: Найз нөхөд, хөршүүдтэйгээ хамт байх, олон нийтийн нэг хэсэг байх, шашин шүтлэгтэй байх, соёлын онцлогтой байх, түүнийгээ хадгалах
4. Сэтгэл хөдлөлийн сайн сайхан байдал: Үүнд ямар нэгэн зүйлд итгэлтэй байх, харилцаа холбоотой байх, удирдан чиглүүлэх, өөрийгөө хүндэтгэх, өөртөө итгэх итгэлтэй байх зэрэг орно. Хүчирхийллийн хохирогчдын хувьд өөрсдийг нь хайрлаж, халамжилж, урамшуулж, ойлгож байгаа тохиолдолд сэтгэл хөдлөлийн хувьд сайн дэмжлэг болж өгнө.
5. Оюун санааны сайн сайхан байдал: Оюун санааны эрх чөлөө, олон нийтийн нэг хэсэг нь байх, ирээдүйд итгэх итгэл зэрэг орно.

¹⁶ National guidelines for the provision of psychosocial support for gender based violence victims/survivors 2010

¹⁷ Introduction to Psychosocial Care and Support Training Manual, MGLSD and UNICEF (2015)

Хүмүүсийн сэтгэц, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих хүчин зүйл

- Эрүүл гэр бүл болон олон нийтийн харилцаа холбоо
- Оюун санааны болон шашны үйл ажиллагаанд оролцох, өөрийн гэсэн үүрэгтэй байх
- Харилцааны үндсэн хэрэгцээгээ хангах
- Бие махбодын аюулгүй байдал
- Өөрийгөө мэдрэх, нэр төр, халдашгүй байдал, өөртөө итгэх итгэл
- Бие махбодын сайн сайхан байдал (эрүүл байх)

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдын сэтгэц нийгмийн сайн сайхан байдал нь тэдний бие махбод, нийгэм, сэтгэцийн үйл ажиллагааг тухайн нөхцөл байдалд хөгжүүлэхийн тулд нөхөн сэргээх, хэвийн байдалд оруулахад чиглэнэ. Хамгийн гол нь хохирогчид бие махбодын, сэтгэл хөдлөл, танин мэдэхүйн болон нийгмийн хэрэгцээндээ тулгуурлан нөхөн сэргэх боломжтой байх хэрэгтэй.

Сэтгэц, нийгмийн тусламж, дэмжлэг гэж юу вэ?

Сэтгэц, нийгмийн тусламж, дэмжлэг нь өдөр тутмын амьдрал, гэр бүлд болон олон нийтийн харилцаанд анхаарах зэрэг үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг. Үүнд дараах зүйлс орно:

- Гэр бүлийн орчин дах хохирогчийн туршлага хайр халамж, хамгаалалт
- Хохирогчийн болон гэр бүлийнхнийг асуудлаа даван туулахад туслах нийгмийн зүгээс үзүүлж буй дэмжлэг

Тусламж дэмжлэг нь хохирогчдод өөрийн үнэ цэнийг мэдрэх, чадвартай болох, амьдрах ухааны чадварт суралцах, нийгмийн амьдралд оролцох, ирээдүйд итгэх итгэлийг олж авахад тусалдаг. Энэ нь тулгарч буй бэрхшээлийг даван туулахад тэдний идэвхтэй оролцоог хангах төдийгүй тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд хохирогч болон тэдний асран хамгаалагчдыг чадваржуулахад тусалдаг.

Сэтгэл зүйн үйлчилгээнд дараах зүйл хамаарна.

- Сэтгэл зүйн зөвлөгөө
- Дэмжих бүлэг
- Сэтгэл засал

Сэтгэлзүйн үйлчилгээ нь хохирогчийн өдөр тутмын амьдрал, нийгмийн орчны харилцааг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр юм. Эдгээр нь өдөр тутам тэдний давуу талыг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт эсвэл нэмэлт байдлаар асран хамгаалагчдаар дамжуулан үзүүлж буй тусламж дэмжлэг, сэтгэлзүйн тусламж, үйлчилгээнээс ялгаатай. Зөвлөгөө гэдэг нь ярилцах, сонсох, тусламж үзүүлэх, дэмжих үйл ажиллагааг хамааруулсан ойлголт юм. Судлаач Аллен Е Ивей нар “туслах” гэдгийг зөвлөгөөтэй холбон тайлбарлахдаа “хэн нэгэн хүн нөгөөдөө дэмжлэг үзүүлэхийг хэлнэ” гэсэн байдаг. Тэгвэл “туслах харилцаа” гэдгийг тайлбарлахдаа “хэн нэг нь ярилцах, зөвлөгөө өгөх, сэтгэл засал хийх замаар нэг буюу бүлэг хүнд дэмжлэг үзүүлэхийг хэлнэ” гэжээ. Үүнээс үзэхэд ярилцах, зөвлөгөө өгөх, сэтгэл засал хийх гэх мэт үйлчилгээ нь “туслах” гэсэн нэгэн үгээр илэрхийлэгдэж байна. Хохирогч өөрийн бэрхшээлийг олж тодорхойлоход дэмжлэг үзүүлэх ажлыг “туслах” гэсэн ойлголтод хамааруулна.

Дэмжлэг үзүүлэхийн гол зорилго нь:

- Асуудлаа ойлгох
- Бэрхшээл үүсэхэд нөлөөлж байгаа өөрийн бодол, зан үйл, эсвэл асуудалд хүчтэй нөлөө үзүүлж буй тогтолцоог өөрчлөх оролдлого хийх явдал юм. Энэ ухагдахууны хүрээнд дараах ойлголтыг авч үзнэ. Үүнд:
 - Ярилцлага
 - Зөвлөгөө өгөх
 - Засал хийх





Ярилцлага хийх гэдэг нь мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргах, богино хугацааны уулзалттай холбоотой ойлголт бөгөөд ярилцлагын явцад харилцагч хүнд “жирийн хүн” гэсэн үүднээс хандана. Ярилцлага хийхэд зөвлөгөө өгөхөөс илүүтэй асуулт асууна. Үүнээс хамаарч ярилцлагын үед ярилцлага хийж буй хүн тодорхой хэмжээгээр эрх мэдэл дээгүүр байна.

Зөвлөгөө өгөх гэдэг нь Хохирогч амьдралын асуудлаа өөрөө шийдвэрлэхэд туслахад чиглэсэн “Хохирогчийг чадваржуулах” үйл явцыг хэлнэ. Ярилцлагыг бодвол нэлээд эрчимтэй гүнзгий шинж чанартай үйл явц бөгөөд хохирогчийн хувьд тодорхой зорилго тавьж, түүнийгээ хэрэгжүүлэн өөрийн амьдрах, ажиллах, нийгмийн харилцаанд орох үйл явцаа сайжруулахад тусална.

Сэтгэц засал гэдэг нь зан үйлийн өөрчлөлт, бодол санаа, сэтгэхүйн өөрчлөлт, хүний хувийн зан байдлын өөрчлөлтийг хийхэд чиглэсэн Хохирогч сэтгэц засалч хоёрын хоорондын урт хугацааны хамтын ажиллагаа юм. Сэтгэц засал нь хохирогчийн сэтгэл зүй, зан үйл, сэтгэл санаанд байгаа гажуудлыг засах гэсэн хандлага руу илүү төвлөрдөг.

Эдгээр ойлголтын хувьд ижил төстэй “туслах дэмжих” гэсэн нэгдмэл зүйл байгаа боловч ялгаатай зүйлүүд их бий. Ярилцлага хийх гэдэг нь дангаараа бие даасан үйл явц болдог. Зөвлөгөө өгөх гэдэг нь дотроо ярилцлага хийх гэсэн ойлголтыг хамааруулж байдаг. Харин психотерапи нь ярилцлага хийх, зөвлөгөө өгөх үйл явцын аль алиныг хамааруулсан ойлголт. Зөвлөгөө өгч байгаа нийгмийн ажилтан нь ярилцлага хийж, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлж болно.

Нийгмийн ажилтан зөвлөгч нь хүмүүстэй “жирийн, эмгэгтэй бус, гэхдээ асуудалтай хүн” гэдэг хандлагаар ажиллахын зэрэгцээ клиник асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэдэг.

Сэтгэц засалч нь ярилцлага хийж, заслын үйлчилгээ үзүүлэхдээ эмгэгтэй зүйлийг өөрчилж, засаж байна гэсэн хандлагаар ажилладаг. Өөрөөр хэлбэл өвчтөн эмгэгтэй хүн гэсэн байр сууринаас хандаж, түүнийг эмчлэх, засан залруулах үйлчилгээ үзүүлнэ. (Ивей, 1987)

Нийгэм - сэтгэлзүйн дэмжлэг

Нийгэм - сэтгэлзүйн дэмжлэг гэдэг нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд асуудал болон ноцтой үйл явдал тохиолдсоны дараа нийгмийн нөхцөл байдлаа сэргээж, сэтгэлзүйн шархаа эдгээхэд тусалдаг. Энэ нь хохирогчдыг идэвхгүй байхаас илүү идэвхтэй тэмцэгч, даван туулагч болж өөрчлөгдөхөд тусалдаг. Эрт үеийн нийгэм - сэтгэлзүйн оновчтой дэмжлэг нь дараах зүйлсийг бий болгож чаддаг. Үүнд:

1. Сэтгэлийн зовууриас урьдчилан сэргийлж, зовлон шаналал илүү ноцтой түвшинд хүргэхээс хамгаалдаг.
2. Хүмүүсийн өдөр тутмын амьдралаас хүлээн зөвшөөрөх шаардлагатай зүйлийг хүлээн зөвшөөрөх, түүнийгээ даван туулах чадварыг илүү сайжруулдаг.
3. Үйлчилгээний үр шим хүртэгчдэд хэвийн амьдралаа үргэлжлүүлэн авч үлдэхэд тусалдаг.
4. Олон нийтийн тодорхой хэрэгцээ шаардлагыг биелүүлдэг.

Асуудал бэрхшээл, зөрчил маргаан, эрүүл мэндийн асуудлууд нь нийгэм сэтгэлзүйн хэд хэдэн ноцтой үр дагаврыг бий болгодог. Сэтгэлзүйн шарх нь эд материалын гэмтэл, сүйрэлтэй харьцуулахад үр нөлөө багатай харагддаг боловч эд материалын алдагдлыг даван туулахаас илүүтэйгээр сэтгэлзүйн асуудал бэрхшээлийг даван туулахад илүү хугацаа шаарддаг.

Нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг болон сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрт үйлчилгээ хүргэх, дасан зохицох үйл ажиллагаа явуулах нь хүндрэл бэрхшээл тулгарсан хүмүүсийг нөхцөл байдлаа амжилттай даван туулахад тусалдаг.




Нийгэм-сэтгэлзүй гэдэг нэр томьёо нь хувь хүн болон түүний холбоо хамаарал бүхий нийгмийн нэгжүүдийн хоорондын харилцаа холбоог хамардаг. Нийгэм - сэтгэлзүйн дэмжлэг нь хүмүүсийн анхаарал хандуулж буй бие махбодын болон сэтгэлзүйн хэрэгцээ шаардлагад хариу өгөхийн тулд тодорхой нөхцөл байдалд дасан зохицох, асуудал бүхий нөхцөл байдлаа хүлээн авч, даван туулахад тусалдаг. Нийгэм - сэтгэлзүйн хувьд эрүүл байх нь сэтгэлзүй, сэтгэл хөдлөл, нийгэм, оюун санааны хувьд эрүүл байх тухай ойлголт юм.

Нийгэм-Сэтгэлзүйн хувьд эрүүл байхад туслах стратегиуд:

- Өөрт нь тусалж дэмжих нийгмийн бүлэг хайж олох
- Шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэх
- Бодит хүлээлт бий болгох
- Өөртөө цаг гаргахад туслах
- Дасгал хөдөлгөөн хийх замаар бие махбодын эрүүл мэндээ дэмжих
- Асуудал бэрхшээл тулгарсан эсэхээ эргэцүүлж, тусламж дэмжлэг эрэлхийлэхэд туслах
- Хангалттай унтаж амрах

Нийгэм-Сэтгэлзүйн үйлчилгээний загвар:

1. Ганцаарчилсан нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг: Энэ нь хохирогчийн нийгэм сэтгэлзүйн хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулдаг.
2. Нийгэм - сэтгэлзүйн нэмэлт дэмжлэг: Энэ нь хохирогчийн нийгэм сэтгэлзүйн хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулахаас гадна хохирогчийн суурь хэрэгцээ болох хоол хүнс, хувцас, орон байр зэрэгт мөн анхаарал хандуулдаг.
3. Нэгдсэн загвар А: Энэхүү загвар нь хохирогчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хямралын менежмент, нийгмийн хамгаалал зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлнэ.
4. Нэгдсэн загвар Б: Хохирогчид үзүүлэх үйлчилгээний энэхүү загвар нь бүхий л үйлчилгээг цогцоор үзүүлнэ. Энэхүү загварын зорилго нь хохирогч, тэдний гэр бүл, олон нийтэд бүхэлд нь "Шүхрийн дэмжлэг" үзүүлэхэд оршино.





ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

1. Итгэлцэлийг бий болгох

Хэрэв итгэлцэл байхгүй бол зөвлөгч хохирогчид тусалж чадахгүй. Хамгийн чухал зүйл бол итгэлцэл байдаг. Зөвлөгөө өгөхөөс өмнө итгэлцлийг бий болго. Гэр бүлийн хучирхийллийн хохирогч нь итгэл алдарсан, найдвар тасарсан, цөхөрсөн хүмүүс байх нь түгээмэл. Иймээс тэдэнд итгэж болно гэдгийг харуул. Хэн нэгэнд итгэж болох үедээ хүн санаа зовнилоо илэрхийлэх, хуваалцахдаа чөлөөтэй байдаг.

2. Нууцлал хадгалах

Хохирогчийн хувийн нууцыг хүндэтгэх. Түүний ярьсан хэлсэн бүх зүйл хатуу чанд нууцлагдан хадгалагдах ёстой. Зөвлөгөөний бүхий л үйл явцад нууцыг хадгалах нь маш чухал бөгөөд энэ нь хохирогчийн нэр төр, халдашгүй дархан байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

3. Өөрийгөө тодорхойлоход нь туслах

Хохирогч өөрийн амьдралын талаар өөрийн шийдвэрийг бодитоор хэрэгжүүлэх боломжтой байдаг. Зөвлөгчийн үүрэг бол сонголт, боломж олгох төдийгүй тэдэнд өөрсдийн чадвар, нөхцөл байдалд хамгийн сайн тохирсон хувилбаруудыг судлахад туслах явдал (даван туулах стратеги гэх мэт) юм.

4. Эерэг хандлагаар хандах

Хохирогч юуг хэрхэн сайн хийж байгааг онцлон дэмжих хэрэгтэй. Тэднийг сайн зүйл хийснийх нь төлөө урамшуулах шаардлагатай. Ингэснээр өөрөөрөө бахархах бахархал төрж, тэдний өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ.

5. Мэдрэмж дээр анхаарлаа төвлөрүүлэх

Хохирогчид туслахын тулд тэдний мэдрэмжийг (ил болон далд) ойлгохын тулд нээлттэй ярилцах нь чухал байдаг.

6. Чин сэтгэлээсээ ойлгохыг эрмэлзэх

Энэ бол бусад хүний ухамсарт ертөнцөд орж, ертөнцийг тэдний харж байгаагаар нь харах чадвар юм. (Burnard P, 1994). Хохирогч болон түүний асуудлыг тэдний өөрийн үзэл бодол, тэдний өнцгөөс харах, ойлгох нь чухал юм. Энэ нь сэтгэл хөдлөлийн дэмжлэг болж өгдгийг анхаараарай.

Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээний үндсэн зарчим:

- Гэр бүл ба зөвлөгчийн харилцаа холбоон дээр хамтын ажиллагаа суурилна.
- Эмчилгээ, засал, үйлчилгээ нь тухайн гэр бүлийн өөрчлөх хүсэл зорилго дээр үндэслэгдсэн байх.
- Интервенц, эмчилгээ, зөвлөгөө засал нь тохиолдсон асуудал, үйл явдлуудаас эхлээд өнөөгийн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд чиглэх ёстой.
- Интервенц, үйлчилгээ нь гэр бүлийн хэрэгцээ болон давуу талд түшиглэсэн үйл ажиллагаанд суурилсан байх.



- Интервенц, үйлчилгээ нь гэр бүлийн гишүүдэд чиглэсэн байх хэрэгтэй.
- Эцэг эхчүүдэд эцэг эх байх ур чадвар, арга барилд суралцахад нь туслах
- Тухайн гэр бүлийнхэнд материаллаг болон сэтгэл хөдлөлийн хэрэгцээг хангахад нь туслах.
- Харилцаа холбоо, харилцан үйлчлэлийн загварт анхаарлаа хандуулах.
- Гэр бүлийн дотоод холбоо, харилцан үйлчлэлийн тохиромжгүй байдлыг засан залруулах.
- Тухайн гэр бүл олон нийтийн нөөц боломжийг ашиглан асуудлаа шийдвэрлэх, даван туулах боломжийг олгох.

Зөвлөгөөний онолчид зөвлөгчийн дагаж мөрдөх ёс зүйн зарчмыг тодорхойлсон байдаг.

Зөвлөгчийн ёс зүй

Зөвлөгч нь:

- Хүмүүс өөрчлөгддөг гэдэгт итгэдэг байх.
- Хүмүүст, ялангуяа Хохирогчдоо чин сэтгэлийн үүднээс хандах.
- Харилцааны ур чадвартай байх.
- Хохирогчид туслахыг зорилгоо болгох, боломжгүй бол Хохирогчид хор хүргэх зүйл хийхгүй байх.
- Зөвлөгөө өгөх үйл явц нь зөвлөгч, Хохирогчийн хамтарсан, өөрчлөлт гаргах зорилго бүхий хичээл зүтгэл гэдгийг ойлгох.
- Хохирогчийнхоо нөхцөл байдлыг ойлгосон эерэг харилцаа үүсгэх чадвартай байх.

Хохирогчтой ажиллах нийгмийн ажилд Феллик Бестикийн доорх 7 зарчмыг¹⁸ түгээмэл хэрэглэдэг. Үүнд:

1. Хувь хүний онцлогийг хүндэтгэх:
Хүн бүр давтагдашгүй өвөрмөц онцлогтой бөгөөд хүн бүрийг бие даасан хувь хүн гэсэн байдлаар үйлчилгээ үзүүлэх
2. Санаа сэтгэгдэл, мэдрэмжээ тодорхой илэрхийлэх:
Хохирогч өөрсдийн санаа зовж буй асуудлаар сэтгэл санаа, мэдрэмжээ илэрхийлэх хэрэгцээ байдгийг ойлгох
3. Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах:
Хохирогч санаа сэтгэлээ илэрхийлсний дараа зөвлөгч нь сэтгэл хөдлөлдөө автагдалгүй зөв зохистой, мэргэжлийн үүднээс хил хязгаараа баримтлан ажиллах
4. Хүлээн зөвшөөрөх:
Хохирогчийг байгаагаар нь хүлээн авах, өөрийн онцлог байдлыг зөвшөөрөх
5. Буруушааж, шүүмжлэхгүй байх:
Зөвлөгөө өгч байгаа ажилтан нь хохирогчид туслах зорилготой гэдгээ ойлгож, тэднийг шүүмжлэх буруутгах нь тэдэнтэй ажиллах зорилго биш гэдгийг анхаарах
6. Хохирогчийн өөрийгөө тодорхойлох чадвар:
Хохирогч өөрсдийн төлөө шийдвэр, сонголтыг хийх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх.
7. Нууцыг хадгалах:
Хохирогчийн нууцыг хадгална.

¹⁸ Biestek, Felix Paul (2018) Client Self-determination in Social Work: A fifty year



Зөвлөгчийн үүрэг:

- Зөвлөгөө өгөхдөө хувь хүн, бүлэг, хамт олны хэм хэмжээ, үнэт зүйл, хандлагыг хүндэтгэх
- Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор эцэг эх, гэр бүл, хамт олон, хүүхэдтэйгээ байнгын харилцаа холбоог бий болгох
- Хохирогчтой сонирхлыг хүндэтгэн, итгэлцэл бий болгох
- Нийгэм, тэдний хүрээлэн буй орчноос дэмжлэг олж авахад хувь хүн, хохирогчдод туслах
- Бусад агентлаг, байгууллагын үйлчилгээтэй уялдуулах
- Үйл явцыг үнэлэх (Жишээлбэл баримтжуулалт), дараагийн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах
- Зөвлөгөө өгөх үеэр хохирогчид сайн үлгэр дуурайл болох (Жишээлбэл өрөвч сэтгэл, тэвчээр, хүндэтгэл, өөдрөг үзэл гэх мэт)



СЭДЭВ 2.2 ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР ЧАДВАРУУД

Хичээлийн зорилго:

- Зөвлөгчийн үндсэн ур чадварт суралцана.
- Аюулгүй орчин итгэлцэл бүхий харилцаа, идэвхтэй сонсох чадварт суралцана.
- Чин сэтгэлээсээ ойлгох (Эмпати) өрөвдөх сэтгэл (Симпати) хоорондоо ялгаатай гэдгийг мэднэ.
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн сэтгэлийн зовлон шаналлыг хуваалцах талаар мэдээлэлтэй болно.

Үндсэн ойлголтууд:

- Харилцааны ур чадвар
- Дэмжих харилцаа
- Чин сэтгэлээсээ ойлгох(Эмпати) Өрөвдөх сэтгэл (Симпати)
- Идэвхтэй сонсох чадварын талаарх ойлголт

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Бүлгийн ажил
- Хэлэлцүүлэг
- Нэгтгэн дүгнэх

Унших материал:

- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, Бүлэг II

Хэрэглэгдэхүүн:

- Тараах материал: ABC загвар (хуудас 41, 42)
- Дэлгэц цаас, маркер





ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР ЧАДВАНУУД

А – Аюулгүй орчин ба итгэлцлийн харилцаа:

Дэмжих харилцааны үндэс нь аюулгүй орчин, итгэлцэл бүхий харилцаа байдаг.

Дэмжих орчин гэдэг нь:

- Харилцан ярилцах, зөвлөгөө өгөх таатай орчин
- Бие махбодын болон сэтгэл хөдлөлийн аюулгүй байдал
- Нууцыг хадгалах
- Хохирогч хүчирхийллийн талаар ярих боломжийг бүрдүүлэхэд туслахуйц хохирогчид зориулсан материал, гарын авлага, товхимол

Дэмжих харилцаа:

- Шүүмжлэхгүйгээр ойлгох
- Чин сэтгэлээсээ ойлгох
- Тусламж үзүүлж байгаа хүний хүйс зэрэг нь чухал хүчин зүйл болдог.

Хохирогчдын сэтгэл хөдлөлийг мэдрэх, түүнд үзүүлэх дэмжлэг нь тэдний сэтгэл санааг ойлгох, нууцыг хадгалах, шүүмжлэхгүйгээр сонсох, тэдний мэдрэмжийг ойлгох зэрэгт суурилсан үйл ажиллагаа юм.

В – Хүчирхийллийн хохирогчтой холбоо тогтооход анхаарах зүйл:

- Шүүмжлэхгүйгээр сонсох
- Ажиглах (юу харж байна, сонсож байна, хохирогч хэрхэн ярьж байгааг, түүний биеийн хэлэмж ямар байгааг анхаарах)
- Асуух, гэхдээ байцаах биш
- Яаран дүгнэлт хийхгүй байх
- Тайлбарлах
- Нээлттэй байх
- Эрсдэл хийхгүй байхыг хичээх.

Анхааралтай сонсох зааварчилгаа:

- Болгоомжтой сонс, бүү саад бол.
- Чимээгүй байгаа тохиолдолд хүлээх – тухайн нөхцөл байдалд тохируулан үг хэлэх, үйлдэл хийх, зохицуулах чадвартай байх ёстой.

Биеийн хэлэмжид анхаарлаа хандуулах:

- Биеийн хэлэмжийг анхаарах
- Аман бус харилцааны хэлбэр буюу үйл хөдлөлөөр яриаг өдөөж өгөх (тухайлбал толгой дохио, нүүрний хувирал болон нүдний хөдөлгөөн)
- Ярилцагчийн аман бус харилцаанд анхаарлаа хандуулах

Асуух:

- Нэг доор хэт олон асуулт асуухгүй байх
- Нээлттэй асуулт тавьж, нарийвчлан судлах боломжийг олгоно



- Яагаад, ямар учраас гэсэн асуултуудыг бүү хэрэглээрэй (яагаад өмнө нь энэ талаар яриагүй юм бэ?...).
- Таны хувьд ойлгомжгүй байгаа үг, хэллэгийг давхар шалгана уу.

Хариу үйлдэл:

- Энгийн үг, өгүүлбэрийг ашиглан яриаг дэмжих (ж.нь Энэ талаар та хэлж өгөөч? Би ойлгож байна, анхан гэх мэт.)
- Тухайн хүний хэлсэн зүйлийг үе үе эргүүлэн асуух (тухайн хүний түүх, мэдрэмж).
- “Би гэсэн үгийг” ашигла. Хүмүүст та юу мэдэрч байгаагаа илэрхийлэхийн оронд тухайн асуудлыг хэрхэн ойлгож байгаагаа хэлээрэй (Жишээлбэл “Та тэгж байна? гэхээсээ илүү “Би ингэж бодож байна ... «)
- Тухайн хүний мэдрэмжийг үгээр илэрхийл (Та ууртай байх шиг байна).

С- Юу хийх, Юуг асуух, Юуг хэлэх вэ?

Хэн нэгэн хүчирхийлэл, доромжлолд өртөөд түүнийгээ мэдээд тусламж хүсэх үед тэдэнд тусалж дэмжлэг үзүүлэх нь чухал. Ихэнх тохиолдолд хохирогч өөрөө хамгийн анхны тусламж хүсэгч байх нь гарцаагүй бөгөөд бид хохирогч түүний хүчирхийлэл доромжлолын талаар ярих боломжтой цорын ганц хүн гэдгийг ойлгох хэрэгтэй. Тусламж авахын тулд хохирогч үйлчилгээний талаар эерэг бодолтой байх нь чухал юм. Ядуу байх, үр дүнтэй бус үйлчилгээ, зөвлөгөө нь хохирогчийг ухарч, буцах, тусламж хүсэх тухай бодлоо өөрчлөхөд хүргэдэг. Энэ нь маш аюултай үр дагавартай.

- “Танд тусламж хэрэгтэй юу” эсвэл “би танд яаж туслах вэ” гэж асууж сурах
- “Та хүчирхийлэлд өртсөнөөрөө буруутгагдах ёсгүй” эсвэл “Та аюулгүй байх эрхтэй” гэж хэлэх

Зөвлөгч нь юуг хэлж болох, юуг хэлж болохгүй гэдгийг ялгаж салгах, сайтар мэдэж байх нь чухал юм. Хүчирхийлэлд өртсөн хохирогчид хэлэх хамгийн чухал нэг мессеж бол «Та хүчирхийлэлд өртсөнийхөө төлөө хариуцлага хүлээхгүй» гэсэн үг юм.

Юу хийх, юу хэлэх вэ?

- Дэмжсэн эелдэг харилцааг чухалчил.
- “Би танд яаж туслах вэ?” гэж асуух нь тохиромжтой! “Ямар нэгэн буруу зүйл байна уу?” “Танд тусламж хэрэгтэй байна уу?” “Танд ямар нэгэн байдлаар аюултай байгаа санагдаж байна уу?” Таны болон хүүхдүүдийн чинь амьдралд ямар нэгэн байдлаар аюул занал байна уу?” “Энэ хүчирхийллийн талаар та хэн нэгэнд хэлж байсан уу?»
- Тэдэнд энэ нь ямар хэцүү болохыг ойлгосон гэдгээ илэрхийл, харуул.
- Шуурхай тусламж үзүүл. Түүнд туслахыг хүсэж байгаагаа хэл.
- Хэрэв Хохирогч сэтгэл дундуур, ууртай байвал түүнийг тайвшрахад нь тусал.Түүнийг тайвшрахад нь юугаар тусалж болохыг асуу.
- Бие махбодын аюулгүй байдлаа хангахад нь туслахыг хичээ.
- Тухайн хүний ярьж буй зүйлийг сонс.
- Юу хийж чадахаа, хэрхэн тусалж чадахаа тайлбарла.
- Хүчирхийллийн туршлагыг даван туулах чадвартай, хүчирхийллийн талаарх мэдээллийг олон нийтэд дэлгэх чадвартай хүн гэдгээ онцол.
- Тухайн Хохирогчид юу хэрэгтэй байгаа, юу хүлээж байгааг анхаарч үзэх (хүчирхийллийг таслан зогсоох хамгаалалт, мэргэжлийн туслалцаа авахын тулд хаана хандах, хүчирхийллийн талаар мэдээлэх, шуурхай үйлчилгээний төв болон хамгаалах байр руу хандах, хууль эрх зүйн зөвлөгөө авах).

- Түүнд итгэж байгаагаа илэрхийлэх.
- Тэр үнэхээр гэмт хэргийн золиос болсон гэдгийг нотлох баримт хайх гэж бүү оролд. Үүнийг цагдаа хийх болно гэдгийг анхаараарай үлдээгээрэй. Түүнийг хүчирхийллийн золиос болсон гэдэгт итгээрэй.
- “Объектив үнэн”-ийг хайх хэрэггүй. Яаралтай тусламж хэрэгтэй байгаа хүмүүст туслахад бэлэн гэдгээ харуулах. Үзүүлэх тусламж, зөвлөгөөний талаарх үндсэн мэдээллийг өгөхөд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.
- Хүчирхийллийн эсрэг байр сууриа тодорхой илэрхийлнэ. Хүчирхийллийг бүү үгүйсгэ, хор хөнөөл багатай мэт бүү ойлгуул, бүү тэвч.
- Аюулгүй тайван байдлыг мэдрэх эрхтэй гэдгээ тэдэнд хэл.
- Хэн ч, хэнийг ч, хэзээ ч, хаана ч хүчирхийлэх эрхгүй гэдгийг тайлбарла.
- Тэдэнд: «Та хүчирхийлэлд хэзээ ч буруутгагдах ёсгүй» гэж хэл. Хүчирхийллийг үйлдэгч хүн нь бүхэлдээ буруутай тэр хүн хариуцлага хүлээх ёстой гэдгийг онцол.
- Тэдэнд хүчирхийллийг даван туулахад хэрэгтэй дэмжлэг, туслалцаа үзүүлэх нөөц, боломжийг олж мэдэхэд нь туслах (найз нөхөд, гэр бүл, хамтран ажиллагсад, мэдлэг, чадвар...)
- Тусламж зөвлөгөө авч болох янз бүрийн арга зам, эх сурвалж, байгууллага, хөтөлбөрийн талаарх мэдээллээр хангах (төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хууль, дүрэм, журам).
- Тэдний шийдвэрийг хүндэтгэх.
- Хүчирхийллийн талаар танд мэдэгдэж, танд итгэж асуудлаа ярьсанд баярласан гэдгээ илэрхийлэх.

Юуг хэлж, юуг хийж болохгүй вэ?

- “Тэр хүн чамайг хүчирхийлэхэд юу нөлөөлсөн бэ?”, “Та яагаад хүчирхийллийн талаар мэдээлээгүй юм бэ?”, “Чи яагаад зугтаад явж болоогүй юм вэ? гэж битгий асуу
- Хүчирхийллийг нотлох баримт хайхгүй байх
- Хүчирхийлэл үйлдэгчтэй шууд тэмцэж, тулалдахыг хэзээ ч бүү шаард
- Хүчирхийлэл үйлддэг хүн хохирогчоос илүү хүчтэй, харилцаа нь тэгш бус байдаг.
- Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод сул дорой мэт хандаж болохгүй. Тэднийг чадваржуулах, бие даасан болгоход анхаар.
- Тэдний бодол санаа, мэдрэмж, үйлдлүүдийг бүү шүүмжил, ёс суртахуунгүй гэж бүү дүгнэ.
- Хохирогчдод бодит бус хүлээлт бүү бий болго. Тэднийг ямар нэгэн зүйлийг заавал хийх гэж шахалт үзүүлэхгүй байх.
- Тэднийг өөрийн зан үйлээсээ болон хүчирхийллийг өдөөж, хүчирхийлэлд өртсөн гэж хэзээ ч бүү хэл.
- Байцаалт авч байгаа мэт сэтгэгдэл бүү төрүүл, юу болсныг хэт нарийвчлан асуух хэрэггүй.
- Хүчирхийлэл, хүчирхийллийн талаар дуулаагүй сонсоогүй гэж хэлж болохгүй.
- Хүнийг эрсдэлээс аврах гэж бүү оролд. Зөвлөгчийн мэргэжлийн хил хязгаарыг баримтлах хэрэгтэй. (Хүчирхийлэгчээс зугтаах үед шаардлагатай хувцас, бичиг баримтыг нь гэртээ хадгалахгүй байх, очих газар байхгүй тохиолдолд тэднийг гэртээ аваачихгүй байх зэрэг)
- Огцом, хүчтэй сэтгэл хөдлөл болон хариу үйлдэл үзүүлэх хэрэггүй («Өө, энэ бол сүйрэл, үнэхээр аймшигтай юмаа, хүчирхийлэл бол хэзээ ч нөхөж баршгүй хохирол учруулдаг даа гэх мэт ...»).

- Хохирогч болон гэмт этгээдийг бүү шүүмжил.
- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх хувийн туршлага, өөрт тохиолдсон зүйлийг ярихгүй байх.
- Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчийг орхихыг ятгаж, хүчлэхгүй байх.

Идэвхтэй сонсох

Идэвхтэй сонсох нь зөвхөн хүн өөрийн сонорын эрхтнээрээ дамжуулан дуу авиаг хүлээн авах тухай асуудал биш юм. Энэ нь сонорын мэдрэмжийг ашиглахаас гадна бусад мэдрэмжээ ашиглан Хохирогчийн асуудлыг хүлээн авч ойлгох үйл явц . Хохирогч нь зөвлөгчийн халуун дулаан сэтгэл, туслах гэсэн хүсэл, түүний ойлгож байгаа гэдгийг мэдрэх боломжийг олгохын тулд хэлж ярьж байгаа зүйлийг сонсож, үүний зэрэгцээ аман бус харилцааг ойлгон хүлээн авч, зөвшөөрч, аль алинд нь зохих ёсоор хариу өгөх ёстой. Идэвхтэй сонсох ур чадвар нь богино хугацааны болон урт хугацааны зорилгыг агуулдаг.

Богино хугацааны зорилго: Хохирогч болон зөвлөгчийн хоорондын харилцааг хөгжүүлж, хадгалах, хувь хүний мэдрэмжийг ойлгох.

Урт хугацааны зорилго: Хувь хүн буюу Хохирогч өөрийн санал бодлоо илэрхийлэх, хувь хүний давуу талыг хөгжүүлэх, хүндрэл бэрхшээлтэй асуудал буюу хүчирхийллийг даван туулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх чадварт суралцахад чиглэнэ.

Яагаад?

- Илүү их хувь хүнд хандсан байна.
- Хувь хүний асуудал, мэдрэмжийг хүндэтгэж, хүн бүхэнд нухацтай хандах шаардлагатай
- Асуудал болон түүнийг шийдвэрлэх арга замуудын талаар дүн шинжилгээ хийж, өөрийн эргэцүүлэн бодох чадварыг хөгжүүлдэг учраас
- Асуудлаа шийдвэрлэх бодит арга хэрэгсэл буюу аргачлал болж өгдөг учраас
- Өөрийгөө илэрхийлэх болон, харилцаа холбоо, ярилцах үйл явцыг идэвхжүүлж өгдөг учраас

Яаж?

А. Асуудлыг тодорхой ойлгомжтой болгож, бүтэцжүүлэх

- Зайлшгүй шаардлагатай мэдээллийг аль болох сайн цуглуулах
- Хариултуудыг тодруулж, нөхцөл байдлыг элдэв дүгнэлт шүүмжлэлгүйгээр тайлбарлах
- Өөрийн асуудлыг ойлгож тодорхойлоход нь туслах

Харилцааны ур чадвар

Хохирогчийн яриаг хэсэг, сэдэв бүрийн дараа бодитойгоор нэгтгэн дүгнэх (хангалттай шинэ мэдээлэл байгаа тохиолдолд л).

Нэгтгэн дүгнэхдээ:

- а) Та зөвлөгчийн хувьд болон сонсогчийн хувьд хохирогчийн түүх, захиасыг ойлгосон эсэхээ шалгаарай.
- б) Та хохирогчийг анхааралтай сонсож байгаа гэдгээ харуул, тийм мэдрэмжийг төрүүл.
- в) Хохирогчийг цааш нь үргэлжлүүлэн ярихыг үг яриа болон үйл хөдлөлөөрөө дэмжих.
- д) Ярилцлагаа үргэлжлүүлэх, завсарлах зэргийг тухайн ярилцлагын нөхцөл байдалд



тохируулан төлөвлө. Ихэвчлэн маш их хэмжээний мэдээлэл агуулсан тохиолдолд хохирогч ялангуяа хүүхдүүдийн хувьд асуудлаа ярихдаа зарим зүйлийг орхигдуулах, мартаж, мэдээллийг дутуу өгөх зэрэг эрсдэл байдгийг анхаарах. Жишээлбэл “Хэрвээ би буруу ойлгоогүй бол ...”

Мэдрэмжийг харилцаандаа тусгах

Зөвлөгч нь хохирогчийн шууд болон шууд бусаар илэрхийлж буй сэтгэл хөдлөлийг тусгах ёстой. Энэ бол хохирогчийн байдлыг ойлгуулах, мөн тухайн асуудлын гол шалтгаан байж болзошгүй зүйлсийг анхаарч үзэхэд туслах хамгийн хүчирхэг чадварын нэг юм. Жишээлбэл:

“Танд хэцүү байсан болохоор гунигтай санагдаж байна.”

“Та дахиж гэр рүүгээ очихыг хүсэхгүй байх шиг байна

“Та нөхөртөө уурлаж байна; ийм учраас та гэртээ очих талаар бодохыг ч хүсэхгүй байгаа юм байна” гэх мэт.

Өөр үгээр илэрхийлэх

Зөвлөгч нь хохирогчийн хэлсэн зүйлийг зөв ойлгосон эсэхээ бататгах үүднээс өөр үгээр илэрхийлэх ур чадварыг хэрэглэдэг. Өөр үгээр илэрхийлэх нь хохирогчийг өөрийн асуудал, бодол санаа, тохиолдсон үйл явдал зэргийг бүрэн илэрхийлэх, салаа болон хоёрдмол утгатай зүйлийг хэрхэн ойлгож байгаагаа зөвлөгч баталгаажуулах зөв ойлгоход тусалдаг. Өөрөөр хэлбэл бодол болон мэдрэмжийн нэгдэл гэж хэлж болно. Жишээлбэл:

“Та нэлээд удаан хугацаанд унтаж чадахгүй байгаа болохоор анхаарал төвлөрөхөд бэрхшээлтэй байгаа гэж та хэллээ”

“Таны ярьсан зүйлээс харахад, миний ойлгож байгаагаар бол та гэрээсээ зугтахыг хүсэж байгаа ч энэ нь ямар үр дагавартай вэ гэдгийг мэдэхгүй байх шиг байна” гэх мэт

Давтан асуух, Бататгах

Зөвлөгч нь хохирогчийн хэлсэн үгийг эсвэл өгүүлбэрийн нэг хэсгийг давтаж, түүнийг үргэлжлүүлэн ярих, мөн тодорхой хэсэгт анхаарлаа хандуулахад чиглүүлж өгдөг. Эдгээр нь ихэвчлэн сэтгэл хөдлөлийн болон ярьсан зүйлийн агуулгын хувьд чухал зүйлийг онцолсон байдлаар харагддаг. Заримдаа нэг зүйлийг олон дахин давтаж байгаа нь тухайн хүний бодол санаа, мэдрэмжийг илүү ихээр нээн харуулж байдаг. Жишээлбэл:

Хохирогч: «Би энэ хэдэн өдрүүдэд маш их зовж шаналж, итгэл найдваргүй болсон; Хэн ч надад тусалж чадахгүй эсвэл хэн ч намайг тоохгүй байгаа юм шиг санагдаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд туслах хүн байхгүй байгаа мэт, орхигдсон мэт надад санагдаж байна.” гэвэл

Зөвлөгч: “Хэн ч танд тус болохгүй гэж та хэлж байна уу?”

Зөвлөгч: “Та юунд ч итгэхгүй байгаа юм уу?”

В. Асуулт асуух ур чадвар

- Нээлттэй асуултууд

Тухайн хүнд хариултаа өөрийн үгээр өгөх, дэлгэрэнгүй хариулах боломжтой асуултуудыг нээлттэй асуулт гэнэ. Энэ нь тухайн хүнийг өөрийн бодол санаагаа цэгцэлж, нөхцөл байдлыг судлахад түлхэц өгдөг. Дараах идэвхжүүлэх асуултуудыг ашиглаарай.

Жишээлбэл: “Та өөрийнхөө мэдрэмжийн талаар илүү ихийг хэлж чадах уу? ”

- Хаалттай асуултууд

Эдгээр асуултууд нь ярилцлагын эхэнд мэдээлэл цуглуулахад хэрэгтэй байдаг. Тийм, үгүй гэсэн хязгаарлагдмал хариултуудыг авах боломжтой асуултууд юм. Гэхдээ болгоомжтой хэрэглэхгүй бол хохирогчийн хариултыг хязгаарладаг төдийгүй асуудлын учир шалтгаан, уялдаа холбоог илрүүлэхэд саад болдог.

Жишээлбэл: “Чи түүнд таалагдаж байна уу? Та түүнтэй байнга муудалцдаг уу? Тэр чамайг дандаа хардаж зоддог уу?”

- Санал болгож буй (дөхүүлэх) асуултууд нь болгоомжтой хэрэглэх ёстой асуултын хэлбэр юм.

Асуулт асууж байгаа мэт боловч асуултаараа хариултыг нь шууд дөхүүлж өгч байдаг. Асуултад хариулт оршино. Жишээлбэл: “Чи түүнд их уурлах ёстой, үгүй гэж үү?” Үүнийг хийх нь тэнэг хэрэг гэж бодоогүй биз дээ? Та үүнийг хийж чадна биз дээ?”

- Чиглүүлэх асуултууд

Ярилцлага өөр тийшээ хазайх, яриа сунжруу болох, сэтгэл хөдлөлдөө хэт автах зэрэг тохиолдолд асуултын энэ хэлбэрийг хэрэглэх нь тохиромжтой.

Жишээлбэл: “Бид гэр бүлийн чинь талаар нэлээд ярилцлаа. Одоо танай нөхрийн зан аашны талаар яривал ямар вэ?” “Өмнө нь бас бид энэ талаар ярилцаж байсан. Танд нэмж хэлэх зүйл байвал хэлж болно. Тэгээд ярилцах гол асуудал руугаа орох уу?”

Чин сэтгэлээсээ ойлгох, санаа тавих

Чин сэтгэлээсээ ойлгох буюу Эмпати гэж юуг хэлэх вэ?

Энэ нь зөвлөгөө өгөх ур чадвар ба хандлагын бүтээлч хослол бөгөөд Зөвлөгч нь хохирогчид тохиолдсон хүчирхийллийн тухай болон хохирогчийн асуудал, нөхцөл байдлыг тухайн хүний түвшинд ойлгох, хүлээн авахыг хэлж байгаа юм. Эмпатийг дараах байдлаар илэрхийлж болно.

- Мэдрэмжийн тусгалаар дамжуулан илэрхийлэх (мэдрэмжийг ойлгох) Жишээлбэл: Та ...ийм учраас ийм зүйлийг мэдэрдэг”
- Өөр үгээр илэрхийлэх: Жишээлбэл “Эцэг тань нас барсан нь энэ асуудлын учир шалтгаан гэж та үздэг юм байна...”
- Аман бус харилцаагаар илэрхийлэх: Жишээлбэл хохирогчийн сэтгэл хөдлөлтэй байх үед зөвлөгч чимээгүй байх
- Асуултаар илэрхийлэх: “Аав тань нас барснаар танд юу тохиолдсон талаар бага зэрэг мэдээлэл өгч болох уу? ”

Чин сэтгэлээсээ ойлгох (Эмпати) ба Өрөвдөх сэтгэл (Симпати) хоёрын ялгаа

Зөвлөгч нь өөрийгөө хохирогчийн байр суурин дээр аваачиж бодол санаагаар нь дамжуулан асуудлыг чин сэтгэлээсээ ойлгох хэрэгтэй байдаг.

Харин түүнийг өрөвдөх, хөөрхийлөх сэтгэл гаргаад байх нь хохирогчийн нөхцөл байдлыг дордуулж мэднэ. Иймд Эмпати ба Симпати хоёр нь хоорондоо өдөр шөнө шиг ялгаатай зүйл гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй.





Санаа тавих/аман бус харилцаа

Санаа тавих гэдэг нь үндсэндээ хэн нэгэнтэй (хохирогчтой) хамт байх, түүнд энэ байдлаа мэдрүүлэх гэсэн үг юм. Үүнийг:

- аман бус харилцааны хэлбэрүүдээр, тухайлбал тайван суух, бага зэрэг урагшлах, хараагаараа холбоо тогтоох (соёлын хувьд тохиромжтой эсэхийг анхаарах),
- зөвлөгчийн төвлөрч байгаа байдал, анхаарлаа хандуулж байгаа байдал зэргээр дамжин хэрэгжүүлж болно.

Аман бус харилцаа нь аман харилцаанаас илүү ойлгомжтой байж болно. Царай ил харагддаг, үүнийг өөр үгээр, өөр зүйлээр орлуулах боломжгүйг анхаарах хэрэгтэй. Жишээлбэл: Зөвлөгч нь хохирогчийг хүлээн зөвшөөрөхдөө толгой дохих, инээмсэглэх замаар үргэлжлүүлэн ярихыг нь дэмжиж чадна.

Аман бус харилцааны бусад хэлбэрт чимээгүй байх (айдасгүй байх, бодол санаагаа цэгцлэх, амсхийхэд нь тустай байдаг), нүдний харц, инээмсэглэл, нүүрний хувирал орно.

Дэмжих хандлага

Үүнд харилцааны дараах илрэл орно:

- Эелдэг байдал
- Нээлттэй байдал
- Тайтгаруулах (үг хэлэх, биед нь тохиромжтой байдлаар хүрэх)
- Дэмжих
- Анхаарал хандуулах, сонирхол
- Харилцан ойлголцох
- Шүүмжлэхээс зайлсхийх эсвэл шууд дүгнэлт хийхгүй байх

Дэмжих хандлагыг хэрэглэхтэй холбогдох ур чадвар:

- Хохирогчийг байгаагаар нь хүлээж авах
- Хохирогч бүрийг дахин давтагдашгүй хувь хүн гэж ойлгох
- Ярилцлагын нууцыг хадгалах
- Хохирогчид өөрийгөө тодорхойлох боломж олгох, үйл ажиллагаагаа төлөвлөхөд өөрөө оролцох боломжоор хангах
- Хохирогчийн үзэл бодлыг хүндэтгэж, сонсох
- Зөвлөгчид таны талаар асуух боломж олгох
- Хохирогчтой ярилцахдаа ойлгомжтой, энгийн (өөрсдийнх нь онцлогт тохирсон) үг хэллэг хэрэглэх

Зөвлөгөө өгөх нь хүнд нөхцөлд байгаа хохирогчийн сэтгэц, нийгмийн болон сэтгэл хөдлөлийн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга юм. Эерэг зөв хандлага, харилцааны ур чадвар сайтай бол зөвлөгөө өгөх арга зүйгээр тусгайлан бэлтгэгдсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөгч болж зөвлөгөө өгч чадна.

- Зан үйл нь мэдрэмжийн илэрхийлэл болдог. Асуудалтай зан үйлийг өөрчлөхийн тулд зөвлөгөө өгөхөд тухайн хохирогчийн мэдрэмжийг ойлгож харилцах шаардлагатай байдаг.



- Сэтгэл зүйн эрүүл байдал нь хохирогчийн даван туулах, оршин тогтнох, хамгаалах, хөгжлийн чухал хэсэг юм.
- Хууль эрх зүйн үндэс: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын тухай хууль
- Ялангуяа хүчирхийлэлд өртсөн хохирогчдод туслах нь олон янзын хандлага шаарддаг. Хоол хүнс, орон байр, эрүүл мэндийн үйлчилгээ, зөвлөгөө, засал гэх мэт. Зөвлөгөө өгөхөд хохирогчийн мэдрэмж, бодол, санаа бодолд төвлөрдөг.
- Зөвлөгөө нь хохирогчдод тулгамдаж буй асуудал, хүндрэлтэй нөхцөл байдлаа шийдвэрлэх, даван туулахад нь тусалж, дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Зөвлөгөөний үед хийж болохгүй зүйлс:

- Тушаал өгөх, тулгах, шахах
- Сэрэмжлүүлэх айлгах, аюул заналхийлж байгаа мэт ойлгуулах
- Зааварлах, сургах эсвэл өмнөөс нь шийдвэр гаргах
- Ёс суртахууныг номлох, хаяг шошго зүүх
- Санал зөрөлдөх, хүлээн зөвшөөрөхгүй байх, шүүх, шүүмжлэх
- Зааварчлах, үнэлгээ шууд хийх
- Маргах, зөрөлдөх
- Гэгээрүүлэх гэж дүрэмдэх (зохисгүй тохиолдолд)





МОДУЛ 3. ХОХИРОГЧИД НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АРГА ЗҮЙ

СЭДЭВ 3.1 ХОХИРОГЧИД НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ

Хичээлийн зорилго:

- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөний явцын талаар мэдлэгтэй болно.
- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөний үе шатуудад зөвлөгчийн анхаарах зүйлийн талаар мэдлэгтэй болно.
- Үйлчлүүлэгчид тохиолдсон хүндрэл бэрхшээл, зөрчил маргааны мөн чанарыг нарийвчлан тодруулах, илрүүлэх арга барилд суралцана

Үндсэн ойлголтууд:

- Зөвлөгөө өгөх үйл явц, анхаарах асуудал
- Зөвлөгөөний баримтжуулалт

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Кейс дээр ажиллах
- Товч мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах
- Асуулт хариулт, харилцан ярилцах

Унших материал:

- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, Бүлэг III

Хэрэглэгдэхүүн:

- Тараах материал 1. Үйлчилгээний төлөвлөгөөний хүснэгт (хуудас 55)
- Тараах материал 2. Кейс

Кейс. Хохирогч О 40 настай, нөхөр 2 хүүхдийн хамт амьдардаг. Хүү нь 15, охин нь 11 настай. О нь соёлын сургууль төгссөн, аав ээжээсээ наймуулаа. Түүнийн нөхөр барилгын ажил эрхэлдэг, 6 жилийн өмнөөс хохирогч О-гийн биед гар хүрэх болсон. О тогтмол ажил хийх хүсэлтэй боловч түүний нөхөр зөвшөөрдөггүй учраас гэртээ л байдаг. О-г ах дүү нартай нь уулзуулдаггүй байсаар одоо тэдэнтэй холбоо тасарсан. 6 жилийн турш нөхрөө засрана гэж бодсон боловч өөрчлөлт гараагүй, улам л хүчирхийлэх болсон. О салах хүсэлтээ хэлсэн боловч зөвшөөрөөгүй, улмаар түүнийг улам дарамтлах болсон...



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ

Зөвлөгөө өгөх явцад сэтгэл санааны дэмжлэг зайлшгүй шаардлагатай байдаг гэдгийг маш сайн анхаарах хэрэгтэй. Зөвлөгчийн зүгээс хүчирхийлэлтэй харилцаанд байхаар шийдэж, үлдэж байгаа хохирогчийн хувьд дараах асуудлыг анхаарах хэрэгтэйг сануулан ажиллах шаардлагатай. Үүнд:

- Аюулгүй байдлаа хангах үеийн арга хэмжээ
- Эрсдэлийн үнэлгээ байнга хийлгэх
- Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөнд хамрагдах: Хохирогч өөрөө; хүчирхийлэл үйлдэгчийг үйлчилгээнд хамруулах; хосуудын зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдах
- Сонголтын талаар бодох, тунгаах
- Үүрэг хариуцлагын талаар тунгаах
- Хүүхдэд бий болох эрсдэлүүдийг анхаарах хэрэгтэй.

Харин хүчирхийлэлтэй харилцааг орхиж явсан хохирогчийн хувьд зөвлөгч:

- Хямрал, хагацлыг давж туулах сэтгэл санааны байдал
- Хүчирхийлэл зогсох, эсвэл хүчирхийлэлтэй харилцааг орхиж явахад анхаарах зүйлсийг сануулж ажиллах нь чухал юм.

1) Харилцаа холбоо тогтоох, зөвлөгөө өгөх үйл явцыг эхлүүлэх

Үйлчилгээний хэлбэр нь тулгарсан асуудал, тодорхой шалгуур үзүүлэлт, ямар үйлчилгээ хэрэгтэй байгаа зэргээс хамаарах ёстой. Сэтгэл хөдлөлийн тэнцвэргүй байдал, сэтгэц нийгмийн асуудлууд, өдөр тутмын үйл ажиллагаа алдагдсаны улмаас асуудалд орох зэргээс хамаарна.

Энэ үйл явцад зөвлөгч нь хохирогчтой харилцаа холбоо тогтоох, харилцан ойлголцсон, тав тухтай уур амьсгалыг бий болгосны дараа өөрийгөө болон зөвлөгөөний талаар тайлбарлана. Хохирогчтой харилцахдаа эерэг уур амьсгал бүрдүүлж, хувь хүний нууцлалын асуудлыг хадгалах, ямар тохиолдолд, хэнд мэдэгдэх талаар ярилцах хэрэгтэй.

Зөвлөгч нь:

- Хохирогчийн хүсэлтийн дагуу түүнийг хүлээн авах өдөр, цаг хугацааг тохирон бүртгэх
- Хохирогчийн тавьж байгаа санал хүсэлт, санаа зовж буй асуудлыг нь сайтар тодруулах
- Хохирогчийн гэр бүлийн талаар товч мэдээлэл авах
- Зөвлөгөө явуулах дэг журмын талаар товч мэдээлэл өгөх
- Зөвлөгөөний талаар тайлбарлах
- Ямар хүлээлт байгааг асуух
- Хохирогчийн айдас түгшүүрийг намжаах, итгэл найдварыг нь бэхжүүлэх
- Энгийн бөгөөд илэн далангүй харилцах

Хүчирхийллийн талаар асуух, ярих нь тохиромжтой эсэх, аюулгүй байдлын талаар өөрөөсөө асуугаарай гэх мэтээр зөвлөнө. Жишээлбэл:

- “Танд ямар нэгэн асуулт байна уу?”
- “Танд тусламж хэрэгтэй юу?”
- “Ямар нэг хэцүү зүйл байна уу?”
- “Би танд яаж туслах вэ?”
- “Танд ямар нэгэн шууд аюул заналхийлж байна уу?”
- “Энэ бол таны амьдрал, үр хүүхдүүдийн тань амьдрал учраас та өөрөө юу гэж бодож байна вэ?”





II) Асуудлыг тодруулах, нөхцөл байдлын үнэлгээ хийх

Зөвлөгч хохирогчийн ярьж буй зүйлийг анхааралтай сонсоно (аман болон аман бус харилцааны хэлбэрт анхаарлаа хандуулна). Хохирогчийн ярьж байгаа зүйлд анхаарлаа төвлөрүүлж түүнд юу хэрэгцээтэй байгаа, зөвлөгчөөс юу хүсэн хүлээж байгааг ойлгох нь маш чухал юм. Энэ нь тухайн хүний сэтгэл хөдлөлийн байдал, хэрэгцээ (мэдээлэл, үйлдэл гэх мэт) түүний хүлээлтийг үнэлэхэд бидэнд чухал ач холбогдолтой юм.

Юуны түрүүнд хохирогчид тулгарч буй асуудлыг илрүүлнэ. Хохирогчийн асуудлыг илрүүлж, эрсдэлийн, нөхцөл байдлын үнэлгээг хийнэ. Түүнчлэн хохирогчийн давуу тал, нөөц боломж, эерэг шинж чанаруудын талаар олж мэдэх хэрэгтэй. Аливаа шийдвэр бүрд зөвлөгч нь хохирогчтой хамтдаа шийдвэр гаргана.

- Асуудлыг илрүүлэх, судлах
- Хохирогчийн давуу тал гэх мэт эерэг шинж чанаруудын талаар олж мэдэх
- Нөхцөл байдал, бэрхшээлийг ойлгох
- Үйл явцыг эхлүүлэхийн тулд хамтдаа шийдвэр гаргах
- Асуудлын талаар харилцан ойлголцлыг бий болгох

Хэрэв хохирогч өөрийн гэр бүлд байдаг зүйлүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд тооцогддог гэдэгт эргэлзэж байгаа бол түүнд нотлох баримт, баримтын талаар мэдээлэл өгөх шаардлагатай байна.

- Хүчирхийллийг хүчирхийлэл гэж тодорхойл.
- Хүчирхийллийн золиос болсон гэдэгт итгээрэй.
- Хохирогч нь хэн бэ, хүчирхийлэгч нь хэн бэ гэдгийг нарийн тодорхойлох хэрэгтэй. Хүчирхийллийг үүсгэсэн хүн нь хүчирхийллийг бүхэлд нь хариуцах ёстой гэдгийг онцол; хүчирхийллийн хариуцлагыг хүчирхийлэгч, хохирогч хоёрын хооронд хуваахыг хэзээ ч бүү оролд.
- Хохирогчид ихэвчлэн өөрсдийн хүчирхийллийн буруутан гэж боддог. Хохирогч хэзээ ч хүчирхийлэлд буруутгагдах ёсгүй гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Хохирогчид тохиолдсон хүндрэл бэрхшээл, зөрчил маргааны мөн чанарыг нарийвчлан тодруулах, илрүүлэх хэрэгтэй.

Анхаарах асуудал:

- гэр бүлийн гишүүн бүртэй уулзаж ярилцах замаар амьдралын түүхийг судлах
- тухайн хувь хүн болон гэр бүлийн амьдралд үүсэж бий болсон өнөөгийн нөхцөл байдалд задлан шинжлэл хийх
- гэр бүл болон хохирогчид тохиолдож бий болсон бэрхшээл зөрчлийн бодит учир шалтгааныг тодруулах
- гэр бүлийн гишүүдийн хооронд зөрчил маргаан, хүчирхийлэл үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх
- гэр бүлийн дотор тухайн хохирогчийн эзлэх байр суурь
- хохирогчийн тавьсан санал гомдлын дагуу тухайн гэр бүлд бодитойгоор бий болоод байгаа асуудал бэрхшээл, зөрчил маргаан, хүчирхийллийн учир шалтгаан
- гэр бүлийн амьдралыг өмнөх хэвийн байдалд оруулахад ашиглаж болох нөөц боломжуудыг судлан тогтоох
- гэр бүлийн харилцаанд хүндрэл бэрхшээл учруулаад байгаа гишүүдийн зан үйлийн өөрчлөлт, доголдол, илэрч байгаа төрх байдлын илрэл, шинж тэмдгүүд
- тухайн хүний зан үйлийн өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс
- шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн болон клиникийн нарийвчилсан үнэлгээ хийх



Тодруулах асуудал:

- Хосуудын харилцааг тодруулах
- Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн үнэлгээ хийх
- Гэр бүлийн бусад гишүүдэд (хүүхдэд) гарах үр дагаврыг тодорхойлох
- Өөрийгөө болон хүүхдүүдээ хамгаалах арга замуудыг тодруулах

Нийгэм-сэтгэл зүйн дүгнэлт гаргах:

Зөвлөгөөний явцад хохирогчтой уулзаж ярилцах явцдаа цуглуулсан мэдээлэл, судалгаа, үнэлгээний баримт нотолгоонд тулгуурлан үүсэж бий болсон асуудал, нөхцөл байдлын төлөв байдлын талаарх дүгнэлт гаргах нь хамгийн чухал.

III) Зөвлөгөө өгөх төлөвлөгөө боловсруулах

Зөвлөгч нь хохирогчтой хамт хүчирхийллийг таслан зогсоох, шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэхийн тулд цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө гаргана. Үүний тулд зорилгоо тодорхойлох, аль нь чухал гэдгээ, юунаас эхлэхээ эрэмбэлэх, зорилгоо эцсийн байдлаар хамтдаа боловсруулна. Хохирогчийн гаргасан шийдвэрийг дэмжиж, хүндэтгэх хэрэгтэй. Ихэвчлэн хохирогчид тулгарч буй асуудал, холбогдох түүхэн мэдээлэл, үйлчилгээнд хамрагдаж буй шалтгаан, даван туулах чадвар, амиа хорлох эрсдэл гэх мэт зүйлийг хянан үзэх 1-2 удаагийн (эсвэл хохирогчоос хамаарч түүнээс олон) нөхцөл байдлын үнэлгээ хийсний дараа зөвлөгөөний зорилгыг тодорхойлно.

Зөвлөгөөний зорилго нь хохирогчийн давуу талд тулгуурласан, бодитой, энгийн, хэмжигдэхүйц, чадваржуулахад чиглэгдэх нь зүйтэй. Зөвлөгөөний төлөвлөгөө нь тодорхой аргачлалтай байж, хохирогчийн гаргаж буй ахиц, эсвэл огт ахиц гаргахгүй байгааг ч үнэлэх хэрэгсэл болдог. Тухайлбал:

- Хохирогчийн сонгосон үр дүнг томъёолох
- Зорилгоо тодорхойлж судлах
- Аль нь чухал гэдгээ, юунаас эхлэхээ эрэмбэлэх
- Зорилго эцсийн байдлаар хамтдаа шийдэхэд чиглэгддэг.

Асуух, ажиглах, сонсох: хүчирхийллийг таслан зогсоох, тусламж авахын тулд тэд аль алхмыг хийсэн бэ?

- Тэр тантай ярихаас өмнө хэн нэгэнтэй хүчирхийллийн талаар ярьсан уу?
- Тэр урьд нь хүчирхийллийн талаар мэдээлсэн үү?
- Тэр нийгмийн халамжаас тусламж авсан уу?
- Тэр өмнө нь хамгаалах байранд байсан уу?
- Түүнд хэн тусалсан бэ?

Хүчирхийллийн хохирогчдод сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, тусламж авсан эсэх, гэм буруутай мэт төрсөн мэдрэмжийг арилгахад туслах, түүний сэтгэл хөдлөл, хүсэл сонирхол, хэрэгцээний талаар ярилцах хэрэгтэй.

Асуудлыг задлан шинжлэх:

Саад бэрхшээл, хүчирхийлэл бий болсон шалтгааныг задлан шинжих, түүнийг шийдвэрлэх арга замыг боловсруулах, хэрэгжүүлэх.



**Анхаарах асуудал:**

- Хохирогч, гэр бүлийн гишүүдийн одоогийн амьдралд бодитой оршиж байгаа давуу болон сул талыг тодорхойлох
- Үүсэж бий болсон асуудал бэрхшээлээс гарахад ашиглаж болох гадаад болон дотоод нөөц боломжийг илрүүлэх
- Тухайн гэр бүлийн гишүүд зөрчилдөх болсон үндсэн шалтгаанд дүн шинжилгээ хийх
- Зөвлөгөөний өмнөх үе шатанд нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн гаргасан дүгнэлтийг хохирогчтойгоо хамтран хэлэлцэж, түүний бодол санааг сонсох
- Нийгмийн ажилтан - хохирогч хоёр хамтран ажиллаж, үүсэж бий болсон таагүй байдал, зөрчлийг даван туулах арга зам, хувилбаруудыг боловсруулж хэлэлцэх
- Асуудлыг шийдвэрлэж болох хувилбар тус бүрийг үнэлж, түүний давуу болон сул талыг тодорхойлох
- Тухайн нөхцөл байдал, хохирогчийн одоогийн нөөц боломж, хүсэл эрмэлзэлд нийцэж байгаа хамгийн оновчтой гэсэн хувилбарыг сонгон авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах
- Гаргасан шийдвэр буюу сонголтоо хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах
- Уг шийдвэр сонголтыг амьдралд хэрэгжүүлэхийн тулд гэр бүлийн гишүүдийн зүгээс хүлээх үүрэг хариуцлагын талаар ярилцаж тохирох
- Гаргасан шийдвэрээ амьдралд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн гэрийн даалгавар болон бодит ажлуудыг төлөвлөж боловсруулах, хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, бататгах

**Зөвлөгөөний төлөвлөгөө:**

Зорилго: Хохирогчийн гаргахыг хүсэж буй ахиц (тэдний мэдрэмжийг өөрчлөх бөгөөд хохирогчид тулгарч буй асуудалтай холбоотой). Жишээ нь: Хохирогчийн сэтгэл гутралын мэдрэмжийг багасгах, айдас түгшүүрийг багасгах, нийгмийн ур чадварыг нэмэгдүүлэх гэх мэт.

Богино хугацааны зорилго: Зөвлөгөөний эхний хэдэн сарын хугацаанд бодитоор хүрч болох зорилго.

Урт хугацааны зорилго: Зөвхөн урт хугацаанд (зургаан сар эсвэл нэг жил) хүрч болох, тухайн хохирогчийн хүрэхийг зорьж чармайж байгаа зорилго.

Зорилт: Зорилт бол зөвлөгөөний зорилгодоо хүрэхийн тулд таны зааварчилгын дагуу хохирогчийн өөрийнх нь хийх алхмууд юм. Жишээ нь: амьсгалын дасгал хийх, найз нөхөдтэйгээ ярилцах, өөрийгөө баярлуулдаг зүйлийг зурах, хөгжим сонсох гэх мэт

Үр дүн: Зорилгодоо хүрснийг илтгэх, хэмжиж болохуйц үр дагавар. Жишээ нь: уур уцаар бага мэдрэх, өөрийгөө үнэлэх үнэлэмж дээшлэх, шөнө уйлах нь багасах гэх мэт.

Зөвлөгөөний туршид зорилго өөрчлөгдөх тохиолдол олонтоо гардаг бөгөөд зөвлөгөөний төлөвлөгөө нь үргэлж зөвлөгч, хохирогчийн хоорондын “дуусдаггүй ажил” байдаг. Тиймээс зөвлөгөөний төлөвлөгөө нь хэтэрхий хатуу, яг таг байх зохисгүй. Энэ шалтгааны улмаас зөвлөгч, хохирогч хоёр зөвлөгөөний явцад зөвлөгөөний төлөвлөгөөг үе үе үнэлдэг байх хэрэгтэй.

Тухайн хохирогчтой хамтран хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийллийн харилцааг орхиход чиглэсэн алхмуудыг хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой нөөцүүдийг (дэмжих сүлжээ, орон сууц, санхүү, ажил эрхлэлт, мэдээлэл гэх мэт) судалж үзнэ. Тусламж авах, дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн хөтөлбөрийн талаарх мэдээллээр хангах (байгууллага, төрийн бус байгууллага, журам) хэрэгтэй.



Хохирогчтой хамт хүчирхийллийг таслан зогсоох, шаардлагатай тусламж, дэмжлэг авахын тулд цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллахдаа:

- Тэдний гаргасан шийдвэрийг дэмжиж, хүндэтгэх
- Таны алхам юу болохыг тэдэнд хэлээрэй (хэрэв та цагдаад мэдээлэх үүрэгтэй бол г.м.)
- Яаралтай үед, амь насанд шууд аюул заналхийлж байгаа эсвэл цагдаагийн оролцоо шаардлагатай тохиолдолд цагдаа дууд!
- Хохирогчтой хамт аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулна.

Аюулгүй байдлын төлөвлөгөө нь хүчирхийлэл гарсан тухайн тохиолдолд хохирогч хэрхэн өөрийн аюулгүй байдлыг хамгаалах талаар тодорхойлоход тэдэнд туслах арга зам юм. Аюулгүйн байдлын төлөвлөгөө нь асуудлыг шийдвэрлэх урт хугацааны шийдэл болж чадахгүй. Гэсэн хэдий ч хохирогчид тухайн тохиолдолд аюулгүйн төлөвлөгөөг ашиглах нь тустайгаас гадна тэд өөртөө туслах талаар бодож, өөрийгөө дайчлахад ач холбогдолтой. Энэхүү төлөвлөгөөг гаргахад хохирогч асуудал шийдвэрлэх явцад оролцох ба өөрийн аюулгүй байдлыг хамгаалахад оролцсоноор тэдний өөрийн үнэлэмж дээшлэхэд эергээр нөлөөлнө. Аюулгүйн байдлын төлөвлөгөө нь хохирогчид туслах зорилгоор хийгдэж байгаа бөгөөд энэ нь нийгмийн ажилтны ашиглаж буй арга юм.

.Аюулгүйн байдлын төлөвлөгөө гаргахад тус болох 5 асуулыг асуух хэрэгтэй.

- Хүчирхийлэл гарахаас өмнө ямар зүйл хүчирхийлэл үйлдэгдэх дохио, сэжүүр болдог вэ? (хүчирхийлэгч архи уух, мансуурах бодис хэрэглэх, уурлаж бухимдах нь ихсэх, үг хэлээр дайрч доромжлох, хэзээ гэх мэт)
- Та өөрийгөө болон хүүхдээ хамгаалахын тулд өмнө нь ямар арга хэмжээ авч байсан бэ? Энэ арга нь эрсдэлээс хамгаалах боломжтой арга хэмжээ болж байсан уу?
- Та хаанаас, хэнээс туслалцаа хүсэж ханддаг вэ? Таныг өмөөрч хамгаалдаг гэр бүл, найз нөхөд байдаг уу, ямар байгууллагад ханддаг вэ?, гэрээсээ явлаа гэхэд хаашаа явдаг вэ?
- Хуулийн дагуу ямар үйлчилгээнд болон мэргэжилтэнд хандаж болох талаар хохирогч мэдэж байна уу? (цагдаад хандах, яаралтай тусламж авах утас 107 уруу утасдах, шүүхийн хамгаалалтад орох гэх мэт)
- Эмнэлгийн яаралтай тусламж авах бол хаашаа хандаж явахаа мэдэж байна уу? Ойролцоох эмнэлэг, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх байгууллагыг мэдэж байна уу?

Хэрвээ хохирогч хүчирхийлэлтэй харилцаанд байгаа бол дараах зүйлсийн талаар бодож үзэхийг зөвлөнө.

1. Өөрийнхөө болон хүүхдүүдийнхээ төлөө чухал шаардлагатай утасны дугааруудыг ойр байлгах, үүнд: цагдаа, шууд утас, найз нөхөд болон орон нутгийн хамгаалах байр.
2. Хүчирхийллийн талаар хэлж болох найз нөхөд ба хөршүүд. Хэрүүл маргаан, эсвэл хүч хэрэглэж буй чимээ гарвал цагдаа руу залгаж байхыг тэднээс хүсэх. Хэрвээ хүүхэдтэй бол 102, 107, 108 руу яаж залгахыг зааж өгөх. Тусламж хэрэгтэй үедээ ашиглаж болох нууц үг бодож олох.
3. Гэрээсээ хэрхэн аюулгүй гарч явах вэ? Гэрээсээ аюулгүй гарч явах дасгал хийх.
4. Танай гэрийн гарах гарц бүхий аюулгүй газрууд. Хэрэв та хүчирхийлэл болох гэж байна гэж мэдэрвэл тэдгээр аюулгүй газруудын нэгэнд нь хүчирхийлэгчээ аваачихыг хичээ.



5. Гэрт байгаа хүйтэн зэвсэг, тэдгээрийг гэрээсээ холдуулах аргын талаар бодох.
6. Гэрээсээ явах төлөвлөгөөгүй байгаа ч гэсэн хаашаа явж болох талаар, яаж гарч болох талаар бодох. Гэрээс гарах шалтгаануудыг бодож олж турших (хог хаях, нохойгоо салхилуулах, дэлгүүр явах, хүүхдээ цэцэрлэг, сургуулиас авах зэргээр турших. Өдөр тутам хэрэглэдэг зүйлсээ нэг дор цүнхэнд хийж, авахад хялбар газар нуух
7. Аюулгүй байдлын төлөвлөгөөгөө дахин нарийвчлан шалгах

Аюулгүй байдлын төлөвлөгөө:

- Гал тогооны өрөөнөөс зайлсхийх (хутга сэрээ гэх мэт хүчирхийлэгч зэвсэг болгон ашиглаж болох зүйл байдаг).
- Гарах арга байхгүй өрөө, угаалгын өрөө гэх мэт газраас зайлсхий.
- Буу зэвсэг хадгалагдаж байгаа өрөөнөөс зайлсхий.
- Хүүхдүүд байгаа өрөөнд бүү оруул, учир нь хүчирхийлэгч тэднийг гэмтээж болзошгүй. Тэднийг холдуулж, өөрт туслахыг хичээх хэрэггүй гэдгийг ойлгуул. Хэрэв хүүхдүүд том болсон бол та цагдаа дуудаж сургах хэрэгтэй.
- Чухал ач холбогдолтой баримт бичиг (иргэний үнэмлэх, гадаад паспорт, эрүүл мэндийн дэвтэр, жолооны үнэмлэх гэх мэт) болон таны болон хүүхдүүдийн байнга уудаг хэрэглэдэг эмийг үргэлж авч явах (эсвэл яаралтай гарахдаа авах боломжтой газар тавих).
- Хүчирхийлэл хүнд ноцтой болсон үед юу хийж болох талаар хүүхдүүдтэйгээ ярилцаарай (хөршүүд рүүгээ явах уу, цагдаа дуудах уу гэх мэт).

Зөвлөгөөний төлөвлөгөөний товч жишээ:

Зорилго	Зорилгод хүрэх үйлчилгээ	Хүрэх үр дүн
Богино хугацааны зорилго1. Хохирогчийн түгшүүрийг бууруулах	Хямралын үеийн интервенц үзүүлэх	Хохирогчийн түгшүүр, хямралын түвшин буурна.
Богино хугацааны зорилго 2. Өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх, давуу талаа олж харах	Хохирогч өөрийн дотоод мэдрэмж, сэтгэл хөдлөлөө ойлгох, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх, давуу талаа олж харахад туслах урлагийн сэтгэл заслын арга техникүүдийг хэрэглэх	Хохирогч өөрийгөө танин мэдэж, давуу тал, нөөц боломжоо олж харснаар өөртөө итгэх итгэл нь нэмэгдэнэ.
Урт хугацааны зорилго1. Хохирогчийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, хохирогч тогтмол ажилтай болох	Холбогдох нийгмийн үйлчилгээний байгууллагуудад холбон зуучлах	Хохирогч гэр бүлийн асуудалдаа санаа зовох нь багасна. Цаашид өөдрөг амьдрах хүсэл эрмэлзэлтэй болсон байна.

IV) Зөвлөгөөний зорилго, шийдвэрийн хэрэгжилт

Дээрх төлөвлөгөөний дагуу зөвлөгч нь хохирогчтой ажиллаж болно. Мөн зөвлөгөөний явцад хохирогчийн давуу болон сул талуудыг ярилцах, нийгэм, соёлын нөөц дээр тулгуурлан ажиллах, даван туулах стратегийг ашиглаж болно. Түүнчлэн зөвлөгөөний явцад төлөвлөгөөний дагуу цагийн хуваарийг тогтох, уулзалтыг таслахгүй байхад анхаарах хэрэгтэй.

V) Зөвлөгөө өгөх үйл явцыг дуусгах, үнэлэх

Хохирогчид зөвлөгөөг дуусгах талаар урьдчилан хэлсэн байх шаардлагатай бөгөөд зөвлөгөөний үйл явцыг бүхэлд нь нэгтгэн дүгнэнэ. Хохирогчийг зөвлөгчид итгэж асуудлаа ярьсан явдалд талархаж байгаагаа илэрхийлээрэй. Ямар ч тохиолдолд танд ахин хандаж болох бөгөөд туслахад хэзээ ч бэлэн гэдгээ ойлгуулаарай.

Зөвлөгөөг төгсгөхдөө эергээр дуусгахад анхаарна.

- Зөвлөгөөг дуусгах талаар урьдчилан хэлэх
- Зөвлөгөө өгөх үйл явцыг бүхэлд нь нэгтгэн дүгнэх
- Эергээр дуусгахад анхаарах санал зөвлөмж өгөх
- Зөвлөгөө дууссаны дараах шилжилтийн үе шатны талаар ярилцах
- Туслахад хэзээ ч бэлэн гэдгээ ойлгуулах

Гэр бүлийн гишүүд, олон нийтийг жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч болоход нөлөөлж буй сэтгэлзүйн болон нийгмийн хүчин зүйлийг ойлгуулахын тулд тэдэнд сургалт явуулах, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд туслах явдал нь хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд ач тустай. Түүнчлэн хохирогчийн гэрт тогтмол очиж уулзах замаар гэр бүл, бүлэг, олон нийтэд нийгэмшүүлэх ажлыг дэмжих нь зүйтэй.

Зөвлөгөөний төгсгөл үе шатанд зөвлөгөөний үр дүнг үнэлж дүгнэнэ.

Анхаарах асуудал:

- гаргасан шийдвэр сонголтынхоо хэрэгжилт, явцыг тооцож үнэлэх
- нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран ажилласан хугацаанд гарсан ахиц амжилтыг дүгнэж, цаашдын ажиллагааны талаар ярилцаж шийдвэрлэх
- гэр бүлд цаашид үүсэж болзошгүй асуудал, бэрхшээл, хүндрэлтэй зүйлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтарч ажиллах дараагийн шатны хөтөлбөр боловсруулах

Зөвлөгөөний үр дүнг үнэлэх шалгуур:

- Нөхцөл байдлын үнэлгээнд илэрч байсан асуудлын өөрчлөлтийн хэмжээ
- Гэр бүлд хүндрэл гарах болсон шалтгаан, үр дагаврыг бодитойгоор ойлгосон байдал
- Гэр бүлийн харилцаанд гарсан өөрчлөлт
- Гэр бүлийн гишүүдийн дотоод уур амьсгал, амьдрал сэргэн тогтворжиж буй байдал
- Үүсэж бий болж байгаа асуудлыг цаашид бие даан шийдвэрлэх чадварын өсөлт, ухаарал г.м.

Баримтжуулалт

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн мэдээллийг бүртгэх нь зөвлөгч болон нийгмийн ажилтнуудад хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

1. Эмэгтэй хүн аюулгүйн хамгаалалт авахыг хүсэж байгаа болон түүний хамтрагч нь гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд энэхүү бүртгэл нь шүүхэд баримт бичиг болдог.
2. Хосууд тусдаа байгаа тохиолдолд хүүхдийг асран хамгаалах талаар шүүхэд хандахад шаардлагатай байж болно.
3. Хохирогчийн талаарх мэдээлэлтэй байх нь ирээдүйд гэмтэл бэртэл авсан хүмүүсийн тухай мэдээллийн баазаас шалгаж үзэх боломж олгодог.



4. Эмнэлэгт хандсан бүртгэлийг хөтлөх нь хүчирхийллийн эрсдэлийн талаарх улаан дохио өгч буй хэлбэр юм.

Гэхдээ эдгээр бүртгэлийг хөтлөхийн тулд арвин туршлагатай байх хэрэгтэй.

Баримт бичиг, нотолгоог бүрдүүлэх:

Бүх төрлийн гэмтэл, шинэ болоод хуучин гэмтэл, гэмтлийн шинж, байршил зэргийг биеийн рентген зураг авхуулан тайлбарлах.

- Хохирогчоос хэрхэн яаж бэртсэн, хэн түүнийг гэмтээсэн талаар асууж товч тайлбарыг тэмдэглэх. Хүчирхийлэлд өртсөн хүний нэр болон хүчирхийлэгч хоорондын харилцааг асууж тэмдэглэх. Хүчирхийлэл болсон цаг хугацаа он сар газар зэргийг тэмдэглэх. Хэрэв гэрч байгаа бол гэрчээр бүртгэх. Баривчилсан, саатуулсан цагдаагийн нэр, дугаар ашигласан зэвсгийн дэлгэрэнгүй мэдээлэл, мөн гэрчийн мэдээлэл байгаа бол хавсарган бичнэ.
- Хохирогчоос ямар нэг хүчирхийлэлд өмнө нь холбогдож байсныг асууж түүхийг бичих.
- Хэрэв бэртэл гэмтэл нь хохирогчийн өгсөн мэдэгдэлд нийцэхгүй байгаа бол хохирогчийн мэдэгдэл, бэртэл гэмтлийн байдлыг цуг тэмдэглэнэ. Хохирогчийн өгсөн тайлбар нь өөрийн үзлэгтэй нийцэж байгаа эсэхийг эмч тэмдэглэнэ.
- Хохирогчийн гэмтлийн шалтгааныг тайлбарлахдаа шүүхийн бус нэр томъёог ашиглана.
- Гэмтлийг гэрэл зургаар баримтжуулахдаа гэмтлийн гэрэл зургийг шаардлага хангасан камераар авч, зураг авсан хүн гарын үсэг зурж баталгаажуулах ёстой.
- Биет нотолгоог хадгалах ¹⁹

Гэмтэл бэртлийн зургийг хэрхэн авах вэ?

- Гэмтлийн зургийг хамгийн тохиромжтой газраас камер ашиглан авах.
- Хэрэв шууд дүрс бичлэг хийх камер байхгүй бол нэг удаагийн камер ашиглаж болох боловч мэргэжлийн лабораторид зайлшгүй угаалгах шаардлагатай. (Нууцлалыг алдахгүй байх) Хэргийн дараа нотлох баримт шаардлагатай бол камерыг цагдаагийн байгууллагад шилжүүлэх боломжтой байх ёстой.
- Зураг авахдаа дарааллыг тэмдэглэнэ. Эхнийх нь хохирогчийн нүүр царай байх ба зургийн ар талд он сар, цагийг тэмдэглэсэн байх ёстой (1,2 г.м). Зураг авсан хүний гарын үсэг болон хохирогчийн гарын үсэг хамт байж болно. Бүх зургийг дарааллаар авах бөгөөд дээрх тэмдэглэгээнүүдийг хийнэ.
- Зургийг хохирогчоос зөвшөөрөл авсны дараа авах ёстой бөгөөд цаашид энэхүү зураг нь нотлох баримт болно гэдгийг мэдэгдэх ёстой. Шүүх танхимд зарим тохиолдолд нээлттэй хэрэглэдэг талаар ч мэдээлэх хэрэгтэй.
- Хохирогч заримдаа гэрэл зураг авхуулахыг хүсдэггүй. Тэр тохиолдолд тухайн хохирогчийн хүсэлтийг хүндэлнэ.
- Хохирогч олон тооны бэртэлтэй, бэртэл гэмтэл нь бие биетэйгээ хэрхэн холбогдож байгаа талаар харьцуулах, гэмтлийг системтэйгээр баримтжуулахад биеийн рентген зураг тустай.

¹⁹ Adapted from Domestic Violence: A Health Issue: Guidelines for Hospital Staff, 2004

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛБЭРҮҮД

Ганцаарчилсан зөвлөгөө:

- Хохирогчийг хүлээн авч уулзаж, тохиолдож бий болсон асуудлын талаар мэдээлэл авах
- Хохирогчийн санал хүсэлтийг сонсох
- Үүсэж бий болсон асуудлын шалтгааныг тодруулах
- Асуудал үүсэж бий болсон одоогийн нөхцөл байдалтай бодитойгоор танилцаж, эргэцүүлэн бодох боломжийг хохирогчид олгоход туслах
- Өөрийгөө болон гэр бүлийн одоогийн амьдралаа өөрчлөх хэрэгцээ сэдэл төрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Өөрийн “Би” төсөөллийг өөрчлөх, бэхжүүлэхэд туслах
- Өөртөө итгэх итгэлийг төрүүлэх, хувийн нөөц боломж, давуу талаа олж харах, түүнийгээ амьдрал ахуйдаа хэрэглэхэд туслах
- Одоогийн асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх арга зам, боломжуудыг эрэлхийлэх, хамтарч шийдвэр гаргах
- Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхэд туслах зэргээр хохирогчтой тулж ажиллахад ганцаарчилсан зөвлөгөөний хэлбэрийг голчлон хэрэглэдэг.

Ганцаарчилсан болон гэр бүлд түшиглэсэн нийгэм сэтгэл зүйн дэмжлэг:

1. Хүчирхийллийн хохирогчтой харилцах, зөвлөгөө өгөх үйл явцад тухайн хохирогчийн гэр бүлийн бүтэц, гишүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл хохирогчийн хувьд гэр бүлийн хүмүүс нь тайтгарал, тайвшрал авчрах, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх зэргээр нэмэр тус болдог.
2. Гэр бүлийг эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ. Энэ үйлчилгээг үзүүлэхдээ тухайн нөхцөл байдал, гэр бүлийн хүмүүсийн харилцаа, хүчирхийллийн төлөв байдал, цар хүрээг харгалзан үзнэ. Мөн соёл, ёс заншил, тогтсон ойлголт хандлагыг анхааран үзэх хэрэгтэй. Бүх ёс заншил, хандлага ойлголтыг зөв гэж үзэхгүй бөгөөд ялангуяа ихэнх улс орны хувьд зарим ёс заншил, тогтсон ойлголт эмэгтэйчүүдэд халтай тэдний эсрэг байдгийг хатуу анхаарах хэрэгтэй.
3. Ажилтнууд. Хүчирхийллийн хохирогчтой ажиллах үүрэг хүлээсэн хүмүүс хохирогчид сэтгэлзүйн болон нийгмийн бусад ямар үйлчилгээнд хамрагдахыг холбон зуучилж өгнө. Хохирогчид нь танин мэдэхүйн, зан үйлийн зэрэг эмчилгээ засал шаардлагатай байдаг бөгөөд ажилтнууд энэ үйлчилгээг санал болгох, үйлчилгээнд хамруулах ажлыг хийх ёстой. Эдгээр эмчилгээ, үйлчилгээ, засал нь тухайн хохирогчийн итгэл найдварыг сэргээх, өдөр тутмын хэвийн амьдралд эргүүлэн оруулахад тусалдаг.

Бүлгийн зөвлөгөө:

- Ижил төстэй асуудалтай хүмүүс сайн дураараа нэгдэж нэг бүлэг болсон тохиолдолд
- Бүлгийн гишүүдийн тоо 6-8 байх
- Бүлгийн зөвлөгөөг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч хөтлөн явуулна
- Бүлгээр ажиллах үед ижил төстэй асуудалтай хүмүүс нэг багт нэгддэг учраас тохиолдож байгаа бэрхшээл асуудлаа илэн далангүй ярилцах, бие биеэсээ суралцах, туршлага арга барилаа солилцох, сэтгэл санааны дэмжлэг нөлөөлөл үзүүлэх, шийдвэрлэх арга зам, хувилбарыг хамтарч боловсруулахад илүү тохиромжтой.
- Баг бүрдүүлэх, багийн гишүүдтэй хамтарч ажиллахад цаг хугацаа, мэргэжлийн бэлтгэл, зохион байгуулах чадвар шаардагддаг.



**Бүлгийн зөвлөгөөний зорилго:**

- Бүлгийн зөвлөгөө өгөх нь бүлгүүдэд дараах зүйлийг хийх боломжийг олгодог.
- Тэдний амьдралд нөлөөлж буй мэдээлэл, асуудлыг хуваалцах.
- Зан үйл, бүтцийн болон / эсвэл сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийг бий болгох.
- Нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйлийг бүрдүүлэх, дагаж мөрдөх.
- Асуудлыг шийдвэрлэх ур чадварыг дээшлүүлж, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх
- Мэдрэмжийг хуваалцах (ярилцах гэх мэт) бий болгох
- Санаа бодол, сэтгэл хөдлөл, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох
- Бусад хүмүүс, тэдний үзэл бодлыг ойлгож сурах, бусдыг хүндэтгэхийг уриалах
- Үе тэнгийнхэнтэйгээ харилцах нийгмийн чадвар эзэмших

Бүлгийн зөвлөгчийн үүрэг:

1. Харилцааны явц ба урсгалыг чиглүүлдэг байх
2. Бүх оролцогчдод үг хэлэх тэгш боломж олгоно; дэмжиж өгдөг, хүн бүр өөрийн санал бодлоо хэлэх / үг хэлэх, дагаж мөрдөх цаг хугацаатай байх
3. Оролцогчдыг айлган сүрдүүлэх, заналхийлэхгүй байх
4. Гишүүд бусдынхаа санаа бодлыг сонсдог эсэхийг шалгах
5. Одоогийн үе шатыг үе үе нэгтгэн дүгнэдэг
6. Өөрийн шийдэл, зөвлөгөөг санал болгохоос зайлсхийх
7. Бүлгийн гэрээг бичгээр үйлдэнэ, бүгдээс нь асууна, бүлгийн гишүүдийн гарын үсгээр баталгаажих
8. Холбоос хийх замаар хэлэлцүүлгийн агуулгыг тодруулах, тодорхойлох, дүгнэх
10. Мэдээллийг өөрчлөн шинэчлэх, тодруулахад тусалдаг, эсвэл шаардлагатай бол шийдлийг олоход тусална.

Бүлгийн дэмжлэг. Энэ нь ижил буюу төстэй (хүчирхийллийн хохирогч болсон) асуудалтай хүмүүс өөрсдийн асуудлаа ярьж, хүчирхийллийг хэрхэн даван туулах болон хэрхэн даван туулсан талаар мэдлэг туршлагаа хуваалцах боломжийг олгодог.

Хүчирхийллийн хохирогч болон эрсдэлийн хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, хүмүүс санал бодлоо солилцох боломжийг олгох нь ихээхэн ач холбогдолтой. Энэ үйл ажиллагааны хүрээнд олон нийтийг идэвхжүүлэх, эмэгтэйчүүдийн дэмжих бүлгүүд, асуудал шийдвэрлэх, даван туулах өөртөө туслах бүлгүүдийг зохион байгуулах нь чухал.

Олон нийтэд түшиглэсэн зөвлөгөөг хэзээ хэрэглэх вэ?

Олон нийтэд түшиглэсэн зөвлөгөө нь:

- Эцэг нь хүүхдээ зоддог учраас хүүхэд нь гэрээсээ зугтахыг хүсдэг мөн өөрт нь туслах хэн нэгэнтэй ярих шаардлагатай байгаа тохиолдолд. Түүнд гэрээсээ гараад очих байх газар хэрэгтэй байгаа үед;
- Найз залуу нь өсвөр насны жирэмсэн охинтойгоо хамт байхыг хүсэхгүй орхиод явсан тохиолдолд;
- Нөхөр нь дагавар охиноо гэрээсээ хөөж, мөнгө олох хэрэгтэй гэж байнга дарамталдаг талаар ээж нь зөвлөгөө авахаар хандаж байгаа тохиолдолд.



Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. Үүнд олон нийтийн гишүүд, гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид энэ асуудлаар болон тэдэнд үзүүлэх үйлчилгээний талаар (урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх тусламж, дэмжлэг, үйлчилгээ, интервенц) мэдээлэл солилцдог хэвлэл, цахим болон нийгмийн мэдээллийн хэрэгслүүд багтдаг. Жишээлбэл Радио ток шоу нь хүчирхийлэл, түүний хор хөнөөлийн талаар ярилцлага хэлэлцүүлэгт олон нийтийг оролцуулах, ярилцах, санал бодлоо илэрхийлэх боломжийг олгодог. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийт төдийгүй хохирогчдод сэтгэлзүйн боловсрол олгох боломжтой.

Олон нийтэд түшиглэсэн нийгэм-сэтгэл зүйн тусламж дэмжлэг

Хүчирхийллийн хохирогчдод ялангуяа залуу хүмүүсийн хувьд сонирхол татахуйц үйл ажиллагаа явуулах нь үр дүнтэй, богино хугацаанд хэвийн байдалд оруулах ач холбогдолтой байдаг. Хөгжим, бүжиг, драм зэрэг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь залуучуудыг тодорхой цаг хугацаа, тодорхой газар, хүрээлэл эсвэл албан бус орон зайд өөрсдийгөө аюулгүй гэдгээ мэдрэх, өөрсдийн асуудлаа даван туулах боломжийг олгодог. Залуучуудын хувьд хүчирхийллийг даван туулахад үе тэнгийнхний дэмжлэг хамгийн чухал. Мэргэжлийн нийгмийн ажилтнуудаас гадна бэлтгэгдсэн сайн дурынхан эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой.

Олон нийтэд түшиглэсэн зөвлөгөөнд анхаарах асуудал:

- Олон нийтэд түшиглэсэн зөвлөгөө нь орон нутагт албан бус нөхцөлд хийгдэх ёстой. Зөвлөгч нь орон нутгийн манлайлагч, багш, лам, үе тэнгийн зөвлөгч, ээж гэх мэт бусдад хүндлэгдсэн хүн байж болно. Гэхдээ тэд мэргэжлийн зөвлөгчийн удирдлага зааварчилга доор ажиллах ёстойг анхаарах хэрэгтэй.
- Гэр бүл, нийгэм дэх хувь хүний стресс, дарамтыг бууруулах зорилготой зөвлөгөө дэмжлэгийг албан бус нөхцөлд өгөх боломжийг нийгэм, олон нийтэд олгох хэрэгтэй. Олон нийтэд түшиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хүмүүст анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах ёстой.
- Шаардлагатай тохиолдолд асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад олон нийтийн гишүүдэд тусламж үзүүлнэ. Энэ нь (идэвхтэй) сонсох, ярих, тэвчээртэй хандах, хүндэтгэлтэй хандах, асуудлыг шийдвэрлэх чадварыг бий болох, хөгжүүлэх, даван туулах стратегиар дамжуулан хэрэгждэг.
- Зөвлөгөө өгөхдөө тухайн орон нутгийн нөөц, хүмүүсийн чадвар, давуу талыг хамгийн сайн ашиглах механизмыг бий болгох.





СЭДЭВ 3.2 ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД УРЛАГИЙН СЭТГЭЛ ЗАСЛЫН АРГААР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ

Хичээлийн зорилго:

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчидтой ажиллахдаа арт терапи хэрэглэх, хэрэгцээ, шаардлагын талаар мэдээлэл өгөх

Үндсэн ойлголтууд:

- Урлагийн сэтгэл заслыг ашиглахад шаардлагатай орчин ба арга хэрэгслүүд
- Хохирогчид зөвлөгөө өгөхөд энэ аргыг ашиглахад зөвлөгчийн анхаарвал зохих зүйлүүд
- Арт терапи үйлчилгээ үзүүлэхэд урлагийн хэрэгслийг ашиглахуй

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Оролцооны аргад тулгуурлаж ажиллана.

Унших материал:

- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, Бүлэг III

Хэрэглэгдэхүүн:

- Дасгал тус бүр дээрх хэрэглэгдэхүүн



ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД УРЛАГИЙН СЭТГЭЛ ЗАСЛЫН АРГААР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ

Бидний амьдралд тохиолдсон үйл явдлууд ихэвчлэн үгэн бус байдлаар хадгалагддаг. Тухайлбал, нүүр царайны хувирлууд, хоолойны өнгө, төрх байдал, биеийн хөдөлгөөн, үнэр зэргээр хадгалагдана. Жишээлбэл тодорхой нэг үнэр хэн нэгэн, ямар нэгэн газар, үйл явдлыг бидэнд санагдуулдаг. Тодорхой нэг төрх байдал бидэнд тайвшралыг авчирна эсвэл эсрэгээрээ сэтгэл санааг тавгүй болгодог шүү дээ.

Бидний амьдралд баяртай үйл явдал тохиолдоход бид зөвхөн үгээр бус харин биед төрөх сэрэл мэдрэмжээр дурсамж болгон хадгалдаг. Яг л бие маань биднээс тусдаа ой санамжтай мэт. Тэгвэл баяр хөөрийн мэдрэмж хадгалагдаж байгаа бол айдас, түгшилт ч мөн тийм маягаар хадгалагддагийг санах нь зүйтэй. Хэрэв бид дурсамжийг зураглал хэлбэрээр эсвэл мэдрэхүйн бусад хэлбэрээр хадгалдаг юм бол яагаад асуудал, хар бараан дурсамжийг **үгээр, ухаанаар засварлах** гэж оролдоод байгаа талаар эргэцүүлье.

Дурсамж зөвхөн бодол, үгээр бус бидний **бүх мэдрэхүй, хүртэхүйгээр** дамжин хадгалагддагийг санацгаая. Нэгэн тодорхой жишээ авъя. Манай улсад одоогоос 10-аад жилийн өмнө 7-р сарын 1 - д болсон үймээнийг эргэн саная. Тэрхүү үйл явдлыг бодоход үгнээс илүү тухайн үеийн дүр зураг бууж байгаа. Жишээлбэл: утааны үнэр, хатуу чулуу, галын хар дөл, хүмүүсийн айсан царай гэх мэт. Харин энэхүү үйл явдлыг үгээр илэрхийлүүлж гаргахад зарим хүнд тун хүндрэлтэй байдаг. Магадгүй тэд энэ үйл явдлын талаар дахин хэзээ ч ярихыг хүсэхгүй байгаа. Тэгвэл бид тэднийг үгээр илэрхийлж яриулах нь тэдний сэтгэлийн гүнд байгаа **шархыг эргэн сэдрээж** байна гэсэн үг юм. Харин бид шаардлагатай тохиолдолд тэднийг тухайн үйл явдлын талаар сэтгэл хөдлөл, мэдрэмжийн талаар **өнгө, хэлбэр, дүрс, үлгэр, тоглоом зэргээр** илэрхийлүүлэхэд тэд аюулгүй бөгөөд тайван байх зуураа өөр өнцгөөс харах боломж бүрддэг.

Тийм учраас олон улсын сэтгэцийн эрүүл мэндийн салбарт арт терапи буюу урлагийн сэтгэл заслыг үг, хэл яриагаар илэрхийлдэг аргаас илүү үр дүнтэй гэж үзэж байна²⁰. Нэн ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, насанд хүрэгчдэд хамгийн үр дүнтэй арга гэж үздэг (Malchiodi, 1997, 2001; van der Kolk, 2002). Учир нь хүний бие махбод бидний тархитай адил өөрийн гэсэн ой, санамжтай гэж тэд үздэг. Тэрхүү бие махбодод буй ой санамж нь мэдрэхүйн эрхтнүүдээрээ дамжин тухайн хүнд тохиолдсон аймшигтай үйл явдлуудыг өнгө, хэлбэр, дүрс, үнэр, амт зэргээр нь хадгалдаг. Цаашилбал бие махбодод нөхөн сэргээх, амьд байхад юу хэрэгтэй байгааг ч мэдээд зогсохгүй хариу үйлдэл үзүүлдэг.

Өөрөөр хэлбэл хүүхэд, насанд хүрэгчид биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөх, таагүй нөхцөлүүдийн гэрч болох буюу байнгын дарамт шахалт, үл хайхралд өртөх үед тухайн үйл явдал болж байх үеийн **дүр зураг, үнэр, амт, өнгө, хэлбэр дүрс** нь үгнээс илүү хүний биеийн мэдрэхүйн эрхтнүүдээр дамжин бие махбодод хадгалагдсан байдаг тул энэ хэлбэржилтийг эвдэхэд **үг яриа** төдийлөн үр дүнтэй биш гэж сэтгэл судлал болон сэтгэл заслын нөлөө бүхий эрдэмтэд (Карл Юнг, Зигмуд Фрейд, Кейти Малкиоди, Глинда Нийдс) баталсан.

Тэгвэл арт терапевтууд хохирогчийг хязгааргүй олон урлагийн хэрэгслийг (усан будаг, багс, бийр, цаас, өнгө, баримлын шавар, хөгжим, хөдөлгөөн, зэрэг) ашиглаж байх явцад түүнд үзүүлж байгаа хариу үйлдлүүдийг анзаарч ажилладаг. Ийнхүү арт терапевсттай ажиллаж байх явцдаа хүн өөрийнхөө мэддэггүй байсан зүйлээ мэдэж авах, эргэн санах, ухамсарлах, эргэцүүлэн бодох, үгээр илэрхийлж болохгүй байсан зүйлээ ойлгох, амьдралын түүхээ өгүүлэх зэрэг боломжийг олж авдаг. Энэ нь тэдэнд өөрийгөө үгэн бус байдлаар илэрхийлэх, бусдад өөрийгөө ойлгуулах, бусадтай харилцах сайхан боломж олгодог юм.

20 Appleton, 2001; Eth&Pynoos, 1985; Pifalo, 2002





Арт терапи буюу урлагийн сэтгэл заслын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулагчдын нэг Австрали улсын арт терапевт Глинда Нийдс хэлэхдээ “Гэнэтийн аймшигтай үйл явдал нь хүний тархинд хүчтэй нөлөөлж тухайн үйл явдлын талаар бодох, эргэцүүлэх, зохицуулахад нь сөргөөр нөлөөлдөг”. Жишээлбэл: алан хядлага харсан хүнд харсан зүйлээ үгээр хэлж илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг учраас тэд гацаж, цочиж, балмагдаж зарим нь хэлгүй болдог. Энэ үйл явдал нь мэдрэхүйн эрхтнүүдээр дамжин тархинд хадгалагдахаас гадна хүний биед хадгалагддаг учраас тэрхүү мэдрэмжүүд нь ямар нэг хэлбэр дүрсээр бууж хадгалагддаг байна. Энэ үед түүнийг үг, хэл яриагаар хэлж илэрхийлүүлэхэд хүндрэлтэй²¹. Тэрхүү нэгэнт хүний биед шууд өнгө, хэлбэр дүрс, бэлэг тэмдэг маягаар хадгалагдсан зүйлийг үгээр гаргуулах гэж оролдох нь утгагүй бөгөөд хохирогчийн асуудлыг сэдэрэх аюултай тул хохирогчийн сэтгэл зүй, оюун ухаантай нь ажиллахаас гадна биеийг дасгалжуулж, дадлагажуулах эмчилгээ, нөхөн сэргээх нь чухал²². Тийм учраас арт терапевстууд сэтгэцийн эмгэгийг эмчлэх, нөхөн сэргээхэд хүнийг бүтээлч байлгах, энгийн зураг зурахад ч эерэгээр нөлөөлөх, танин мэдэх, сэтгэл хөдлөлөө илэрхийлүүлэхийг шаарддаг²³. Тэгвэл хохирогчийн өөрийн бүтээсэн урлагийн бүтээл нь тэдэнд танин мэдэх, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, мэдрэмжээ ойлгох, өөрийн амьдралын түүхээ эргэн харах, эргэцүүлэх, хүүрнэх, асуудлын гарц шийдлээ өөрөө олж харах боломж олгодог давуу талтай гэж үзжээ (Malchiodi, 2003, p. 21).

Сэтгэцийн эрүүл мэндийн эрдэмтэд урлагийн сэтгэл засал нь хүүхдүүдэд илүү тохиромжтой гэж үздэг. Учир нь тэд төрөлхийн үгэн болон үгэн бус хэлбэрээр юу мэддэг, юу мэдэрч байгаагаа маш сайн илэрхийлж чадна. Мөн арт терапевстууд хүүхдэд аюулгүй буюу эмзэглүүлэхгүйгээр тэдний дуртай хэрэгслийг ашиглан ажиллаж хүүхдийн амьдралд үлдсэн хар толбыг арилгах, нөхөн сэргээх, асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг гэж үздэг²⁴. Хүүхдүүд урлагийн хэрэгсэлтэй ажиллахдаа дуртай байдаг бөгөөд энэ нь эмчлэх, эдгээх явцад эерэг нөлөө үзүүлдэг байна²⁵ (Green, 2003). Тухайлбал хүүхэд зураг зурж байхдаа юу бодож, мэдэрч байгаагаа заавал ярих шаардлагагүй (Veltman & Browne, 2003). Ялангуяа хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд “Чи дуугүй бай”, “Юу болсон талаар бүү ярь”, “Өөрт төрсөн мэдрэмжээ битгий илэрхийл”, “Битгий асуулт асуу”, “Хэнд ч бүү хэл” гэх мэт үгийг байнга сонсдог (Peled & Davis, 1995). Тийм учраас хүчирхийлэлд амьдарч байгаа хүүхдүүд өөрт төрж буй мэдрэмж, сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг. Иймээс тэднийг өөр аргаар илэрхийлэхэд урлагийн сэтгэл засал тохиромжтой (Malchiodi, 1997). Ихэнх тохиолдолд тэдний эцэг эх өөрсдөө хүүхэд байхдаа хүчирхийлэлтэй орчинд төрж, өсөж, өөрийгөө илэрхийлэх ур чадвар эзэмшээгүй байдаг.

Хүчирхийллийн хохирогчдод арт терапи буюу урлагийн сэтгэл засал нь ямар боломжууд олгодог вэ?

Бид өөрсдийн мэдрэмж, үйлдлийг үгээр илэрхийлэх болохоороо хэт “ерөнхийлж”, асуудлаа дахин дахин бодох, ярих зуршилтай болчихдог. Жишээлбэл, “Энэ одоо бүтэхгүй” эсвэл “Одоо өнгөрсөн” гэх мэт.

Тэгвэл тулгамдсан асуудлаа байнга боддог дээрх хэвшмэл арга барил, хандлагаас өөрөөр бодох эргэцүүлэх боломжийг урлаг бидэнд олгодог. Өөрт хэрэггүй мэдээллийг хүлээн

21 Глинда Нийдс “Foundation of art therapy” 2003

22 Глинда Нийдс “Foundation of art therapy” 2003

23 Freud, S. (1905) Fragment of an analysis of a case of hysteria (‘Dora’), Harmondsworth, UK: Penguin Freud Library. Ironside, L. (1995) Beyond the boundaries: A therapist and an allegation of sexual abuse, Journal of Child Psychotherapy, 21(2), London: Routledge. Piontelli, A. (1992) From fetus to child: An observational and psychoanalytic

24 Emma Mills & Stephanie Kellington (2012) Using group art therapy to address the shame and silencing surrounding children’s experiences of witnessing domestic violence, International Journal of Art Therapy

25 An Art Therapy Group for Children, Traumatized by Parental Violence and Separation kasia kozlowska & lesley hanney, The New Children’s Hospital, Sydney, Australia



авахгүйгээр харин түүний оронд асуудалдаа шинэ утга, санаа өгч, шинэ дүрслэлээр илэрхийлэхийг сануулдаг. Жишээлбэл: бид бүтээсэн зүйлээ хараад тайлбарлах үед тэр дунд санаанд оромгүй зураас, дүрс, өнгө явж байх нь бий. Тэдгээрийн хариуг сэтгэл дотроосоо эрж байхдаа асуудлынхаа талаар шинэ санаа, шинэ сэтгэгдлийг нээн илрүүлдэг билээ. Ийнхүү арт терапи буюу урлагийн сэтгэл засал нь бидэнд бүтээлч байх зуураа өөртөө төвлөрөх, өөрийн асуудлаа өөр өнцгөөс харах гэх мэт олон боломжийг олгодог.

Үүнд:

- Үгээр хэлж илэрхийлэхэд хүндрэлтэй сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлэх
- Айдас, түгшилт, сэтгэл зовнилоо бууруулах
- Стресс, уур бухимдлаа бууруулах
- Уур бухимдлаа ойлгох, ухамсарлах, удирдаж сурах
- Өөрийн давуу болон сул талаа олж харах өөрчлөгдөх
- Өөрийн зан чанар, сэтгэлзүйн онцлог, авьяас чадвараа танин мэдэх
- Өөрийн ур чадвар, нөөц боломжоо илрүүлж, хөгжүүлж, өөртөө итгэлтэй болох
- Бодол, мэдрэмж, сэтгэл хөдлөлөө хянан зохицуулах, эерэг аргаар илэрхийлж сурах
- Зорилгынхоо төлөө тэмцэх чадвараа хөгжүүлэх
- Өөрийгөө илэрхийлэх, хамгаалах ур чадварт суралцах
- Амьдрах урам зоригтой болох
- Эрүүл мэнд нь сайжрах
- Асуудлаас гарах арга замаа тодорхойлох
- Аливаад ул суурьтай, нухацтай хандаж сурах
- Өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө хянан зохицуулах, эерэг аргаар илэрхийлж сурах
- Мэдээллийг шүүн тунгаах, анализ дүгнэлт хийх чадвараа хөгжүүлэх
- Өөрийгөө зөв илэрхийлж, бусдад хүндэтгэлтэй хандаж сурах
- Бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох
- Эрсдлээс өөрийгөө хамгаалах ур чадварт суралцах
- Мэдрэмж сэргээх тоглоомууд болон түүнтэй холбоотой үйл ажиллагаануудаар дамжуулан биеийн дотоод сэрэл, мэдрэхүйгээ идэвхжүүлэх, ажиллуулах

Хохирогчид зөвлөгөө өгөхөд энэ аргыг ашиглах зөвлөгчийн анхаарах зүйлүүд

Урлагийн сэтгэл заслыг бид ач холбогдолтой гэж бодож байгаа хэдий ч зарим тохиолдолд зарим хохирогчид ашиглахгүй байх нь зүйтэй. Үүнд:

- Тохиромжгүй материал, хэрэгсэл ашиглах тохиолдолд хүүхэд, насанд хүрэгчдийн сэтгэлийн зовуурь, шархыг урлагаар илэрхийлэх нь асуудлыг сэдрээх аюултай. Эрсдэлтэй тохиолдолд мэргэжлийн урлагийн сэтгэл засалчийн удирдлага дор уг аргачлал үр дүнгээ өгөх болно.
- Тухайн хохирогч хий юм харах /параной/ өвчтэй байх үед урлагийг ашиглах нь аюултай. Учир нь урлагийн үйл ажиллагаа нь тэдний хий төсөөллийг улам дэвэргэж мэднэ.
- Зарим үед урлагаар дамжуулан тайвшрах, тайтгарах, сатаарахад болохгүй зүйл байхгүй. Гэвч энэ тийм ч үр дүнтэй арга биш.
- Заримдаа хүмүүс зургаа “зөв” сайхан болгохын тулд махран зүтгэх нь бий. Энэ тохиолдолд хохирогч өөрт хэрэгтэй сэтгэл заслыг олж авч чаддаггүй юм. Учир нь урлагийн сэтгэл засал нь галерейд үздэг “урлаг”-аас өөр зүйл. Хэн ч тэдний уран бүтээлийг шүүхгүй, төгс зураг, бүтээл гаргуулж болохгүй. Хохирогч урлагийн авьяастай байх албагүй.



- Зарим хохирогч урлагийн хэрэгсэлтэй ажиллахдаа тавгүйтэж, таагүй сэтгэгдэл төрж татгалзаж болно. Тийм учраас тэдэнд тохиромжтой орон зай, аюулгүй орчин бүрдүүлэх нь чухал. Хэрвээ хохирогч тань тавгүй байгаад байвал та дараах алхмуудыг хийж болно. Үүнд:
- Та хохирогчийн дэргэд ойр зуурын юм сараачаад сууж болно.
- Та тааруу муу зургийн жишээг ханандаа хадах эсвэл номынхоо хавтсанд байрлуулснаар хүмүүс хараад өөрийн зурах ур чадварт санаа зовних нь багасна.
- Энгийн хээ бүтээхээс эхэлж болно. Жишээлбэл: зураас зуруулах, дугуй дүрс зэрэг хүн бүрийн зурж чадах зүйлийг зуруулж болно.
- Хохирогчийг аль болох тайван байлгаж, өөрт төрж байгаа мэдрэмжээ илэрхийлж байхад нь зогсоож өөрийн бодол санаагаа хэлэхгүй байх
- Хохирогч стресстэй байгаа тохиолдолд аль болох аюулгүй байдлаар илэрхийлүүлэх боломж олгох хэрэгтэй.
- Хүчирхийллийн тухай сонссон таны анхны хариу үйлдлээс хохирогч өөрийнхөө тухай юу мэдрэх нь шалтгаалдаг. Таны сөрөг хариу үйлдэл тэдэнд аймшигтай санагдах учраас таны хариу үйлдэл нь түүнд өөрийгөө буруутгах, ичих мэдрэмжийг төрүүлнэ.
- Хохирогч тайван байж, өөрийн бүтээлээ тайлбарлаж ярихыг дэмжих.
- Юу ч болсон байлаа тэдний буруу биш гэдгийг ойлгуулах хэрэгтэй.
- Насанд хүрэгчид хааяа буруу зүйл хийдэг гэдгийг тайлбарлана.
- Хүүхдийг тайвшруулах бүхий л аргыг хэрэглээрэй. Өөрийн үйл ажиллагааны зорилгоо тодорхой хэлнэ. Чадахгүй зүйлээ амлах хэрэггүй. Нууцыг хадгална гэдгээ ч мөн ойлгуулна.
- Кейсийн шинжилгээг алгасаж огт болохгүй бөгөөд хохирогчдын тухай судалгаа хийж, илүү их мэдээлэлтэй болох тусам хөтөлбөрийнхөө үр дүнг тодорхой төсөөлж, төлөвлөж, учирч болох бэрхшээлүүдийг урьдчилан тооцож бэлэн байх нь зүйтэй.

Урлагийн сэтгэл заслыг ашиглахад шаардлагатай орчин ба арга хэрэгслүүд

Арт терапи өрөө нь хохирогч, мэргэжилтэн хоёрын хооронд аюулгүй харилцаа үүсгэж болохуйц тайван, тухтай байхаас гадна өөрийгөө чөлөөтэй илэрхийлж болохуйц зай талбайтай байх ёстой. Арт терапи үйлчилгээ нь урлагийн хэрэгслүүдийг бүтээлчээр ашиглахад тохиромжтой байхаар төлөвлөж өрөөгөө тохижуулах нь зүйтэй (Brown 2008).

Хохирогч арт терапи өрөөнд орж ирэхэд анхны мэдрэмж маш чухал. Аюулгүй, тайван, итгэл, найдвар төрүүлэхүйц газар хохирогч тайван байж, үйлчилгээ үзүүлж байгаа хүнд ч зорилгоо биелүүлэхэд чухал. Гэхдээ хүн бүхэн өөр учраас өөр өөр сэтгэгдэл төрүүлэх нь мэдээж. Өөрөөр хэлбэл хэтэрхий хүйтэн хөндий том өрөөнд хохирогчдод айх, цочих, тавгүйтэх мэдрэмж төрдөг. Жишээлбэл хоосон хөндий өрөөнд харааны бэрхшээлтэй хүн орж ирэхэд цуурайтах, эвгүй үнэр үнэртэх зэрэг нь тэдэнд аюултай мэдрэмж төрүүлдэг.

Өрөөгөө тохижуулахдаа дараах зүйл байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Үүнд:


- Өрөө нь хангалттай зай, талбайтай байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн орох боломжтой байх
- Ариун цэврийн өрөө байх
- Хангалттай сайн гэрэлтүүлэгтэй байх
- Үйл ажиллагаа явуулахад угаалтууртай байх, устай байх
- Сандал ширээ хангалттай байх
- Хийсэн бүтээл байрлуулах зайтай байх
- Үйл ажиллагаа зохион байгуулахад тохирсон зай талбайтай байх

- Дуу чимээнээс тусгаарласан байх
- Анхан шатны эмнэлгийн тусламжийн хайрцагтай байх
- Яаралтай тохиолдолд утсаар ярих боломжтой байх
- Арт терапи хэрэгслүүдээ хадгалах, байрлуулах тавиуртай байх
- Хуучин сонин, сэтгүүл

Мөн арт терапи үйлчилгээг зөвхөн хувь хүнд төдийгүй бүлгийн, гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх, мэргэжилтнүүдийн уулзалт хийхэд зориулж тохижуулж болно.

Урлагийн хэрэгслүүд нь их зай талбай эзэлдэг тухайлбал: хэрэгсэл хадгалах сав, элсэн терапи хийх хэрэгсэл, тоглоом, хүүхэлдэй хадгалах зай, хөгжмийн зэмсэг хадгалах, уулзаж ярьж суух гэх мэт зай талбай хангалттай байх хэрэгтэй.

Орчин үед арт терапи үйлчилгээ үзүүлэх өрөөг олон үйл ажиллагаанд ашиглаж байна.




Арт терапи үйлчилгээ үзүүлэхэд урлагийн хэрэгслийг ашиглахуй

Зураачид, хөгжимчид, барималчид бүгд л урлагаас тайвшрал, баяр баясал мэдэрдэг гэдэг. Бүтээн туурвиж байхад тэдний сэтгэл санаа тогтуун байж, өдөр тутмын аар саар асуудал, сэтгэл санааг нь зовоож байгаа зүйлээс хол байж үр бүтээлтэй, шинээр цэнэглэгдсэн мэт мэдрэмж төрдөг. Гэхдээ урлагийг тайвшрах, сэтгэлээ түр зуур сэргээх зорилгоор ашиглах болон зорилготойгоор сэтгэцийн хямрал, цочрол, айдас түгшүүр бууруулах, зан төлөвийг өөрчлөх, амьдралын асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглах хоёр хоорондоо ялгаатай юм.

Байгалийн сайхан зураг зурах нь ууртай, түрэмгий зантай хүнд зангаа засахад нь тусалж чадахгүй юм. Харин тусгай дасгал бүхий системтэй, зорилготой арт терапи хөтөлбөр өөрчлөлтийг бий болгож чадна. Энэхүү үйлчилгээг үзүүлэхийн тулд тухайн ажилтан урлагийн төрөл бүрийн хэрэгсэл болон түүний шинж чанарын талаар ойлголт мэдлэгтэй байх ёстой. Арт терапи буюу урлагийн сэтгэл заслын үйлчилгээнд дараах хэрэгслүүдийг ашиглана.



Анхаарах асуудал:



Урлагийн хэрэгсэлтэй ажиллаж байхдаа үйл ажиллагаа бүрд хэрэглэх хэрэгслийг л хохирогчийн өмнө байрлуулна. Өөрөөр хэлбэл нэг доор олон төрлийн хэрэгсэл тавих нь тэднийг буруу хэрэгсэл ашиглах, төөрөгдөлд оруулах, сандраах мөн хохирогчийн өмнө эмх замбараагүй үлгэр дуурайлал үзүүлдэг учраас эмх цэгцтэй, дэс дараатай ашиглана. Гэхдээ хохирогчийн асуудлаас хамаарч тохирсон хэрэгслүүдийг ашиглана.

Усан будаг, акрилик будаг, гуаш, ус хийх сав
Тосон будаг
Будаг холигч
Багс, бийр (том, жижиг)
Харандаа- өнгийн харандаа, тосон харандаа,
үзгэн бал, шохойн харандаа
Цаас-төрөл бүрийн өнгө, хэлбэр, дүрстэй, зузаан,
нимгэн гэх мэт
Баримлын шавар, зүсэгч
Хуучин сэтгүүл
Цавуу
Толь
Хуучин ашигласан ном, дэвтэр
Шавар, зүсэгч хэрэгсэл
Сийлбэрийн хэрэгсэл
Маск

A3, A4, A5 хэмжээтэй төрөл бүрийн цаас
Самбарын цаас
Оригами цаас
Зөөлөн харандаа
Фломастер
Холигч /блиндэр/
Скоч
Өнгийн харандаа
Шугам
Гар урлалын материалууд
Халуун цавууны хайч
Төрөл бүрийн даавуу
Тоглоом-үйлчилгээнд зорилготой ашиглах
Хөгжим, хөгжмийн зэмсгүүд
Мод, чулуу, навч, цэцэг... г
Утас/ төрөл бүрийн өнгө, хатуу, зөөлөн/
Төмөр утас / нарийн, бүдүүн, уян гэх мэт
Тэмдэглэлийн дэвтэр хийх материал

СЭДЭВ 3.3 ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД УРЛАГИЙН СЭТГЭЛ ЗАСЛЫН АРГААР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТЕХНИКУУД

Хичээлийн зорилго:

- Ганцаарчилсан зөвлөгөөний төрөл хэлбэрийн арга техникийн талаар мэдэж авна.
- Ганцаарчилсан болон гэр бүлд түшиглэсэн нийгэм сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.

Үндсэн ойлголтууд:

- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон насанд хүрэгчидтэй ажиллахдаа үлгэр, өгүүлэг, түүхээр дамжуулан тэдний хэрэгцээг тодорхойлох
- Хохирогчид тулгамдаж байгаа асуудлыг ойлгох, өөрт төрж буй сэтгэл хөдлөл, мэдрэмжээ ойлгох, сэтгэл хөдлөлөө зөв удирдаж сурах
- Өөрийн аюулгүй байдлаа таньж мэдэх, өөртөө аюулгүй орчин бүрдүүлэх

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Оролцооны аргад тулгуурлаж ажиллана.

Унших материал:

- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, Бүлэг III

Хэрэглэгдэхүүн:

- Сургагч багшийн бэлтгэсэн материал
- Тусгайлсан хэрэглэгдэхүүн






ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХЭД, НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН УРЛАГТ СУУРИЛСАН ДАСГАЛУУД

1. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон насанд хүрэгчидтэй ажиллахдаа үлгэр, өгүүллэг ашиглах нь

“Үлгэр болон түүх” нь урд шөнө хэр унтсан, өчигдөр хэрхэн завгүй өнгөрсөн, эсвэл хэдэн жилийн өмнө тохиолдож байсан явдал гэх мэт юу ч байж болдог. Аль нь ч байлаа гэсэн өөрийн гэсэн эхлэл, өрнөл, төгсгөлтэй байдаг шүү дээ. Хүүхдүүд ч мөн тоглож байх зуураа “үлгэр, түүх” өгүүлж байдаг бөгөөд амьдралдаа тохиолдсон зүйлстэйгээ холбогдуулан өөрсдийгөө том хүн, эмч, эсвэл бүр амьтан болсноор төсөөлөн, ярьдаг билээ.



Иймээс үлгэр бол бидний амьдралын салшгүй хэсэг, алив асуудлыг шийдэхдээ хэрэглэдэг нийтлэг арга болсон юм. Тийм учраас хүүхэд, насанд хүрэгчидтэй ажиллах үед үлгэрээр өгүүлэх аргыг урлагийн төрлөөр орлуулж болдог.

Өгүүлж байгаа үлгэр нь бодит явдал байж болох ба эсвэл зохиосон ч байж болох бөгөөд өнгө, дүрс ашиглан өгүүлж болдог. Жишээлбэл: “Ногоон гурвалжин өөрийн хурц өнцгүүдээсээ болоод өөр дүрснүүдтэй ойртож чаддаггүй

байв. Ялангуяа зөөлөн дугараг дүрснүүдээс хол байдаг байв. Учир нь түүний өнцөг нь бусдыг хатгаж өвтгөх байх гэж айдаг байлаа”. Энэ үлгэрээр хохирогчийн нийгмээс тусгаарлагдах, бусдын шүүмжлэлээс зайлсхийх байдлыг илэрхийлж байгааг харж болно. Ийнхүү үлгэр домог, явган яриа хэлбэрээр илэрхийлэх нь амар мартагддаггүй учир илүү үр дүнтэй байдаг. “Хурц өнцөг нь дугуй дүрснүүдийг үнэхээр гэмтээн гэдгийг Ногоон гурвалжин маань мэдэж байгаа юу, эсвэл зүгээр тэгж таамаглаж байгаа юу? Магадгүй хурц өнцгөөрөө дугуй дүрсэд зөөлөн хүрэхэд тэдэнд таалагдаж ч мэднэ шүү дээ?” Энэ маягаар гурвалжин болон дугуй дүрсийг ашиглан ярилцсанаар хохирогчид хурц өнцөгтэй байх нь нийгмээс өөрийгөө тусгаарлах шалтаг биш, харин ч дугуй дүрснүүд хурц өнцгийг нь тоохгүй ногоон өнгө, онцлог хэлбэрт нь дуртай байж болохыг ойлгуулж болдог. Магадгүй ногоон гурвалжин маань өөрийнхөөрөө байж, бусдыг хурц өнцгөөрөө гэмтээхгүй байх аргад суралцаж болох юм. Хохирогч үлгэрээр дамжуулан ухаарал авч, аливааг өөрөөр харах аргад суралцах боломжтойг та харж болно. Тэгвэл урлагийн сэтгэл заслын гол зорилго бол хохирогчдод өөрийн давуу талаа таньж мэдэх, өөрийн мэдлэг чадвар, нөөц боломжоо нээх, илрүүлэх, өөртөө эерэг өөрчлөлт бий болгоход нь туслахад оршино. Хохирогч өөрт төрсөн асуудал, хэнд ч яримааргүй байгаа зүйл эсвэл санаа зовж байдаг зүйлээ үлгэр хэлбэрээр өгүүлэхдээ түүнийгээ нууж далдлахаа больж, үлгэр болгон хүүрнэх явцдаа өөр дүрд оруулж харснаар өөрт тулгамдсан асуудлаа арай өөр өнцгөөс харах, мухардалд орсон нөхцөл байдалдаа арга замаа олж авдаг. Тэд хэдийгээр төгсгөлийг нь амар сайхандаа жаргуулж амжихгүй ч аль хэдийн дотроо төсөөлсөн байдаг. Бусад дүрээр төлөөлүүлэн үлгэрээ өгүүлснээр тухайн дүрээ /өөрийгөө/ ойлгон, тэр дүрийнхээ давуу тал, эр зоригийг бодитоор үнэлж, өөрсдийгөө илүү хайрлаж эхэлдэг. Өөрсдийгөө ойлгож, хайрлаж эхэлснээр бид амьдралдаа зөв шийдвэр гаргаж, зан араншин ч өөрчлөгдөж төлөвшиж эхэлдэг.

Аливаа асуудлыг шийдэх боломжит бусад гарцуудыг ч олж харж эхэлдэг.



Зорилго: Хохирогчид хүнд хэцүү бэрхшээлийг даван туулах үедээ өөрийн олж авсан сургамжаа хүүрнэн өгүүлэх аргаар бусадтай хуваалцаж, амьдралын хэтийн зорилгоо тодорхойлох, асуудлаасаа гарах гарцаа олоход нь туслах

Үлгэр хэнд тохиромжтой вэ? - Бүх насныханд тохиромжтой.

Давтамж: Үлгэрийг эхлэл, өрнөл, төгсгөлтэй болгоход анхаарч ажиллах хэрэгтэй. Үлгэрийг бүтээлчээр өрнүүлэхийн тулд зөвхөн хохирогчийн асуудал, өөрийн онцлог зэргийг харгалзаж үзээд 4-5, 6-8 удаагийн уулзалтыг зохион байгуулж болно.

Зааварчилгаа: Үлгэрээ яриулж цаасан дээр буулгасны дараа хамтдаа бяцхан үлгэрийн бяцхан ном хийлгэх нь ач холбогдолтой. Энэ нь хохирогчийг бүтээлч байх зуураа асуудлаа өөр өнцгөөс олж харах, эргэцүүлэх, гарц шийдэл олох, цаашдын хэтийн зорилгоо тодорхойлоход нь тусална. Үлгэр ярьж байх хооронд ажиллаж байгаа мэргэжилтэн зарим нэг зүйлүүдийг тодруулж асууж болно. Энэ нь тухайн хүнийг өөр өнцгөөс харах, санаа оноо олоход нь туслах юм. Ингэхдээ өөрийн санаагаа тулгаж болохгүй. Хохирогчийн ярьж, хийж байгаа зүйлээс л тодруулж асууж болно.

Бэлтгэл: Зурах цаас, өнгийн харандаа, усан будаг, бүтээлч байж болох бусад хэрэгслүүдийг бэлдэх. Зуруулахаас гадна бяцхан ном хийлгэж болно. Ингэхдээ хуучин ном ашиглаж болно. Ватум цаас, эсвэл хатуу цаасаар 6-8 хуудастай ном хийлгэж болно.

Үлгэрийг хэрхэн бүтээх вэ?

Үлгэрээ яриулах, бичихдээ “Би, надад” гэх мэт үгс хэрэглэхгүй, харин “Бяцхан гөлөг гунигтай байлаа. Түүнд маш хэцүү зүйл тохиолджээ” гэх мэтээр бичнэ. Гөлөг /хохирогч/ хүнс авах мөнгөгүй болжээ гэхийн оронд “**Бяцхан гөлөг яс мэрж, галын дэргэд тухлан хэвтмээр байсан ч түүнд аль аль нь байсангүй**” гэх мэтээр өөрийгөө өөр амьтнаар төлөөлүүлэн ярих зааварчилгаа сайн өгнө.

Энэ маягаар үргэлжлүүлэн гуравдагч дүрийг хөндлөнгөөс харах маягаар бичих хэрэгтэй. Гэхдээ өөрийгөө аль нэг дүрд орлуулах ба энэ жишээн дээр өөрийгөө Бяцхан гөлөг гэж үзээд, юу хийж байгаагаас нь илүүтэй юу бодож, юу мэдэрч байгааг бичих хэрэгтэй. Ийнхүү хохирогчидтой ажиллахдаа үлгэрийг аль болох эергээр дуусгахыг хичээх хэрэгтэй. Үлгэрийг заавал нэг өдрийн уулзалтаар хийх хэрэггүй. Та 6-8 өдрийн уулзалтаар үлгэрийг зохиолгож болно. Та хохирогчид даалгавар өгч болно. Энэ нь тухайн хохирогч бэрхшээлийг хэрхэн харах, даван туулах талаар гарц шийдлээ олоход нь туслах мэдлэг, мэдээлэл өгч явуулж болно. Мөн үлгэрээ хэрхэн үргэлжлүүлэх эсэх дээрээ эргэлзэж байвал тэр талаар бодож эргэцүүлээд ирэх даалгавар өгөөд дараагийн уулзалтаар үргэлжлүүлнэ гэдгээ хэлээрэй.

Анхааруулга: Хүүхэд болон насанд хүрэгчидтэй баг болон ажиллахаар төлөвлөж, эсвэл ажиллаж байгаа бол гол зорилгоо тодорхой байлгах нь маш чухал. Тодорхой 3 чухал зорилго тавьж ажиллах нь зүйтэй. Учир нь хэтэрхий олон зорилго тавих нь ихийг өөрчилж чадна гэсэн үг биш юм. Хохирогчдод ямар хэрэгцээ байгаа талаар байнга судалж байх хэрэгтэй.

Санамж: Энэхүү үлгэрийг ашиглахдаа Австрали улсын арт терапевт Глинда Нийдс болон Монголын Урлагийн Сэтгэл заслын Холбооны нэрийг дурдана уу.

Та бүхэндээ жишээ болгоод нэгэн хохирогчийн үлгэрийг хуваалцаж байна. Тэрээр өөрийгөө **бяцхан мэлхийгээр** төлөөлүүлж, өөрийнхөө хамтран ажилладаг даргаа **могойгоор** төлөөлүүлэн хүүрнэж байна.

Энэ үлгэрт Төмрөө гэдэг залуугийн тухай гарах ба нэгэн томоохон төслийн ажил эхлүүлээд, дуусгаж амжаагүй байхдаа эмнэлэгт хэвтэж байх үеийн тухай өгүүлнэ. Энэ үлгэрт Төмрөө өөрт тохиолдож байгаа бэрхшээлүүдийг юу гэж харж байгаа, мөн бүх зүйл сайнаар хэрхэн төгсөж байгаа тухай гарна.





Кейс 1. Төмрөө нэгэн байшин түрээсэлж амьдардаг байв. Тэр байшин нь маш хүйтэн, гаднаа ямар ч зай талбай байхгүй байв. Тэрээр өөрийн гэсэн гэр, оронтой болж, хашаандаа цэцэрлэгтэй мөн цэвэр агаарт амьдрахыг хүсдэг байсан учраас одоогийн амьдарч байгаа нөхцөл байдалдаа маш их санаа зовдог байлаа.

Бодол:

- “Би ч эндээс холдохгүй нь дээ”, “Энд насан туршдаа амьдарна гэж байхгүй дээ, миний бие ч муудах юм байна”.
- “Би хэзээ ч өөрийн гэсэн гэр оронтой болохгүй юм байна даа, яах вэ байз”.

Мэдрэмж:

Гунигтай, уйтгартай

Энэ үлгэрт өөрийгөө бяцхан мэлхийгээр төлөөлүүлж байгаа юм.



Бяцхан мэлхий өөрийнхөө гэр гэж нэрлэдэг бохир усны шалбааг дээгүүр хөндөлдөн хэвтэх хуучин усны хоолойноос толгойгоо цухуйлган эргэн тойрноо харав. Тэр гунигтай байлаа. Хөдөө байдаг бусад мэлхий хөлийнхөө завсар шавартай ч амтлаг авгалдайгаар дүүрэн цөөрөмд, намаржин дэвхрэн тоглох навчин дунд амьдардгийг мэднэ. Харин хотод бол өөртэй нь адилхан зүйл хүсдэг мэлхий бараг байхгүй. Хотын мэлхийнүүд өөр өөрсдийн амьдардаг хуучин хоолой, хаягдал лааз, цементэн хашлага дундаа аз жаргалтай амьдарна. Тиймээс бяцхан мэлхий ганцаардаж байв. Уг нь тэр хөдөө амьдрахыг хүсэвч цөөрөм, ой мод маш хол санагдаж, хэзээ нэгэн цагт сонсож байсан тэр сайхан газар руу хэрхэн очих замаа мэдэхгүй байв.

“Төмөрөөгийн дарга нэгэн төсөл бичихийг даалгаад, нэлээд их хэмжээний мөнгө амласан байв. Тэр мөнгөө хадгаламждаа нэмээд өөрийн гэсэн байшинтай болох боломжтой байв. Гэвч тэрээр айж байлаа. Тухайн ажил нь үнэхээр том хэмжээний ажил байсан тул хүнтэй хамтрах хэрэгтэй байсан ч хамтрах ёстой хүндээ тэрээр итгэдэггүй байжээ”

Бодол:

Ээ бурхан багш минь, бид шинэ байшин авч болох юм байна.

Бурхан багш миний гуилтыг сонссон бололтой. Одоогоос бүх юм сайхан болно.

Мэдрэмж:

Сэтгэл нь хөдөлж, бие нь хөнгөрч байна, баяртай байна ...



Нэг өдөр бяцхан мэлхийн хажуугаар нэгэн могой өнгөрч явах үедээ бохирын суваг дахь хуучин лааз руу нь мөргөчхөв. Могойг ойртож харсан мэлхий нүд нь үүл бүрхсэн юм шиг, хаашаа явж байгаагаа харахгүй байгааг мэдэв. “Могой чи сохор юм уу?” гэж мэлхий асуулаа. “Тиймээ мэлхий. Тэгээд би хөдөө байдаг гэрээ олж очиж чадахгүй байгаадаа маш их гутарч, сэтгэлээр унаж байна” гэв. “Та нөгөө сайхан хөдөөгөөс ирсэн юм уу?” гэж мэлхий асуулаа. “Би ч бас тийшээ явмаар байна, даанч замаа мэдэхгүй” хэмээн нэмж хэлэв. “Би замаа мэднэ, гэхдээ замд тааралдах тэмдэгтүүдийг харж чадахгүй учир чи надад тусална гэвэл хамт явж болох юм” гэж могой хэлэв.

“Энэ төслөө боловсруулахад хэр их ажил шаардагдахыг Төмрөө тооцоолж үзэв.

Долоо хоног бүр маш олон цагаар сууж ажиллах хэрэгтэй байлаа. Угаасаа ч урт цагаар ажилладаг байсан учир эрүүл мэнд нь муудаж, гэр бүлээ халамжлах ч цаг гардаггүй байв. Мөн түүнийг удирдах хүн ямар хэцүү зантай хүн болохыг тэр мэдэж байлаа. Тэгээд энэхүү ажлыг хийж чадахгүй нь, хэтэрхий хүнд даваа байна гэж бодов”

Бодол:

Өө үгүй ээ. Яагаад надад энэ бүхэн тохиолдоно вэ? Би хэзээ мөрөөдлийнхөө гэртэй болох юм бэ?. Би ямар тэнэг юм бэ?

Мэдрэмж:

Ядарсан, сульдсан, хүчгүй, золиос болсон



Пөөх, ямар гоё юм бэ? Ногоон нугатай цөөрөмд удахгүй очих нь дээ. Бяцхан мэлхий бодсоор л байв. Тэрээр могойтой хамт байхдаа тун болгоомжтой байх хэрэгтэйгээ мэдэж байлаа. Хэрэв тэр өлсөх л юм бол мэлхийг дор нь залгичихна гэдэг нь ойлгомжтой. Хөөрхий бяцхан мэлхий санаа алдав. Могойтой хамт аялах нь хэтэрхий их эрсдэлтэй юм. Тэгээд мэлхий гунигтайгаар буцан үүр лүүгээ орлоо.

“Төмрөө ахтайгаа уулзаж, ямар ажлын санал ирсэн тухай, өөрийнхөө татгалзах гэж байгаа тухайгаа ярьжээ. Гэвч ах нь түүнд ядаж оролдож үзэлгүй татгалзах нь тэнэг хэрэг хэмээн хэлжээ. Ах нь түүнийг ажил дээр нь очиж үзэхийг хүсэв. Хэрэв эхэлье гэж оролдоогүй бол ийм зүйлд хүрч чадах байсан болов уу гэж гайхширах болно хэмээн ах нь Төмөрөөд хэлэв”.

Бодол:

Би ч бас оролдоод үзэж болох л юм. Эхэлчхээд дуусгаж чадахгүй бол яах бол? Гэр бүлтэйгээ хамт байж чадахгүй байх нь тэдэнд маань ямар санагдах бол? Ингэхэд би ер нь гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөж чадах болов уу?

Мэдрэмж:

Айдас, эргэлзээ, бага зэрэг зориг дутаж байна



Дараагийн өглөө нь Бяцхан мэлхийг сэрэхэд Могой исгэрэн, гудамж шүүрдэгч машины чимээ маш чанга сонсогдож байлаа. Мэлхий дэвхрэн, сувгийн нөгөө талд гарчээ. Тэгэх зуураа могойд хандан “Наашаа, энэ замаар аюулгүй. Миний чимээг дагаад яваарай” гэж хэлэв. Могой түүний араас болгоомжтой дагаж, аюулгүй газар гарахад машины дуу улам чангаран, тэр хоёрыг арай л дайрчхалгүй өнгөрөв. Тэрхүү машин төдөлгүй далд орлоо. Харин хөөрхий мэлхийн хуучин гэрийг няц дайрсан тул тэр орон гэргүй болжээ.

“Төмрөө төслийг бичих гэрээндээ гарын үсэг зуржээ”

Бодол:

За ингээд урагшаа. Ура. Би юу хийх нь энэ вэ? Магадгүй би өөрийн гэсэн орон байртай болох нь...

Мэдрэмж:

Сандарсан, хөөрсөн, бага зэрэг санаа зовнисон





“Могой, хоёулаа нэг зүйл тохирьё. Би чиний нүд болъё, чи намайг хөдөө рүү замчилна. Гэхдээ надад нэг зүйлийг заавал амла. Хэчнээн ч өлссөн байлаа намайг идэхгүй гэж. Хэрэв тэгвэл би чамд нүд болж чадахгүй, чи ч гэртээ харьж чадахгүй, тэнэг явдал болно”. Могойны үүлтсэн нүд сэргэх шиг болж, баярласандаа “Тэгье тэгье” гэлээ.

“Төмөрөөгийн боловсруулж байгаа төслийн удирдагч нь гол санаагаа хоёр дахь удаагаа өөрчлөв. Энэ нь мэдээж маш хэцүү байдал үүсгэж, илүү их ажиллах хэрэгтэй болов”.

Бодол:

Ингэнэ гэж мэдээд байсан юмаа. Дэндүү хэцүү болохоор би барахгүй юм байна даа. Үгүй ээ би хичээх хэрэгтэй. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг, давж л таарна даа.



Могой, Мэлхий хоёр аяллаа эхэлжээ. “төмөр хогийн сав хүртэл шуудуугаа дагаад яваарай” гэж могой хэлэв. “Машины зогсоол харагдмагц будагтай 12 шугамыг даваад баруун эргээрэй” гэв. “Шатаар буугаад хашаан доогуур гараарай” гэх зааварчилгааг мэлхий дуулгавартай дагасаар, могойд сонсогдохуйцаар вааглан явж байлаа.

Мэдрэмж:

“Байнга л тулалдаж байгаа мэт. Гэтэл Төмөрөөгийн аавын бие муудсан тул настай аавыгаа 2 сар хэртэй сахих хэрэгтэй болов. Энэ үеэр төслийн ажил мэдээж урагшлах нь удааширсан байлаа”

Бодол:

Хэрэгтэй үед надад туслах хэн байна? Гэр бүл гэдэг юу юунаас эрхэм шүү дээ. Өөрийн байшинтай болохоос ч илүү. Ээж аав хоёртойгоо удаан хамт байж чадахгүй нь дээ яах вэ байз. За за гомдоллоод байлгүй тэднийгээ хайрлах хэрэгтэй.



Могой зааварчилсаар байсан ч заримдаа зөв замдаа орохын тулд нэг газраа хэд дахин эргэлдэх нь ч байв. Зааврыг нь ойлгохгүй болохоор тэр Мэлхийнд уурладаг байлаа. “Энд чинь хоёр хаалга байна шүү дээ могой. Хаагуур нь явах вэ?” гэж асууна. Харин могойд мэлхийний төсөөлж байснаас илүү их тусламж шаардлагатай байлаа. Учир нь тэр хурц ирмэгтэй зүйлийг мэдрэхгүй, машиныг харахгүй, тохирох хоол олоход бэрх байв. Мэлхий ямар хулгана барьж байсан биш дээ. “Бид ингэж тохироогүй” хэмээн мэлхий гомдоллоно. Заавраа хэчнээн сайн хэллээ ч хөдөө гэрээ хүрэх яагаа ч үгүй байв. Мэлхий мөрөөдлийн газартаа очиж чадах эсэхдээ эргэлзэж эхлэв.

Мэдрэмж:

Хаягдсан, ганцаардсан, ууртай, эцэг эхийнхээ өвчинд санаа зовсон, хайр, бууж өгсөн “Төслийн ажил дуусахад 2 долоо хоног дутуу байлаа. Гэвч бие нь өвдсөн тул 10 хоног эмнэлэгт хэвтэх хэрэгтэй байдаг. Тэр ууж байгаа эмээс болж анхаарлаа төвлөрүүлж чадахгүй, хүчилтөрөгчийн аппаратаас болоод шил нь байнга цантаж юм харж чадахгүй, өөрөөр хэлбэл ажлаа хийж чадахгүй байв”

Бодол:

Би ч алдаа гаргачихлаа даа. Бараг л дуусах болоод байхад амжих боломжгүй юм шиг байх юм. Үнэхээр алдаа байжээ.

Мэдрэмж:

Үнэхээр сэтгэлээр унасан, би бууж өгсөн нь дээр юм гэх мэдрэмж.

Төслөө эхэлснээс 47 долоо хоногийн дараа Төмрөө ажлаа дуусгав. Гэвч түүний төслийг хараад захиалагч нь хүссэн зүйл нь бүрэн тусгагдаагүй байна хэмээн бухимдав. Гэхдээ тэр хүлээн авсан болохоор ажлын хөлсөө нэхэмжлэв.



Мэлхий могойны ууртайгаар зааварчлахыг дагаж, ваагласаар л явлаа. Алсад моддын орой цухуйж, нарны гэрэлд найган харагдахад могой тэр хоёр тэнд хүрэхийн тулд машины замаас хол зүлэгт хөндийг туулах хэрэгтэй байв. Шөнөдөө тэд чийгтэй нөмөр газар олж хоновч уснаас хол яваа болохоор мэлхийний вааглах хүч суларсаар байлаа. Харин могой түүнийг чанга вааглахыг шаардана. Удалгүй мэлхий дугарч чадахаа болиов. Тэгээд нэгэн модонд арайхийн наалдаад, мөчрөөс нь дуслах уснаас уух гэж оролдов. Тэр маш их ядарч, сэтгэлээр унасан байлаа. Ийм ойрхон ирчхээд, вааглаж чадахгүй болсноос болоод хүрч чадахгүй юм биш биз?

Бодол:

Ура. Би хийж чадлаа. Итгэмээргүй юм.

Би энд хүрч чадна гэж хэзээ ч бодож байгаагүй. Одоо би өөрийн гэсэн гэртэй болж чадах нь.

Мэдрэмж:

Ядарсан боловч тайвширсан. Ахынхаа зөвлөгөөг дагасандаа баяртай, сэтгэл хангалуун байв.


“Төмрөө ажлын хөлсөө аваад хөдөө амьдрах байр хайж эхлэв. Эцэст нь тэр өөрийн боломжид таарсан байшин олсон юм. Том гоёмсог биш боловч түүнд өөрт нь маш гайхамшигтай санагдаж байлаа”

Бодол:



Удалгүй шөнөдөө бороо орох болов. Мэлхийг том том бороон дуслууд сэрээхэд тэрээр баярлан цангаагаа тайлж, мөн эргэн тойронд нь цөөрөм бий болохыг харав. “Могой, сэрээрэй. Би вааглаж чаддаг боллоо” гэв. Тэгээд тэр хоёр аяллаа үргэлжлүүлж, нар жаргахын алдад Мэлхий хулс зэгсэн дунд байх нэгэн том цөөрмийг олж харав. Шөнийн тэнгэрийн доор ногоорох хөндий, аварга моддын дүрс сүүмийн харагдана. “Бид гэртээ ирлээ”.

Би бол хүчтэй. Би зорьсондоо хүрэхийн тулд юуг ч хийж чадна.





Мэдрэмж:

Өөртөө итгэлтэй, зорьсондоо хүрсэн, талархах

Төмрөө шинэ гэртээ аз жаргалтай байлаа. Тайвширч, стрессгүй болсон байв. Эрүүл мэнд нь мөн сайжирчээ.



Зүлгэн дээр гулсах чимээ гарахад мэлхий өөр нэгэн могой ирж байхыг харав. “Зогсоорой. Энэ бол миний нүд болж ирсэн мэлхий. Тэр намайг та нар дээр, гэртээ ирэхэд минь тусалсан. Түүнийг битгий идээрэй” гэж могой хэлэв. Мэлхий баярласнаа илэрхийлэн вааглаад, салах ёс хийлээ. Могойг гэр бүлийнхэнтэйгээ явсны дараа тэр гайхамшигтай чимээ сонсов. Дэвхрэг, шумуул, шувуудын чимээ улам тодорсоор, тэр дундаас Мэлхийнхэн, мэлхийнхэн гэх мэлхийнүүдийн дуу ялгаран сонсогдов. Түүнийг маргаашийн найзууд нь тосон авсан нь тэр билээ.

Бодол:

Би их азтай юм. Би байгальд хайртай. Би хүчтэй болохоор гайхалтай зүйлсийг бүтээж чадна.

Мэдрэмж:

Баяр баясгалан, талархал

Мэлхий өөрийн найз болох могойг хэзээ ч мартаагүй юм. Хэдийгээр нөхөрлөл гэж нэрлэхэд хэцүү ч хамтран ажилласнаар хэн хэндээ их тус болсон билээ. Мэлхий шиг, байгальд ойрхон амьдарч чадах болсондоо, цөөрмийн найзуудтайгаа учирсандаа онцгой баяр баяслыг зүрхэндээ мэдэрсэн юм.

Энэхүү үлгэрийг ярихдаа Төмрөө өөрийгөө хэрхэн хүчтэй болсноо мэдэрснээс гадна өөрийгөө хайрлах, халамжлах ёстойгоо ухаарч, өөрийн чадлын хэрээр зүтгэж байгаагаа ойлгоход тусалсан юм. Хүчтэй хэвээрээ үлдэж, бууж өгөхгүй байх ёстойг сануулсан болно. Бяцхан мэлхийг ойлгож чадсанаараа, түүний эр зориг, хичээл зүтгэлд баяр хүргэснээрээ өөртөө өгч чадахгүй байсан зүйлээ олж авсан юм.

ӨНДӨГНИЙ ТҮҮХ

Энэ аргыг олон улсын арт терапи буюу урлагийн сэтгэл заслын салбарт хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллахад өргөн хэрэглэдэг. Энэ арга нь хүүхдийн амьдарч байгаа орчин нөхцөл, хэрэгцээг тодорхойлох, эцэг эхийн хайр халамж, өөрийн үзэл бодол, асуудлыг хэрхэн харж байгаа зэргийг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой байдаг. Нэг талаар хохирогчийн нөхцөл байдлын үнэлгээгээ баталгаажуулж авах юм.

Зорилго: Хүүхдийн сэтгэл зүйн хэрэгцээг тодорхойлох, амьдарч байгаа орчны үнэлгээ хийх. Хэрхэн зохион байгуулах вэ? Өндөгний түүхийг мөн өмнөх үлгэртэй адил цуврал уулзалтаар хийж болно. Ихэвчлэн 1-3 удаагийн уулзалтад багтаавал сайн. Гэхдээ сүүл хэсэгт дахин хийлгэвэл хүүхэд хэрхэн өөрчлөгдсөн, асуудлаас гарах гарц шийдлээ хэрхэн олсон байна, даван туулах чадвар нь хэр зэрэг байна гэх мэт үнэлгээ хийхэд хэрэгтэй.

Бэлтгэл: Өмнөх үлгэртэй мөн адил А4 цаасыг бяцхан ном хийх гэж байгаа байдлаар нугалж, 6-8 эсвэл түүнээс дээш 10 хуудастай ном хийлгэж болно. Энэ дасгалыг хийхэд чимэглэх зүйл хэрэггүй. Зөвхөн харандаа, өнгийн фломастер, цаас бэлдэнэ.

Хэрхэн ажиллах вэ? Хүүхдүүдтэй ажиллахдаа өмнө нь нүүр хагарах дасгал хийлгэсэн байх нь зүйтэй. Хүүхдийг шууд зураг зуруулаад суух нь зурж чадахгүй гэсэн айх мэдрэмж төрүүлэх



учраас хүүхдэд чөлөөтэй байх, тайван байлгах орчин бүрдүүлсний дараа хийлгэх нь зүйтэй. Зураг зурахдаа заавал гоё, сайхан зураг зурах гэж хичээх хэрэггүй гэдгийг эелдгээр хэлээд би ч гэсэн зураг зурж чаддаггүй гэх мэтээр хэлээд хамт хажууд нь зураад суух юм уу эсвэл хааш яаш зурсан зургаа хананд өлгөх юм уу ширээн дээрээ тавьсан байх нь зүйтэй. Ингэснээр хүүхдэд зургийн хичээлд сууж байгаа мэдрэмж төрөхгүй.

Анхааруулга: Чиглүүлэх асуултаа маш тодорхой асуух хэрэгтэй.

Хүүхдүүд танаас өгөх бяцхан урмаар өндөгний түүхийг зохиох боломжтой юм.

Бүх алхмыг төсөөлөөд энэхүү загварын дагуу өөрийн гэсэн түүхийг нь бүтээлгээрэй.

Хүүхдээс асуух: Ямар амьтны өндгөөр зурагтай номоо хийх вэ?/азарган тахиа, динозавр, луу, могой, гүрвэл болон матар гэх мэт өндөглөдөг амьтан сонгуулах/



Хуудас 1

Асуулт 1. Зорилго: Хүүхдийн эрүүл, аюулгүй орчны талаарх ойлголтыг шалгах

1. Чи надад өндөг зураад өгөөч?
2. Өндөг хаана байна вэ?
3. Үүр нь хаана байгаа вэ?
4. Аюулгүй байна уу?
5. Дулаахан байна уу?

Ажилтан: Хүүхэд ярьж байх хугацаанд тэмдэглэл хөтлөөд, хүүхэд зурж дууссаны дараа хуудасны доор хоёр энгийн өгүүлбэр бичиж болно Жишээлбэл: Өндөг нь цэнхэр өнгөтэй байсан. Шувууны үүрэнд аюулгүй байсан. Голын эргийн хажууд, дулаахан бөгөөд тухтай байсан гэх мэт.



Хуудас 2

Асуулт 2. Зорилго: Хайр, Халамж, Анхаарал хандуулах талаар ойлголттой байгаа эсэхийг мэдэх

1. Өндөгний ээж нь хаана байгаа вэ?
2. Аав нь хаана байгаа вэ?
3. Тэднийг зурж чадах уу?
4. Аав ээж нь юу хийж байгаа вэ?
5. Жижигхэн өндгөө хаана үлдээснийг тэд мэдэж байгаа юу гэх мэт асуултыг хүүхдээс асууна

Ажилтан: Хүүхэд зураг зурж байх хооронд хүүхдийн хариултуудыг хэдэн өгүүлбэрт багтааж бичиж болно. Цэнхэр өндөгний ээж нь наранд унтаж байсан. Тэр өөрийнхөө хүүхэд өндөгтэй маш ойрхон байсан. Аав нь явчихсан гэх мэт.



Хуудас 3

Асуулт 3. Зорилго: Хүүхдийн хүлээлт, хайр, аав ээжийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг шалгах

1. Өө өндөг чинь бага зэрэг хөдлөөд байна шүү дээ. Удахгүй хагарах гэж байгаа юм биш үү? Өндөг хагарч байгаагаар зурж чадах уу?





2. Хүүхэд зурж байх хооронд ээж нь одоо хаана байна вэ?
3. Ээж нь баярлаж байна уу?
4. Аав нь өндөг хагарч байгаа гэдгийг мэдэж байгаа болов уу?
5. Ээж нь юу хийж байна?
6. Өндгөн дотор байгаа хүүхэд нь юу мэдэрч байна? гэж хүүхдээс асуу. Хүүхдийн бүтээл болон хүүхдийн зохиосон түүхийг дүгнэн хэдэн өгүүлбэр бичиж болно.
7. Хүүхэд төрчихлөө/Өндөг хагарчихлаа. Хүүхэд өндөгнөөсөө гарахыг маш их хүсэж, дуу чимээ гаргаж байсан. Ээж нь унтаж байгаад сэрэх ёстой болсон учраас уурласан. Хүүхэд “Ээж ээ, Ээж ээ” гэж дуудаж байсан. Хүүхэд нь маш их айж байсан.



Хуудас 4

Асуулт 4. Зорилго: Хайр болон халамж, дасах байдлыг шалгана.

Хүүхэдтэй ярих, асуух.

1. Өндөг хагарчихлаа.
2. Хүүхэд юу хийж байна вэ?
3. Хүүхдийн хийж байгаа зүйлийг чи зурж чадах уу?
4. Хүүхэд аавтайгаа байна уу?
5. Ээжтэйгээ байна уу?
6. Шинээр мэндэлсэн хүүхдэдээ тэд хайртай байна уу?
7. Хүүхдээ тэд юу гэж дуудаж байна?
8. Хүүхэдтэйгээ тэд юу хийх бол?
9. Хүүхэд аав ээжийгээ юу хийгээсэй гэж хүсэж байна?

Ажилтан тэмдэглэлээ хөтөлнө. Жишээлбэл: түүхийн дагуу хэдэн өгүүлбэр бичиж болно.

- Хүүхэд одоохондоо нэргүй байгаа. Зүгээр л хүүхэд. Хүүхэд өлсөж байгаа. Хүүхэд өт хайхыг оролдож байна. Хүүхэд ээжтэйгээ тогломоор байгаа боловч ээж нь би аяга таваг угаах хэрэгтэй байна гэж хэлнэ. Хүүхэд өт ухаж олохоор ой руу явлаа.



Хуудас 5

Асуулт 5. Зорилго: Хүүхэд аюулд өртсөн үед эцэг эхийн хамгаалалт болон хариу үйлдлийн талаарх ойлголт авах.

Хүүхэдтэй ярилцах, асуулт асуух

1. Өө яана аа. Аюултай амьтан ирж байгаа дуу сонслоо. Хүүхдүүдээ зугтаарай, гүйгээрэй. Хүүхэд/боломжит аюултай амьтан/-аас зугтаж байгаагаар зурж чадах уу?
2. Аюултай амьтныг хараад аав ээж нь юу хийж байна?

Ажилтан: Хүүхдийн хариугаар хэдэн өгүүлбэр бичнэ. Үнэг хүүхдийг хөөж байна. Хүүхэд гүйнгээ ээжийгээ дуудсан боловч ээж нь завгүй байлаа. Хүүхэд аавыгаа харлаа. Аав нь үнэгийг айлгаад явуулчихсан.





Хуудас 6

Зорилго: Хүүхдийн өөрийн хүч чадал, нөөц боломж, итгэл найдвар хэр зэрэг байгааг тодруулах

Хүүхэдтэй ярилцах:

1. Би хүүхдийг маш аз жаргалтай байгаагаар энэхүү түүхийг дуусгамаар байна. Амар сайхандаа жаргажээ гээд төгсдөг түүхүүдийг мэдэж байгаа биз дээ. Амар сайхандаа жаргажээ гэсэн төгсгөлийг хоёулаа зурна. Чи зурж чадах уу? Хэдэн өгүүлбэр бичнэ үү.
2. Хүүхдийн агуй дахь гэрт нь маш онцгой найз ирсэн. Хүүхэд маш их хөгжилтэй байсан бөгөөд орой бүр пицца иддэг байсан. Үргэлж үнэгийг айлгадаг маш онцгой найз буюу нохой найзтай болоод тэд амар сайхандаа жаргажээ.
3. Хүүхдийн хүнд хэцүү, сэтгэл өвтгөм түүхийг бичихээсээ бүү ай. Амар сайхандаа жаргажээ гэсэн төгсгөл нь хүүхдэд тус нэмэр болдог. Хүүхдэд ямар ч хамаагүй түүх бичих эрх чөлөөг олго, танд зөв юм шиг санагдаж байгаа түүхийг бичүүлэх гэж бүү хичээ.

Анхааруулга:

- Чи бага зэрэг түрэмгий загнаад боломжит аюулт амьтныг аав ээж нь алчихсан гэж бичиж болно. Аав ээж нь хамгаалалтын хашаа, дохиоллын систем магадгүй өөр зүйл хийж болох байсан уу? гэж асууж болох ч түрэмгий зантай аав ээж нь хүүхдийн хувьд хамгийн сайн хамгаалагч гэж тусч болох учраас энэ нь сайн зүйл байж болно. Хэдийгээр бид хэрцгий, түрэмгий байдлыг дэвэргэх бодолгүй байгаа ч энэхүү хэрцгий байдлыг хамгаалалт гэсэн үүднээс үзвэл түрэмгий, хэрцгий байдлыг дэвэргээгүй болох нь харагдана.
- Ингэж түүх ярих нь хүүхэд байгаа байдлаа ойлгох, мөн ирээдүйд итгэх итгэлтэй болоход тусалдаг.

Дасгал хийхэд анхаарах зүйл:

- Хүүхэд өөрт тохиолдсон аливаа түүхийг аюулгүй, тааламжтай орчинд ярихад нь туслах
- Заримдаа том хүмүүс муу зүйл хийдэг гэдгийг ойлгоход хүүхдэд туслах. Энэ нь хүүхэд ямар ч буруугүй гэдгийг мэдрэхэд туслах.
- Хүүхдэд байгаа аливаа сөрөг мэдрэмжийг бусад хүмүүст ч гэсэн тохиолддог гэдгийг ойлгуулах, хэвийн болгох. Ингэснээр хүүхэд өөрт нь ганцхан энэ асуудал тохиолдоогүй учраас эргээд би аз жаргалтай амьдрах ёстой байна гэдгийг ухаарах итгэл найдвар төрүүлэх нь чухал.

БЯЦХАН НОМ ХИЙХ



Хүмүүнлэгийн байгууллагын ажилчид 1950 оноос хойш хүүхдийг үрчлэх, түр хугацаагаар айлд асруулахаар явж байгаа хүүхдүүдэд зориулж өөрийнхөө амьдралын талаар түүх бичих номыг үйлчилгээнд нэвтрүүлж эхэлжээ. Улмаар 1970 оноос хойш "Амьдралын түүх" бичих ном нь албан ёсоор эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд ашиглагдаж



эхэлсэн байна. Бүтээлийн зорилго нь өөрийн амьдралын түүхээ мэдэх, өөрийн гэр бүлээ мартаггүй байх, өөрт тулгамдсан асуудлын шийдлийг олоход нь туслах ач холбогдолтой гэж үздэг. Хүн амьдралын туршид тохиолдсон зүйлээ ярихгүйгээр илэрхийлж байхдаа өөрийн амьдралынхаа баатар нь болж чадах юм байна гэсэн итгэл төрдөг.


Дээрх түүхтэй холбож энэхүү бяцхан номыг хийж болно. Мөн хүүхдийн өмнөх амьдралын түүхийг сануулахгүйгээр хүсэл, мөрөөдлөөр нь ч ном хийлгэж болох юм.

Ашиглах материал:

Хэрэглээд дууссан хатуу хавтастай ном, зургийн дэвтэр, өнгийн харандаа, хайч, цавуу, усан будаг, багс, бийр, чимэглэх зүйл хангалттай байх

Ном хийх зааварчилгаа:

- Эхлээд хүүхэд, насанд хүрэгчдээр өөрийн нэрийг хамгийн гоё, чамин, өвөр байдлаар бичүүлнэ
- Өөрийгөө хэн бэ гэдгийг илэрхийлэх зураг зурж болно. Эсвэл дүрс хайчлаад нааж болно



- Хохирогч өөрийгөө илэрхийлсэн амьтан зурж болно.
- Номын хуудсаа 6-10 хуудастай байхаар бодож бэлдэнэ.
- Хохирогчоор Мандалаа зуруулж болно. Ингэхдээ хүнд хэцүү, дарамт, стресс өгөхгүй аль болох хөнгөн мандалаа зуруулах юмуу эсвэл бэлэн Мандала авч өнгөөр будуулж бэлдүүлнэ. Бичихдээ өөр хэлбэр, дүрс, дуртай зүйлээ илэрхийлсэн маягтай хийлгэнэ.



Бусад дасгалууд

Дараах дасгалууд нь хүүхэд болон насанд хүрэгчдийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, уур бухимдал, стрессийг бууруулах, анхаарлыг төвлөрүүлэх, өөртөө төвлөрөх, өөрт тулгамдсан асуудлаа ойлгох, айдас түгшүүрийг бууруулах болон сэтгэл хөдлөл, зан байдлаа зохицуулж сурахад нь туслах юм.

ДАСГАЛ 1. ХЯЗГААРГҮЙН БЭЛГЭДЭЛ 8 ТОО ДАСГАЛ



Зорилго

Хохирогчдыг тайвшруулах, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нэг зүйлд анхаарлыг нь төвлөрүүлэх



Бэлтгэл

- А3 хэмжээтэй цаас
- Өнгийн фломастер, өнгийн зөөлөн тосон харандаа
- Ширээн дээр цаасаа хөдөлгөөнгүй болгож скочоор тогтооно
- Хохирогчдоо тайван байлгаж зурахад нь бэлдүүлнэ, урам өгнө, өөрөө мөн хамтдаа зурна гэдгээ хэлнэ

- Тэдэнд бие, гарын хөдөлгөөн дээрээ төвлөрч, гоё зурсан эсэхэд санаа зовох хэрэггүйг сануулаарай.
- Удаан ч, түргэн ч тэднийг нэгэн жигд хөдөлгөөнөөр зуруулахыг хичээнэ.
- Зурж байхдаа урт амьсгаа авч гаргана. Тэд амьсгалынхаа хэмнэлийн дагуу зурж чадах нь уу? гэдгийг анзаарна.



Үйл явц

- Энэ дасгал нь сэтгэл, санаагаар унасан, гутарсан, агдаж тэвдсэн, сандарсан бүх насны хүмүүст тайвшрахад нь тус болдог.
- Энэхүү дасгалыг анх удаа хийж байгаа хүнд жаахан амаргүй байж мэдэх ч тэднийг эелдгээр зоригжуулах нь чухал. Та дэргэд нь байж хамтдаа дасгалыг хийсэн ч болно.
- Дасгалыг насанд хүрэгчдээр хийлгэхдээ нүдийг аниулж хийлгэж болно.
- Хүүхдийн нүдийг нээлтэй чигээр нь гүйцэтгүүлнэ. Учир нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд байнга айдас түгшүүртэй байдаг учраас тэднийг айдаст оруулах эрсдэлтэй.
- Тэд гардаа бүрэн итгэснээр зураг бүтээгдэнэ. Зураг өнгө үзэмжтэй, төгс сайн болох албагүй. Хамгийн гол нь тэд тайвширч, өөрийн биед итгэх нь чухал.



ДАСГАЛ 2. БИЕТ ЗҮЙЛЭЭР ИЛЭРХИЙЛЭХ АРГА

Зорилго

Хүүхдүүдэд өөрийн гэсэн үнэт зүйлсийг бий болгох, өөрийн гэр бүлээ байнга санаж байхад нь туслах

Хүүхдүүдийг гэрээс нь өөр газар уруу авч явахад хүүхдүүдэд аймшигтай санагддаг шүү дээ. Нэг орчноос нөгөө рүү дамжин урт, богино хугацаагаар өөр газар дамжин амьдарч байхдаа хүүхэд өөрийн болон гэр бүлийн үнэт зүйлсээ мартаж эрсдэлтэй байдаг. Улмаар ямар ч харьяалалгүй болдог. Харин урлагийн ямар нэг биет зүйл нь тэдэнд өөр газар уруу нүүсэн ч хайртай хүмүүс, өөрсдийн үнэ цэнтэй зүйлс нь байгаа гэдгийг санахад тусалдаг. Тэд энэ биет зүйлээ биедээ авч явах хэрэгтэй. Биет зүйл нь жижигхэн, амархан элэгдэхээргүй байна. Тэд үүнийгээ харахдаа гэр бүлээ эргэн санаж, үнэт зүйлсээ санаж, хэзээ нэгэн цагт сайн сайхан амьдралд хүрнэ гэсэн итгэл найдвар өгдөг.





Бэлтгэл

- Өнгийн харандаа
- Өнгийн маркер
- Канвас юмуу хатуу кардон цаас
- Шавар
- Баримлын шавар



Үйл явц

Жишээлбэл: гэр бүлийн бүх гишүүд өөрсдийн тэр өдрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн энгийн Мандала зурна. Үүний дараа Мандалагаа хүний тоогоор хувааж канвас дээрээ наана. Канвас дээр бүх хүний сэтгэгдэл орох учир эргэн санахад тэдэнд үргэлж урам зориг өгдөг. Хамтдаа шүү гэдгийн сануулдаг. Ийнхүү 3 хүн байвал 3 канвастай болно гэсэн үг.

Гэр бүлийн гишүүд бүгд оролцож хийсэн бүтээл байх



ДАСГАЛ 3. ЭЛСЭН ДЭЭР ТОГЛОХ ЗАМААР ХОХИРОГЧТОЙ АЖИЛЛАХ НЬ



Зорилго

Хохирогчид хүнд хэцүү бэрхшээлийг даван туулах үедээ өөрийн олж авсан сургамжаа хүүрнэн өгүүлэх аргаар бусадтай хуваалцаж, амьдралын хэтийн зорилгоо тодорхойлох, асуудлаасаа гарах гарцаа олоход нь туслах

Хэнд тохиромжтой вэ? - Бүх насныханд тохиромжтой.

Давтамж: Мөн л үлгэртэй адил эхлэл, өрнөл, төгсгөлтэй болгоход анхаарч ажиллах хэрэгтэй. Хохирогчийн асуудал, өөрийн онцлог зэргийг харгалзаж үзээд 4-5, 6-8 удаагийн уулзалтаар зохион байгуулж болно.

Зааварчилгаа: Энэхүү дасгал нь хохирогчийг бүтээлч байх зуураа асуудлаа өөр өнцгөөс олж харах, эргэцүүлэх, гарц шийдэл олох, цаашдын хэтийн зорилгоо тодорхойлоход нь тусална. Элсэн дээр тоглох зуур мэргэжилтэн зарим нэг зүйлүүдийг тодруулж асууж болно. Энэ нь тухайн хүнийг өөр өнцгөөс харах, санаа оноо олоход нь туслах юм. Ингэхдээ өөрийн санаагаа тулгаж болохгүй. Хохирогчийн ярьж, хийж байгаа зүйлээс л тодруулж асууж болно.





Бэлтгэл

Үлгэрийн баатрууд, болон жижиг тоглоомууд/ аль болох хүний амьдралыг бүхэлд нь илэрхийлж болох зүйлсийг цуглуулах/ Элсэн хавтан

Санамж: Байгальд ээлтэй байх үүднээс хүүхдүүдийн хэрэглэхгүй тоглоомуудыг цуглуулах аян өрнүүлээд түүгээрээ хохирогчдодоо туслах хэрэгслээ болгож болно.



Үйл явц

- Элсэн хавтан ашиглан өөрийн дотроо ичиж, шаналж, санаа зовж явдаг зүйлийнхээ талаар өгүүлнэ.
- Өөрийгөө болон бусдыг амьтан, үлгэрийн баатрууд, эсвэл ямар нэгэн зүйл ашиглан орлуулна.
- Мөн хүндрэлтэй, бэрхшээлтэй сэтгэл хөдлөл болон мэдрэмжийг ямар нэгэн дүрс эсвэл баатраар илэрхийлж болно.
- “Би, надад” гэх мэт үгс хэрэглэхгүй, харин “Бяцхан яст мэлхий гунигтай байлаа. Түүнд нэг хэцүү зүйл тохиолджээ” гэх мэтээр бичнэ. Яст мэлхий /чи/ хүнс авах мөнгөгүй болжээ гэхийн оронд “Бяцхан яст мэлхий галын дэргэд тухлан хэвтмээр байсан ч түүнд аль аль нь байсангүй” гэх нь зүйтэй.



Монголын Урлагийн Сэтгэл Заслын Мэргэжлийн Холбооны байранд хохирогч өөрийн түүхээ үлгэр болгон хүүрнэж буй хэсэг 2019 оны 6 сар



ДАСГАЛ 4. ӨӨРИЙН АЮУЛГҮЙ ОРЧНОО БҮТЭЭХ

Зорилго

Энэхүү дасгал нь хүүхдүүдэд аюулгүй орчныг хэрхэн бүрдүүлэх талаар тунгаан бодож үзэхэд нь тусалдаг. Мөн энэхүү дасгал нь тайвшруулах бөгөөд хүүхдүүдэд юу хэрэгтэй байгааг илүү тодорхой болгоход тусална.

Бэлтгэл

- Үлгэрийн баатар, амьтан эсвэл бусад дүрс
- Урлагийн хэрэгслүүд



Арт терапи төвд хүүхэд, эцэг эхтэйгээ хамт бүтээсэн аюулгүй орон зай

Үйл явц

Хүүхдүүд өөрийгөө амьтнаар төлөөлүүлж өөрт аюулгүй, тааламжтай орчин юу байж болох талаар бодуулахын тулд өөрсдийг нь бүтээлч байлгах, бодуулах, эргэцүүлэх боломж олгох юм.

- Цаасан хавтан дээр ямар нэгэн дүр сонгох/ихэвчлэн амьтад байж болно/
- Урлагийн хэрэгслүүд, материалуудыг ашиглан тухайн дүр болон түүний аюулгүй орчныг бүтээнэ.
- Тухайн бүтээсэн дүр нь ямархуу харагдаж байна вэ? Юу шиг харагдаж байна вэ?
- Аюулгүй орчныг нь бүтээхэд өөр юу хэрэгтэй байна ?
- Хоол, унд, орон байр, хэн хажууд нь байх гэх мэт хүүхдээр өөрөөр нь бодуулах боломж олгоно.

ДАСГАЛ 5. ТЭГЭЭД ШҮДНИЙ ЭМЧ ХЭЛЭХДЭЭ

Зорилго

Хохирогч тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, гарцаа олоход нь туслах

- Ямар нэгэн нөхцөл байдалд сонирхолтой байдлаар хариу үйлдэл үзүүлсэн тухайгаа зур./Хүн чамтай уулзаагүйн төлөө маш ихээр уурлаад тэдэн рүү залгаад орилох гэх мэт/
- Бүх дүрүүдийг гаргаад энгийн асуултууд асуу. Жишээлбэл: Шүдний эмч Харсан зүйлийнхээ талаар юу хэлэх байсан бол?
- Чиний ээж тэнд юу болсон гэж бодох байсан бол?
- Цагдаа одоо юу болох хэрэгтэй гэж хэлэх байсан бол?
- Мөн чи нэргүй зарим нэг хүмүүсийг үлдээгээд дараа нь тэдгээрийг хүссэнээрээ нэрлэж болно. Жишээлбэл: Жонигийн ээж/Чамайг сургууль дээр цохисон хүү/
- Чи энэхүү үйл ажиллагааг олон төрлийн дүрүүдээс сонгоод хийж болно.

Бэлтгэл

- Тодорхой дүрүүд
- Урлагийн хэрэгслүүд

ДАСГАЛ 6. АЮУЛГҮЙ ГАР

Зорилго

Хамтын ажиллагааны үнэ цэнийг тодорхойлох. Хохирогчийн амьдралд нь хамгийн чухал зүйлийг илрүүлэх.

Үйл явц

- Хохирогчдыг аюултай, хүнд хэцүү цаг үеийг туулахад танд туслах болон тантай ярилцаж чадах таван насанд хүрсэн хүний тухай бодохыг хүсэх. Тухайлбал: эцэг эх, найз нөхөд, багш болон сургууль, цагдаа, эмч гэх мэт байж болно.
- Хохирогчид цаас өгч өөрийнх нь гарыг зуруулна. Үүний дараа зурсан гарынхаа хуруунууд дээр танд хэцүү зүйл тохиолдсон үед хэнтэй ярилцах вэ гэдгээ бодож бичихийг хүсэх.
- Хохирогч бусадтай сэтгэгдлээ хуваалцана.
- Мөн чиглүүлэгч хохирогчид цаасны оронд баримлын шавар өгч болно. Хохирогч дээр дурдсан зааврын дагуу гараа баримлын шавраар дүрслэн түүнийгээ янз бүрийн чимэглэлээр чимэглэнэ. Түүнийг хатсаны дараа гэртээ өлгөх боломжтой байдаг.

Бэлтгэл

- А4 хэмжээт цаас
- Баримлын шавар
- Өнгийн харандаа
- Өнгийн маркер





ДАСГАЛ 7. БИД ӨӨРСДИЙГӨӨ ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛЖ ЧАДНА.

Зорилго: Оролцогч сэтгэл хөдлөлөө илэрхийлэх болон асуудал шийдвэрлэх чадвараа хөгжүүлэх, эрсдэлийг даван туулах чадварт суралцана

Үе шатууд:

- Бүтээл хийх
- Бүлгийн ажил
- Хэлэлцүүлэг

Хэрэглэгдэх материал: Сонин, сэтгүүл, ил захидал, бодит зураг

Оролцогчдын эзэмших чадвар: Оролцогч нь өөрийгөө таньж мэдэх, өөрийн зан араншиндаа дүгнэлт хийх, бусдаас суралцах, өөртөө итгэлтэй болох, харилцааны ур чадварт суралцах

Хугацаа: 45 минут

Бүлгийн гишүүдийн тоо: 6-8

Гүйцэтгэх алхмууд:

1. Акрилка будгийг хүн бүрд тарааж өгнө. Тэд дуртай өнгөө сонгоцгооно. 14x28 хэмжээтэй цагаан ватум цаасны ард бариул хийж бамбай болгож ашиглахад бэлэн болгож, урьдчилан бэлдсэн байна.
2. Хамгаалалтын бамбай хийх

Тухайн хүн арслан бүтээсэн бол түүнээс өөрийгөө хамгаалахад нь шаардлагатай хаалт бамбай бүтээж бас болно. Үүнийгээ ямар хэлбэр дүрстэй, ямар материалаар хийх нь тухайн хүний бүтээлч сэтгэхүйгээс шалтгаална.

Шаардагдах зарим материалыг дор жагсаав. Үүнд:

- Бамбай хийх хатуу цаас, эсхүл цаасан хайрцаг байж болно
- Будаг, харандаа, фломастер
- Хайч
- Тугалган цаас, эсвэл төмөрлөг өнгийн будаг
- Зарим нэг гоёлын металлууд, зураг
- Цавуу болон цавууны буу
-

Зааварчилгаа:

- Цаасан хайрцаг дээрээ бамбайны дүрс гарган зураад, хайчилна
- Бамбайгаа будах буюу тугалган цаасаар бүрнэ.
- Луу болон санаа зовоон түгшээж байгаа зүйлсээс түүнийг юу хамгаалж болохыг төсөөлөн бамбайн дээрээ зурна. Тухайлбал арслан, эсвэл нар гэх мэт юу ч байж болно. Энэ тохиолдолд тухайн хүнтэй эсхүл хүүхэдтэй ярилцан, сонголт хийж бас болно.
- Эдгээр хамгаалалтаа бамбай дээрээ зурж, нааж тогтоож болно. Тэгээд бамбайгаа хаа нэгтээ өөрт харагдах газартаа өлгөж, хадгалж болно.



ДАСГАЛ 8. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ АЛТАН ДҮРЭМ

Зорилго: Оролцогч өөрт тулгамдсан асуудлаа ойлгох, хэрхэн, ямар алхам хийх талаараа бодож үзэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах ямар алхам хийж болох талаар бодож, үйлдэл хийж сурах

Үе шатууд:

- Бүтээл хийх
- Бүлгийн ажил
- Хэлэлцүүлэг

Хэрэглэгдэх материал: Ватум цаас, самбарын цаас

Оролцогчдын эзэмших чадвар: Өөрийгөө таньж мэдэх, өөрийн зан чанарт дүгнэлт хийх, бусдаас суралцах, өөртөө итгэлтэй болох, харилцааны ур чадварт суралцах, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, бусадтай хүндэтгэлтэй харилцах, бусдыг ялгаварлан хандахгүй болох

Хугацаа: 45 минут

Бүлгийн гишүүдийн тоо: 6-8

Гүйцэтгэх алхмууд:

Оролцогчдод дараах зүйлийн талаар бодох мөн энэ талаар товч мэдээлэл өгнө.



- ЗОГС** Гүнзгий амьсгаа ав, тайвшир, юу болоод байгааг анзаар
- МЭДЭР** Ямар асуудал үүсээд байгааг бод. Ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж байна?
- БОД** Асуудлаас гарч болох олон арга зам, гарцуудыг бодож үзээрэй
- СОНГО** Юу хийх шийдвэрээ гаргаж сонголтоо хийгээрэй. “Би ___-ийг хүсэж байна.”
- АЛХАМ ХИЙГЭЭРЭЙ** “Би -----д бэлэн байна.” Түүнийгээ хийгээд үз!

1. Оролцогчдоос өөрт нь юу хүч, урам зориг өгдөг, бусад хүмүүс тэсвэрийг нь алдтал уурлуулах эсхүл хүчин мөхөстөх үед тайвшрахад юу тусалдаг талаар эргэцүүлэн бодохыг хүснэ.
2. Үүний дараа ватум цаасан дээр бодсон зүйлээ дүрслэн зурах эсвэл зураг наахыг хүснэ. Энэ нь магадгүй мод, уул, цэцэг, хүрхрээ, гол, бороо, солонго, нар, сар, амьтан, шувуу, гэр бүлийн сүлд тэмдэг, байшин, хүн гэх мэт юу ч байж болно.
3. Оролцогчдоос “Үе тэнгийнхний дээрэлхэл, дарамт гэж юу вэ?” хэмээх асуултад хариулна.
4. Хүүхдүүд тодорхой жишээ дурдаж, жүжигчилсэн тоглолтоор үзүүлж, ямар хариу үйлдлүүд үзүүлж болох талаар бодол санаагаа уралдуулна.
5. Тэд айх, сандрах, санаа зовох, мухардалд орох, ганцаардах үед төрдөг сэтгэгдэл мэдрэмжүүдээ өөрсдийнхөөрөө илэрхийлнэ. Асуудлаа уудалж эхлэхэд нь чиглүүлэгч “Аюулгүй ажиллагааны алтан дүрэм” ашиглахыг сануулан “Зогс!” хэмээн дохио өгнө.
6. Үүний дараагаар “Бод”, “Мэдэр”, “Сонголтоо хийх”, “Алхам хийх” талаар хэлэлцэн өөр арга хувилбарууд дээр ажиллана.

Санамж: Аль болох хохирогч бүрийг тэгш оролцуулж, тэдний санаа бодлыг сонсох, бусдадаа хэрхэн тусалж болох талаар ярилцах нь зүйтэй.



ДАСГАЛ 9. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН УТАС 108

Зорилго: Хүүхдүүд багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, эрсдэлт нөхцөлд хэрхэн өөрийгөө хамгаалах дадлага хийх

Үе шатууд:

- Бүтээл хийх
- Бүлгийн ажил
- Хэлэлцүүлэг

Хэрэглэгдэх материал: Бичгийн цаас, ватум цаас, маркер



Оролцогчдын эзэмших чадвар: Хүүхдүүд гэнэтийн аюултай, эрсдэлтэй нөхцөл байдлаас өөрийгөө хэрхэн хамгаалах, даван туулах ур чадварт үйлдэл хийнгээ суралцана

Хугацаа: 45 минут

Бүлгийн гишүүдийн тоо: 6-8

Гүйцэтгэх алхмууд:

1. Оролцогчид нэг цаас авч дөрвөн хэсэг нугална. Хамгийн зүүн дээд булангаас эхлэн тэд "Аюулгүй ажиллагааны алтан дүрэм"-ийн ашиглаж болох жишээ нөхцөлийг зурна. Жишээлбэл: Зүүн дээд буланд ЗОГС - гүнзгий амьсгаа ав, тайвшир юу болоод байгааг анзаарч юу тохиолдож буйг бодно. Ямар асуудал тулгамдаж байгаагаа бодож, зурна эсхүл бичнэ.
2. Баруун дээд буланд **МЭДЭР** - ямар асуудал үүсээд байгааг бод. Ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж байна? Хэсэгт өөрт юу мэдрэгдэж өөрөөр хэлбэл сэтгэл санаа нь ямархуу байгаагаа зурна.
3. Баруун доод буланд **БОД** - асуудлаас хэрхэн гарч болох олон арга зам, гарцуудыг бодож үзээрэй хэсгийг буюу асуудалд ямар гарц байгааг зурна.
4. Зүүн дээд буланд **СОНГО** - юу хийх шийдвэрээ гаргаж сонголтоо хийгээрэй. "Би _____-ийг хүсэж байна."
5. Зүүн доод буланд **АЛХАМ ХИЙГЭЭРЭЙ** - "Би _____ д бэлэн байна." Түүнийгээ хийгээд үз!
6. Сурагчид тойргоор зогсож хийсэн бүтээлээ гартаа барина. Бөмбөр нижгэнэх дуугаар эхлэн тэд өөрсдийн "Аюулгүй ажиллагааны алтан дүрэм"-ийг үзүүлэн зогсоно (Зогс, Мэдэр, Бод, Сонго, Үйлд).
7. Дараа нь сурагчид **Яаралтай тусламжийн утас: 108** сэдвээр жүжигчилсэн тоглолтыг хийнэ.
8. Нэг нь асуудлаа ярих холбогдогч болно. Малгай дотор кэйс тохиолдлуудыг бэлдэж, асуудлаа ярих ёстой оролцогчоор сугалуулна.
9. Холбогдогч тусламжийн утас руу холбогдож, сугалсан асуудалдаа тусламж хүснэ.
10. Өөр нэг сурагч яаралтай тусламжийн утасны зөвлөгч болно.
11. Үлдсэн оролцогчид нь үзэгч, мэргэжилтнүүд болж зөвлөгчид асуудлыг шийдэх санаа, оноог зөвлөнө.
12. Жүжигчилсэн тоглолтын үед дараах сэдвүүдийг хэлэлцэнэ. Үүнд: Оролцогчдод тохиолдож байгаа болон тохиолдож болох тулгамдсан асуудлуудыг оруулна. Тамхи татах, хулгайн асуудал, зодоон цохион, дээрэлхэл, дээрэм, хар тамхины хэрэглээ, гэр бүлийн хүчирхийлэл гэх мэт

ДАСГАЛ 10. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН УТСААР ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨГ АМЬДРАЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилго: Оролцогчид бусдын сайн туршлага, зөвлөгөөг хэрэглээ болгох, хүндрэлтэй асуудлыг даван туулах арга барилд суралцах

Үе шатууд:

- Бүтээл хийх
- Бүлгийн ажил
- Хэлэлцүүлэг

Хэрэглэгдэх материал: Баримлын шавар, цаас, малгай

Оролцогчдын эзэмших чадвар: Бусадтай харилцаж сурах, асуудлыг нарийн учрыг тодорхой болгож, түүнээс гарах гарц, гаргалгааг олж сурах

Хугацаа: 45 минут

Бүлгийн гишүүдийн тоо: 6-8

Гүйцэтгэх алхмууд:

1. Оролцогчид өөрийн харсан хамгийн сайхан гүүрийг хийнэ. Чиглүүлэгч ямар гүүр байж болох талаар санаа өгч болно.
2. Чиглүүлэгч ширээн дээр гөлгөр цэнхэр цаас тавьж усыг төлөөлүүлнэ.
3. Ширээний нэг буланд 18x24 хэмжээтэй эмх замбараагүй нийгмийг илтгэсэн бүтээл хийж байршуулна.
4. Ширээний нөгөө буланд энх тайван, амар амгалан ертөнцийг дүрсэлсэн бүтээлүүдээ байршуулна.
5. Зөөлөн баримлын шаврыг өөрсдийн дүрслэлийг бүтээхэд ашиглана.
6. Оролцогчид өөрсдийн хүч чадал, сонирхол, аюулгүй байдал, итгэл бишрэлийг баримлаар урлана.
7. Урласан зүйлсээ хамтдаа хийсэн гүүрний дээр доор, эргэн тойронд байршуулна.
8. Үүний дараа баг бүрд утасны аппаратыг юмаар төлөөлүүлэн өгнө.
9. Үүний өмнө жижиг цаасан дээр "Асуудлууд"-аа бичиж малгай дотор хийн баг тус бүрд өгсөн байна.
10. Оролцогчид **Яаралтай тусламжийн утас** ажиллуулан тодорхой тохиолдлууд дээр дүр бүтээж тоглоно. Өгөх тохиолдлууд нь: Үе тэнгийнхний дарамт (мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээтэй холбоотой), эрсдэлтэй сонголт хийж буй найздаа итгэхээ болих, гэр бүл доторх асуудал гэх мэт байна.





ДАСГАЛ 11. ЭЭРЭГ ЗАН ТӨЛӨВИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ

Зорилго: Оролцогчдод өөрийн амьдралд тохиолдож буй хүчирхийллийн талаар өөрийн байр сууриа илэрхийлэх боломж олгох

Үе шатууд:

- Бүтээл хийх
- Бүлгийн ажил
- Хэлэлцүүлэг

Хэрэглэгдэх материал: Цаасан таваг, бал харандаа, урт иштэй сойз, өд, гялгар чимэглэл

Оролцогчдын эзэмших чадвар: Асуудлыг шийдвэрлэх, аливаа асуудлын учир шалтгаан, үр дагаврыг ойлгох, гарц гаргалгааг олж сурна.



Хугацаа: 45 минут

Бүлгийн гишүүдийн тоо: 6-8

Гүйцэтгэх алхмууд:

1. Тэдэнд өөрийнх нь сэтгэл санаа ямархуу байгааг эхлээд бодуулна.
2. Оролцогчид өөрсдийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн баг, маск хийлгэж, өөртөө төрж байгаа мэдрэмжээ баг дээр зурахыг хүснэ.
3. Баг хийхэд хэрэгтэй цаасан таваг, бал харандаа, урт иштэй сойз, өд, гялгар чимэглэл зэрэг материалыг бэлдэж тавьсан байна.
4. Багууд нь цөхрөл, уур хилэн, урам хугарал, айдас, баяр хөөр, гуниг, ёжлол, нууцлаг байдал зэрэг шинжүүдийг илтгэнэ.
5. Багаа хийж дууссан оролцогчид түүнийгээ өмсөөд багт парад (энх тайвны алхалт) хийж 6 долоо хоногийн гар урлал, жүжигчилсэн тоглолт хийнэ.
6. “Аюулгүй ажиллагааны алтан дүрэм”-ийг бататгахдаа хүүхдүүд жижиг багууд болж жишээ тохиолдол авч үзнэ. Өөр дотроосоо зааварлагч гишүүдийг сонгосноор тэд зогс команд болон бусад командыг шат дарааллаар нь өгнө.
7. Хөтөлбөрийн төгсгөлд дараах үйл ажиллагааг хийж болно.

Оролцогчдын дунд хамтдаа хувааж идэх зүйл бэлдэж, хөтөлбөрийнхөө явцын зургийн цомгийг үзэж болно. Мөн бүгдээрээ тойргоор сууж хөтөлбөрийн талаарх сэтгэгдлээ илэрхийлэх нь бүх оролцогчдыг сэтгэл хөдлөлөө илэрхийлж сургах, цагийг найзуудтайгаа хамт үр дүнтэй бөгөөд бүтээлчээр өнгөрөөх, өөрийгөө таньж мэдэхэд ач холбогдолтой. Оролцогч бүрийн хувь нэмрийг үнэлж, тэдэнд дурсгал болгон авч явах нэг бүтээлч зүйл хийлгэж болно. Жишээлбэл: 8 оролцогчдод 8 ширхэг цаасаар өөрийгөө илэрхийлэх хуудас бэлтгэн оролцогчид дээр нь нэрээ бичээд баруун талдаа сууж байгаа оролцогчдод дамжуулна. Хүлээн авсан оролцогч нь тухайн оролцогчийн талаар урмын үг, зэрэг сайхан үгсийг бичиж мөн холбоотой байх утасны дугаар, мэйл хаяг зэргээ бичиж үлдээж болно. Ийнхүү баруун тийш цаасаа дамжуулсаар нэг оролцогчид 7 хүнээс захидал ирнэ гэсэн үг. Хамгийн сүүлд өөрийнх нь цаас мөн өөр дээр нь ирэхэд өөрийнхөө тухай бусад хүний бичсэн сэтгэгдлийг уншиж хадгална.



СЭДЭВ 3.4 ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙГ ШААРДЛАГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНД ХОЛБОН ЗУУЧЛАХ

Хичээлийн зорилго:

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажилладаг мэргэшсэн байгууллагын ажилтан холбон зуучлах үйлчилгээийн зорилго, зарчим, үе шатуудын талаар зөвлөгөө өгөх мэдлэгтэй болно.

Үндсэн ойлголтууд:

- Холбон зуучлах үйлчилгээний зорилго
- Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим
- Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үе шат
- Холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байгууллага

Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа	Цаг
1 Удиртгал хэсэг	10 минут
2 Үндсэн хэсэг	60 минут
3 Бататгах буюу дүгнэлт хэсэг	20 минут
Нийт	90 минут

Санал болгож буй арга зүй:

- Хэлэлцүүлэг
- Товч мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах
- Асуулт хариулт, харилцан ярилцах

Унших материал:

- “Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй” сургалтын гарын авлага, Бүлэг III

Хэрэглэгдэхүүн:

- Нэмэлт мэдээлэл 1. “Үйлчлүүлэгчийн шийдвэрт үндэслэн хууль зүйн үйлчилгээнд холбон зуучлахад өгөх зөвлөгөө”
- Нэмэлт мэдээлэл 2 “Эмзэг бүлгийн хохирогчийг үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээнд холбон зуучлахад зөвлөгчийн үзүүлэх туслалцаа, сайн туршлага”





ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн, хууль зүйн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах зайлшгүй шаардлагатай.

Холбон зуучлах үйлчилгээ

Эрүүл мэндийн үйлчилгээ	Эрүүл мэндийн салбар
Хууль зүйн үйлчилгээ	Шүүх, цагдаагийн байгууллага
Боловсролын үйлчилгээ	Боловсролын байгууллага
Нийгмийн үйлчилгээ	Нийгмийн ажилтанд хамаарна:
<ul style="list-style-type: none"> • Эрхэд суурилсан хандлага • Хохирогч төвт хандлага • Өөрчлөлтөд чиглэсэн хандлага 	<ul style="list-style-type: none"> • Тусламжийн утас (107, 108, 1800-1903) • Хямралын үйлчилгээ • Хамгаалах байр (Нэг цэгийн, түр хамгаалах...) • Санхүү, материаллаг тусламж дэмжлэг • Бичиг баримтжуулалт • Эрхзүйн зөвлөгөө, туслалцаа • Нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг, зөвлөгөө • Олон нийтийн боловсрол, мэдээлэл олгох • Эргэн нийгэмшүүлэх • Хэвийн амьдралд эргэж ороход нь туслах

Холбон зуучлах үйлчилгээ гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд хүчирхийллийн улмаас учирсан, учирч болзошгүй хор уршиг, үр дагаврыг арилгах зорилгоор шаардлагатай хамгаалалт, үйлчилгээ, туслалцаа (цаашид үйлчилгээ гэнэ) үзүүлэх, холбогдох мэргэжилтэн, байгууллагатай холбож өгөх, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэх цогц үйл явцыг хэлнэ²⁶.

Холбон зуучлах үйлчилгээний зорилго нь хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон өгч, тэдний аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийллийн улмаас учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд эргэн оруулах, нөхөн сэргээх зэргээр хүчирхийллийг даван туулж дуустал нь тасралтгүй дэмжихэд оршино.

Хохирогчтой эхэлж холбоо тогтоосон байгууллага, ажилтан нь холбон зуучлах үйлчилгээг төлөвлөх, холбогдох байгууллага, мэргэжилтэн рүү шилжүүлэх, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэх зэргээр тухайн хэрэг хаагдаж дуустал кейсийн зохицуулалтыг бүрэн хийх үүрэг хүлээнэ. Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.

Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим:

- Аюулгүй байдлыг тэргүүн ээлжид хангана: Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.
- Нууцлалыг чандлан хадгална: Хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, өөртөө итгэх итгэл, үнэлэмж, хувийн нууцтай байх эрхийг хүндэтгэнэ. Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнтэй холбоотой мэдээллийг задруулах ёсгүй.
- Хохирогчийн зөвшөөрөл, оролцоог хангана: Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх бүхий л үйл явцад хохирогчийн сонголт хийх, шийдвэр гаргах эрхтэйг хүлээн зөвшөөрнө. Өөртэй нь хамаатай шийдвэр гаргах үйл явцад хохирогчийн оролцоог хангана.
- Ялгаварлан гадуурхахгүй байна: Хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд нас, хүйс, яс үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байна.

²⁶ ХНХЯ (2016) Холбон зуучлах үйлчилгээний журам



Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үе шатууд

1. Хохирогчийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох;
2. Хохирогчид хэрэгцээтэй үйлчилгээ, нөөц боломжийг судлах;
3. Хохирогчийг хамгаалалт, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгтэй холбох;
4. Үйлчилгээний чанарт хяналт тавих, эргэх холбоотой байх, үнэлэх;

НҮБХАС -гийн дэмжлэгтэйгээр нийт 15 нэг цэгийн үйлчилгээний төвүүд 10 аймаг, Улаанбаатар хотод байгуулагдан ажиллаж байна. Улсын хэмжээнд 14 гаруй хамгаалах байрууд ажилладаг байна:

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хамгийн түрүүнд хандах байгууллагууд

Нэрс	Үйл ажиллагаа	Түр хамгаалах байр	Холбоо барих утас
Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв	Сэтгэл заслын, эрх зүйн туслалцаа үзүүлдэг.	19-60 цаг	96490505 Мэдээлэл авна, зөвлөгөө өгнө
ЦЕГ-ын дэргэдэх Түр хамгаалах байр	Мэдээллийн дагуу нийгмийн халамжийн үйлчилгээ, холбон зуучлах, амь нас	7-30 хоног	107 Мэдээлэл авна, зөвлөгөө өгнө
Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхдийн тусламжийн утас	эрүүл мэндэд ноцтой асуудал үүссэн тохиолдолд тусламж үйлчилгээнд зуучилдаг	Утас 24 цагаар ажиллана	108 Сэтгэл зүйн зөвлөгөө өгнө, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар мэдээлэл авна.
Цагдаагийн байгууллага	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг мэдээлж болно.	Байхгүй	102 Үнэ төлбөргүй, нэгж унахгүй, 24 цаг ажиллана
Хууль зүйн туслалцааны төв	Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа өгөх үүрэг, өмгөөллийн үйлчилгээний чиглэлтэй ажилладаг ч гэмт хэргийн хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцаа жилээс жилд ихэссэн байгаа. ²	Байхгүй Хууль зүйн туслалцааны төв нь нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг болон хүн ам ихтэй зарим сумыг хамруулан нийт 33 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. ³	Хууль эрх зүйн лавлагаа 7000-1892
Хүний эрхийн үндэсний комисс	Өргөдөл, гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх	Байхгүй	Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай Засгийн газрын XI байр, V давхар Утас: 70 000 222, 51-262971, 51-262786
Монголын Хуульчдын Холбоо	Төлбөрийн чадваргүй, бага орлоготой, эмзэг бүлгийн иргэд хууль зүйн туслалцаа авах талаарх хүсэлт гаргах	Байхгүй	Чингэлтэй дүүрэг, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-7, Хууль зүйн үндэсний хүрээлэн



Нэг цэгийн үйлчилгээний төвүүд

Нийслэл, аймаг, дүүрэг	Холбогдох утас
Дорнод аймаг НЦҮТ	70584455
Хэнтий аймаг НЦҮТ	70563433
Говь-Алтай аймаг НЦҮТ	98299111
Завхан аймаг НЦҮТ	80740740
Баянхонгор аймаг НЦҮТ	70442122
Дархан-Уул аймаг НЦҮТ	70378737
Өмнөговь аймаг НЦҮТ	70532005
Хөвсгөл аймаг НЦҮТ	70382121
Баян-Өлгий аймаг НЦҮТ	7042102, 94442902
Хан-Уул дүүргийн НЦҮТ	88127821, 88049073, 89893773
Баянзүрх дүүргийн НЦҮТ	70150183
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн НЦҮТ	93070949 (жижүүрийн цагдаагийн утас)
Гэмтэл согогийн үндэсний төв	70180139
Сүхбаатар дүүргийн НЦҮТ	94016601
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	96490505
Нийслэлийн цагдаагийн хамгаалах байр	107

Гэр бүлийн хүчирхийлэл хүний эрхийн ноцтой зөрчил учир шинэчилсэн Эрүүгийн хуулиар²⁷ гэмт хэрэгт тооцсон. Гэмт хэрэгт тооцогдохооргүй үйлдлүүдийг зөрчил гэж үзсэн юм.

Эрүүгийн хуулийн 11.7 Гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл үйлдэх	Зөрчлийн тухай хуулийн 5.1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн
<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан Энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн 	<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, Бусадтай харилцахыг хязгаарласан, Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан
Ялын төрөл	Шийтгэлийн төрөл
<ul style="list-style-type: none"> Зорчих эрхийг хязгаарлах⁴ Хорих ял 	<ul style="list-style-type: none"> Торгох Албадан сургалтад хамруулах Баривчлах шийтгэл

Хуулийн онцлог тал! Хүчирхийлэл үйлдэгч зөвхөн тэжээгч гэдэг үндэслэлээр хариуцлагаас чөлөөлөгдөхгүй. Хүчирхийлэл үйлдэгч шийтгэлээ эдэлнэ. Гэр бүлдээ эргэж нэгдэхийн тулд зан үйлээ өөрчлөх сургалтад заавал хамрагдана.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдэлд хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд²⁸ (6 дугаар зүйл) тусгагдсан арга хэмжээнд хамрагдах эрх нээгдэнэ.

Тэрхүү хамгаалалтын арга хэмжээний төрөл нь

- ✓ Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ
- ✓ Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

²⁷ Төрийн мэдээлэл эмхтгэл, №23, (2017).

²⁸ Төрийн мэдээлэл эмхтгэл, №30, (2013).

Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, хэлбэр

- Гэрч хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх хамгаалалтын арга хэмжээ юм.

- урьдчилан сануулах
- тодорхой үйлдлийг хязгаарлах
- биечилсэн хамгаалалт
- мэдээллийн нууцлалыг хангах
- нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах
- аюулгүй газар түр байрлуулах
- нүүлгэн шилжүүлэх
- баримт бичгийг солих
- гадаад төрхийг өөрчлөх

Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ, хэлбэр

- Гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

- гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах
- гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх
- шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх
- шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах

Хамгаалалтад хамрагдах шалгуур нь:

- Зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсэн нөхцөлд
- Хохирогч хэрэг шалгаж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч болон өмгөөлөгчөөрөө дамжуулан хүсэлт гаргана
- Хүсэлтийг хүлээн авсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт халдлага үйлдэх үйлдэх бодит нөхцөл байдал, аюулын эрсдэлийн түвшнийг тогтооно
- Эрсдэлтэй түвшинд байна гэж үзвэл хамгаалалтад авах саналаа прокурор, шүүгчид гаргана
- Прокурор, шүүгчийн шийдвэрийн дагуу ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс аюулгүй байдал хамгаалалтын арга хэмжээгээ хэрэгжүүлж, гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг хийнэ. 29
- Хамгаалалтад авхуулах хүсэлтээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гаргаж болно

Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага албан тушаалтан хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг шийдвэр гаргахыг хүлээхгүйгээр хэрэгжүүлж, шийдвэр гаргуулахаар шүүхэд нэн даруй хандах үүрэгтэй.

Эрүүгийн журмаар мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж хохирогчийг иргэний нэхэмжлэгчээр тогтоох боломжтой. Энэ нь гэмт хэргийн улмаас хохирсон хохирлоо барагдуулахад хохирогчид нэлээд ач холбогдол бүхий заалт юм.

- Нэхэмжлэгчээр тогтоосноор улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн хүчирхийлэгчээс хохирлоо барагдуулах асуудлаар иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болно, гэхдээ эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.
- Тэрхүү нэхэмжлэлийг эрүүгийн шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэх боломжтой болно.
- Иргэний нэхэмжлэгч нь зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар иргэний шүүхэд гомдол гаргаж болно.

29 Ш.Шинэбаяр (2016, 12 сарын 5). Гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг ТББ-уудтай ч хамтран явуулах боломжтой. www.police.gov.mn Cit.07.17.2019. Retrieved from http://www.police.gov.mn/a/2435



Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн онцлог! Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нэн тэргүүнд шаардагдах хамгаалалт бол урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлах, мэдээллийн нууцлалыг хангах, аюулгүй газар түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх. Харин сэтгэлзүйн хамгаалалт зайлшгүй байнга авах ёстой эрх юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, туслалцаа авах эрхийн хүрээнд түүний аюулгүйн байдлыг хангахад шуурхай авах арга хэмжээ нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сум, баг, засаг даргын үүрэгт шуурхай авах арга хэмжээ	Цагдаагийн албан хаагчийн шуурхай авах арга хэмжээ
<ul style="list-style-type: none"> • Хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх • Хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох • Хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, боломжтой бол хохирогчийг төрөл, садан, ойр дотнын хүний түр хамгаалалтад өгөх • Хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллээр хангах • Хохирогчийн зөвшөөрснөөр харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх • Хохирогч бие махбод, сэтгэл санааны хувьд ноцтой хохирол хүлээсэн, хохирч болзошгүй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй гэж үзвэл хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд, эсхүл сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэх 	<ul style="list-style-type: none"> • Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орох эрхтэй • Шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн этгээд, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авах • Цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг хүчирхийлэл үйлдэгч биелүүлэхээс татгалзсан, эсхүл эсэргүүцсэн бол албадлага хэрэглэх • Хохирогчид орон байрнаасаа хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл, хэрэглээний шаардлагатай эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулах • Хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах • Шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах • Хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авах

Гэр бүлийн хүрээнд үйлдсэн хүчирхийлэл нь Эрүүгийн хуулийн 11.7 заасан шинж тэмдэг илрээгүй бол хүчирхийлэл үйлдэгчид Зөрчлийн тухай хуулийн 5.1 зүйлд заасан шийтгэл оногдуулна. Гэр бүлийн хүчирхийлэлТТ хуулийн хүрээнд үүрэг хүлээсэн албан хаагчид гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, эрүүгийн шинжтэй бол Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцуулах эрхтэй. Хүчирхийлэл үйлдэгчид чиглэсэн шийтгэл нь зан үйл өөрчлөх сургалтад хамруулна. Уг сургалт хоёр хэлбэртэй.

- Сайн дурын зан үйл өөрчлөх сургалт нь: Ял шийтгэлийн журмаар биш харин хувь хүн өөрөө хүчирхийллийн үйлдэлдээ дүгнэлт үнэлгээ хийж, ойлгосон үед, үүнийгээ яаж засах вэ гээд өөрийгөө мэдрээд байгаа хүмүүс сургалтад хамрагдах хүсэлт гаргаж болно.
- Албадан зан үйл өөрчлөх сургалт нь: Ял шийтгэлийн журмаар өөрөөр хэлбэл Баривчлах арга хэмжээ авсан үедээ (хохирогчийг байнга дарамталсан, доромжилсон хэрэгт шийтгэл эдлүүлэх) албадан сургалтад хамрагдана.



Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч зайлшгүй мэдэж байх ёстой зүйлс!

- Хохирогч гомдлоосоо татгалзсан буюу хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг зогсоох үндэслэл болохгүй.
- Гэр бүлийн хүчирхийлэл дээр эвлэрэхийг ерөнхийдөө хориглож байгаа. Яагаад гэвэл тэнцвэртэй харилцаа биш. Давамгайлсан хүчирхийллийн харилцаатай байдаг учраас ердийн гэр бүлээс ялгаатай.
- Гэр бүлийн хүчирхийлэгчийн зорчих эрхийг хязгаарладаг болсон. Заасан хязгаараас давсан тохиолдолд хүчирхийлэгч, хохирогч хоёр ойртсон үед дохио өгдөг бугуйвч зэргийг зүүлгэхээр заасан байна. Ингэсэн тохиолдолд цагдаа ирж арга хэмжээ авна.

Давуу тал!

- Хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдсэн л бол энэ нь шууд эрүүгийн хэрэг болно.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгааг мэдэгдсэн дуудлагыг цагдаагийн байгууллага авсан даруйдаа хамгийн түрүүнд очих үүрэгтэй.
- Хүүхэд хууль ёсны төлөөлөгчийнхөө³⁰ хүчирхийлэлд өртсөн бол цагдаа тэдгээр хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзалгүйгээр хүүхдийг хамгаална.
- Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлээгүй иргэнд Зөрчлийн хуульд заасны дагуу хариуцлага тооцохоор болсон байна.

Сул тал!

- Эрүүгийн хэрэг үүсгэсний дараа л сэтгэлзүйн хамгаалалт авах эрх үүснэ.
- Хамгаалалтын арга хэмжээг зөвхөн эрүүгийн шүүхийн шүүгчийн шийдвэрээр гүйцэтгэж байгаа нь эрүүгийн хариуцлагын шинжийг агуулж байна. Өөрөөр хэлбэл бусад орны туршлагаас үзэхэд хамгаалалтын арга хэмжээг иргэний шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлдэг ба энэ нь эрүүгийн хариуцлагын хэмжээнд үнэлэгдэхгүй харин тухайн шийдвэрийг биелүүлээгүй, зөрчсөн тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид эрүүгийн арга хэмжээ авах буюу хариуцлага оногдуулдаг байна. Монгол Улсад Эрүүгийн шүүхийн шүүгчийн ачаалал их байна гэсэн үг.
- Төлбөрийн чадваргүй хохирогч үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авах эрх зүйн орчин бүрдээгүй байна.
- Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах арга хэмжээнүүд зөвхөн эрүүгийн шүүхийн шийдвэрээр үйлдэгддэг байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө аюулгүй байдлын хамгаалалт авах боломжгүй.

Гэмт хэргийн улмаас үүдсэн сэтгэл санааны хохирлоо нэхэмжлэх

Өнөөдөр хүчирхийллийн хохирогчид бие, сэтгэлээрээ хохирч ялангуяа сэтгэл зүйд учирсан хохирлоо хохирсон хэмжээндээ нөхөн төлүүлж чадахгүй байна.

Нөхөн төлүүлэх эрх зөвхөн иргэний журмаар явагдана!

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгахад хохирогчийн шаардах эрхийг хуульчилсан ба хэрэгжүүлэх

³⁰ Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч гэж эцэг эх, ах эгч нар, хүүхэд асрах төвийнхөн, халамжийн төвийнхөн, үрчилж авсан хүмүүсийг хэлнэ.



арга зам нь материаллаг хууль болох Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль, Эрүүл мэндийн тухай гэх мэт хуулиар зохицуулагдана.

Хохирогчийн эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл зүйд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэхэмжлэх ажиллагаанд өмгөөлөгчийн мэдлэг, ур чадвар чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэвч өнөөдөр Монгол улсад мөрдөгдөж буй материаллаг болон процессын (эрх зүйгээр) хуулиудад хүчирхийллийн хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг хэрхэн тодорхойлох, арилгах асуудлыг хуульчлаагүй, хуулийн заалтууд нь өөр хоорондоо зөрчилтэй, хэрэглэхэд бэрхшээлтэй байгаагаас хүчирхийллийн хохирогчид хуулиар олгосон эдийн бус хохирол буюу сэтгэл зүйд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх төдийлөн хэрэгжихгүй байна.

Монгол Улсын Иргэний хууль³¹

230 дугаар зүйлийн 230.1. Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй.

230 дугаар зүйлийн 230.2. Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.

511 дугаар зүйлийн 511.1. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

511 дугаар зүйлийн 511.2. Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.

Материаллаг хуулийн сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох, хянан шийдвэрлэх арга механизмыг хуульчилсан заалтууд нь эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарлан зохицуулсан төдийгүй тухайн хуулийн заалтыг хэрэгжүүлэх механизм бүрэн төгөлдөржөөгүй.

Иргэний журмаар сэтгэл зүйн хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх арга зам!

Гэмт хэргийн хохирогчид учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг иргэний шүүхэд гаргана.

- Эдийн бус хохиролд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй. Жишээлбэл хохирогчийн бие махбодын гэмтлийн эмчилгээг дуусгавар болгосны дараа хохирлын хэмжээ тодорхой болсон үед нэхэмжилнэ. Хэрэв хохирол учирснаас хойш таван жилийн дараа нэхэмжлэл гаргавал хүчингүй болно. Түүнчлэн, талуудын хүсэлтээр шүүх хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журмыг өөрчилж болно.
- Гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хөөн хэлэлцэх хугацаа урт байх тохиолдолд уг хуульд заасан хугацаанд хариуцлага хүлээлгэсэн этгээдэд нөхөн төлбөр олгох тухай нэхэмжлэл хүчинтэй хэвээр байна.
- Хохирогч амь, эрүүл мэндийн даатгал хийлгэсэн тохиолдолд уг нөхөн төлбөрийг даатгалын компани нь гэмт хэрэг үйлдэгчээс хохирлыг нөхөн төлүүлэх тухай иргэний хэрэг үүсгэж болно.

31 Төрийн мэдээлэл эмхтгэл, №7, (2002)

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эдийн бус хохирлыг эдийн хохиролд тооцох аргачлал:

Нөхөн төлбөр шаардах эрхийн нэхэмжлэлд дараах нотлох баримтуудыг хавсаргаж болно.

- Эмчилгээ хийлгэсэн төлбөрийн баримтууд
- Сэтгэлзүйн үйлчилгээ авсан төлбөрийн баримт, үйлчилгээ авсан бүрийн төлбөрийн баримт
- Цалингийн тодорхойлолт, байнгын орлоготой байсан эсэх тухай нотолсон баримт, үүнийг ажил хөдөлмөр эрхлээгүй үеийн хугацаанд тооцон оруулах (3 сар ажилгүй байсан бол 3 сарын хөдөлмөрийн хөлстэй тэнцэхүйц мөнгөн дүн нэхэмжлэх)
- Эрүүл мэндийн үнэлгээ, сэтгэл зүйн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн баримт, төлбөр төлсөн баримтууд
- Унааны зардал, төлбөр төлсөн баримтууд гэх мэт
- Амь насанд аюултай гэмтэл учруулсан, Эрүүл мэндийн байдлыг удаан хугацаагаар сарниулсан, гэмтлээс их хэмжээний үлдэц, уршиг үүссэн, хөдөлмөрийн ерөнхий чадвар их хэмжээгээр буюу тогтонги байдал нь алдагдсан бол нийгмийн халамж авах эрх үүснэ.

3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч Гэрлэлтээ Шүүхээр цуцлуулах эрхтэй³²

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна ”

Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл “Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйл “Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.”

32 Улсын Дээд Шүүх, Иргэний танхим (2013, 12 сарын 13). Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар /тойм/. www.supremecourt.mn Cit.08/20/2019. Retrieved from 2019 <http://www.supremecourt.mn/act/view/58>





Гэрлэгчид

Эрх	Үүрэг
<ul style="list-style-type: none"> • Гэр бүлээ төлөвлөх • Оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох • Хуваарьт эд хөрөнгөтэй байх • Дундаа хамтран өмчлөх эд • хөрөнгөө эзэмших, ашиглах, • захиран зарцуулах • Материалын болон сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах 	<ul style="list-style-type: none"> • Бие биедээ үнэнч байх • Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх • Бие биеэ халамжлан хүндэтгэх • Тэжээн тэтгэх, туслах • Гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх • Хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй байх • Бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх • Угийн бичиг хөтлөх

Гэр бүлийн тухай хуулийн 14.1, 14.4-т заасны дагуу гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлтэй болон гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон тохиолдолд гэр бүл цуцлах тухай маргаантай хэргийг шүүх шийдвэрлэнэ.

Гэрлэгчдийн дунд гэр бүлийн хүчирхийлэл байгаа, эвлэрэх боломжгүй гэж шүүх үзсэн бол эвлэрүүлэх хугацаа өгөхгүйгээр гэрлэлтийг цуцалж болно. Үүнийг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.-т зохицуулжээ.

“Гэрлэгчид эвлэрэх боломжгүй” гэдэгт гэрлэгчид цаашид хамтран амьдрах бодит нөхцөл байхгүй болохыг ойлгоно. Уг ойлголтод хэн нэг нь согтуурах болон мансуурах бодис байнга хэрэглэдэг, бэлгийн харилцаа тохирохгүй байх, гэр бүлийн гишүүдийг өөрийн эрхшээлд байлгахаар хүч хэрэглэж, биед нь халдах, айлгах, сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөж мөшгөх, гэр бүлийн дундын өмчийг дангаар захиран зарцуулах зэргээр сэтгэл санаа, бие махбод, эдийн засгийн байнгын хүчирхийлэл, дарамт үзүүлснээр гэр бүлийн бусад гишүүд, ялангуяа хүүхдэд ноцтой хор хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй байхыг хамааруулна.

Гэрлэлт цуцлах - Энэ нь гэрлэлт дуусгавар болох нэгэн үндэслэл бөгөөд гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэрлэгчдийн хамтын амьдрал, тэдний хүсэл зоригийн үндсэн дээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр дуусгавар болохыг ойлгоно.

Шүүх гэрлэгчдийн гэрлэлтийг цуцалснаар гэрлэлтийн харилцааг дуусгавар болгохын зэрэгцээ эрх зүйн өөр харилцааг шинээр үүсгэнэ. Тухайлбал: гэр бүлийн гишүүнд оногдох дундын эд хөрөнгө, хүүхдийн асрамж, тэтгэлэг буюу асран хамгаалалтын болон тэжээн тэтгэх харилцааг шинээр үүсгэдэг болно.

Шүүхийн журмаар гэрлэлтийг цуцлах:

Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг шүүхийн нутаг дэвсгэрийн нийтлэг харьяаллын дагуу хариуцагчийн оршин суугаа газрын харьяа шүүхэд гаргах бөгөөд нэхэмжлэгч нь бага насны хүүхэдтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газарт очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэл нь ИХШХШ тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрдүүлбэрийг хангасан байхаас гадна гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлах болсон шалтгаан, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн байдал, насанд хүрээгүй хүүхдийг



хэний асрамжид үлдээх, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаар ямар хүсэлт гаргаж байгаагаа нэхэмжлэлд тодорхойлон бичиж холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.

Анхаарах зүйл! Шүүх гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэхдээ насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжид үлдээх, хүүхдийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, гэр бүлийн гишүүний хуваарьт болон хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах талаарх маргаан гарвал асуудлыг хамтатган шийдвэрлэнэ. Түүнчлэн нэхэмжлэгч, хариуцагч маргааныг хэнийх нь оршин суугаа газрын харьяа шүүхээр хянан шийдвэрлүүлэх вэ? гэдгийг тохиролцон тогтоож болно.

Иргэний Шүүхэд Гэр бүл цуцлах нэхэмжлэл гаргах тохиолдолд 70200 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан тушаасан байх шаардлагатай.

70200 төгрөг нь эд хөрөнгийн бус болон үнэлэх боломжгүй нэхэмжлэлд төлөх төлбөр юм. Тухайлбал, гэр бүл цуцлах, хүүхдийн тэтгэмж, эцэг эх тогтоолгох гэх мэт.

Иргэд иргэний журмаар нэхэмжлэл гаргахад улсын тэмдэгтийн хураамж төлөх үүрэгтэй. Хэрэв эмзэг бүлгийн иргэд иргэний журмаар нэхэмжлэл шүүхэд гаргах үед улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөх, хураамжийн хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно.

Ямар тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдөх боломжтой вэ?

Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээд хуульд зааснаар төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.

Нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх хүсэлт гаргахдаа хүсэлтийг гаргах болсон шалтгаан, төлбөрийн чадваргүй болохоо нотолсон баримтыг хавсаргаж өгөх шаардлагатай. Үүнд:

- Нэхэмжлэл гаргагч оршин суугаа засаг захиргааны сум баг хорооноос амьжиргааны доод түвшинд амьдардаг (үүнд ам бүлийн тоо, ажилгүй, орлогогүй болон зөвхөн нийгмийн халамжийн орлоготой) гэсэн тодорхойлолтыг оршин сууж буй засаг захиргаанаас авна.
- Суралцдаг бол тухайн сургуулийн тодорхойлолт
- Группэд байдаг бол группийн дэвтрийн хуулбар гэх мэт төлбөрийн чадваргүй болохоо нотолсон бусад баримтуудыг шүүхэд гаргаж өгнө.
- Тухайн иргэний нэр, ам бүл нь дүүрэг баг хороо сумын засаг захиргааны амьжиргааны доод түвшинд амьдардаг нэрсэнд байж байх зэрэг нотлох баримтуудыг нэхэмжлэлийн хамт шүүхэд гаргаж өгнө. (нэн ядуу, эмзэг бүлгийн)
- Хэрэв эд хөрөнгийн маргааны асуудалтай бол улсын тэмдэгтийн хураамжийг уг нэхэмжлэлийн хамт төлөх боломжгүй бол эд хөрөнгөө өөрийн эзэмшилд болгосны дараа төлөх буюу дараа хэсэгчлэн төлөх хүсэлтээ нэхэмжлэлийн хамт шүүхэд гаргаж болно.

Улсын тэмдэгтийн хураамжаас зөвхөн шүүхийн шийдвэрээр (шүүгчийн захирамжаар) чөлөөлнө.





Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэн хамгаалах вэ?

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд болон түүний эдлэх эрх, хамгаалалтын арга хэмжээг авахдаа хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих үүрэгтэй. Хүүхдийн эрхийг хамгаалж байна гээд эцэг эхээс нь салгах үүрэг байхгүй хэдий ч холбогдох чиглэлийн албан хаагчид үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ.

- ✓ Хүүхэд гэдэг нь 18 насанд хүрээгүй хүний хэлнэ.³³
- ✓ Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах нь төрийн үүрэг.
- ✓ Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн хамгаалах үүрэгтэй.
- ✓ Насанд хүрсэн хүн нь хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архи дан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.

Хохирогч хүүхдийн эрх	Хэн хийх вэ
<ul style="list-style-type: none"> • Нөхөн төлбөр авах эрх • Хувийн мэдээлэл нууцлалтай байх • Хүчирхийлэл үйлдэгчтэй холбоо тогтоохгүй байх • Аюулгүй байдлын хамгаалалт авах эрх • Сэтгэлзүйн хамгаалалт авах эрх 	<ul style="list-style-type: none"> • Хууль ёсны төлөөлөгч • Монголын хуульчдын холбооноос хүүхдийн эрхээр ажилладаг мэргэшсэн өмгөөлөгч томилох • Хүүхдийн асуудлаар мэргэшсэн сэтгэл зүйч байх
<ul style="list-style-type: none"> • Хууль ёсны төлөөлөгчийн хамт Шүүх хуралдаанд оролцох эрх 	<ul style="list-style-type: none"> • Хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шалгаж буй мөрдөгч, прокурор, шүүгчид хүсэлт гаргах хэлбэрээр оролцох
<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй байх эрх</p> <ul style="list-style-type: none"> • хэрэг бүртгэл, мөрдөн шалгах үе • Прокурорын үе • Шүүх хуралдааны үе 	<p>Хууль ёсны төлөөлөгч болон өмгөөлөгчөөрөө дамжуулна.</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийг тусгайлсан хүүхдийн өрөөнд хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл авах түүнийгээ дүрсжүүлэх • Сэтгэлзүйчтэй оролцох • Мэргэшсэн өмгөөлөгч, хүүхдийн байгууллагын ажилтан байх

³³ Хүүхдийн эрхийн конвенци, Нэгдүгээр хэсэг, 1 дүгээр зүйл, (1990).



Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд

Зохицуулагдах хууль

- Хэрэв хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, эцэг эхийн ашиг сонирхол нь хүүхдийн эрх ашигт харшлах юм бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг (тусгай асран хамгаалагч) томилохоор шүүх, прокурорт хандана.
- Тусгай асран хамгаалагч нь хохирогч хүүхэдтэй холбоотой бүхий л мэдэгдлийг гаргаж, хохирогчийн эрх эдэлнэ.
- Гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрх ашиг сонирхлыг ЭХ-ийн 16 бүлэг Хүүхдийн эсрэг гэмт хэрэг,
- ЭХХШТХ-ийн 8.2-т Хохирогчийн эрх
- Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 Хүүхдийн эрхийг зөрчих хуулиар зохицуулагдана.
- Бусад хуулиуд болох Гэр бүлийн тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар хамгаалалтыг хангах юм.

Хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага оногдуулах вэ?

- Эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах⁷
- Торгох
- Олон нийтэд тустай ажил хийлгэх
- Зорчих эрхийг хязгаарлах ял
- Тодорхой хугацаагаар хорих
- Сургуулийн нийгмийн ажилтан, багш, сургуулийн захиргааг торгоно

Гэр бүлийн тухай хуулийн 30 дугаар зүйлд хэрэв эцэг эх байх эрхээ эрх урвуулан ашигласан тухайлбал хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болно.

Эцэг, эх байх эрх хасуулах тухай нэхэмжлэлийг эцэг буюу эх нь, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага тухайн эцэг, эхийн оршин суугаа газрын шүүхэд гаргах эрхтэй. Эцэг, эх байх эрх хассан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор шүүх улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

Анхаарах асуудал! Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн талаарх мэдээлэл өгсөн хэсэгт тусгагдсан эрхийг хүүхдэд мөн адил хамаарна гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Хуулийн ажиллагааны үед анхаарах зүйлс:

- Хэрэв хохирогч 18 нас хүрээгүй бол түүнийг хүүхэд гэж тооцно.
- Хохирогч хүүхэдтэй харьцахад юуны түрүүнд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүнд тавьж удирдлага болгоно.
- Тусгай хамгаалалтын арга хэмжээг хүүхдийн хэрэгцээнд тулгуурлан авна гэдгийг эрх бүхий байгууллагын ажилтан мэдэж байх ёстой.
- Хохирогч хүүхдийг шалгах тусгай арга, хүүхдээс мэдээлэл хэрхэн яаж авах талаар мэдлэг, чадвартай байна.
- Эрх бүхий байгууллагын албан хаагчид тухайлбал өмгөөлөгч, шүүгч прокурор хүүхдэд сөрөг үр нөлөө гаргахаас зайлсхийхийн тулд хүүхдийн нас, хувийн онцлог, болон өөр бусад нөхцөл байдлыг анхааралдаа авах үүрэгтэй.
- Хохирогч, гэрч хүүхдийн шүүх хуралдаанд хүүхдийг хохирогчоор оролцуулах бол



түүний эцэг эх, асран хамгаалагч, сэтгэл зүйч, эсхүл хууль ёсны төлөөлөгчийн хамт оролцоно.

- 16 нас хүрээгүй гэрч, хохирогчийг албадан ирүүлэхийг хориглох ба санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүй.
- 16 нас хүрсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд бие даан мэдэгдэл хийж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд дараах арга хэмжээнд хамрагдана.

- Аюулын эрсдэлийн зэргээс үүдэн эцэг, эх, төрөл, садны болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх
- Хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх
- Гэр бүлийн хүчирхийлэл-д өртсөн хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс нь тусгаарлан нэг цэгийн үйлчилгээнд хамруулах
- Түр хамгаалан байрлуулах тохиолдолд насанд хүрсэн этгээдээс тусад нь байрлуулна.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ 1. ХОХИРОГЧИЙН ШИЙДВЭРТ ҮНДЭСЛЭН ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХОЛБОН ЗУУЧЛАХАД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т: “хүн бүр...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй” гэж зааснаараа өмгөөлүүлэх эрхийг хангах эрх зүйн зарчмын үндсийг тодорхойлсон билээ. Гэхдээ хүний эрх нь хуульчлан тунхагласнаар аяндаа хэрэгжих зүйл биш бөгөөд хангах баталгааг нь бүрдүүлж, хэрэгжих механизмыг нь бий болгосон цагт жинхэнэ утгаараа хэрэгждэг. Энэ үүднээс өмгөөлүүлэх эрхийг амьдралд жинхэнэ утгаар нь, бодитойгоор хэрэгжүүлж хангахын тулд хэрэгжих бүхий л талын баталгааг бий болгох шаардлагатай.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцааг Эрх зүйн зөвлөгөө, Өмгөөллийн үйлчилгээний хэлбэрээр авч болохоор заасан байна (Гэр бүлийн хүчирхийлэлТТХ 39 дугаар зүйл).

- ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ гэдэг нь хууль зүйн асуудлаар амаар, бичгээр, утсаар болон цахим хэлбэрээр лавлагаа мэдээлэл өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулж туслах ажлууд орно.
- ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ гэдэг хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулахаар эрүү, иргэний ажиллагаа, тэдгээрийг шүүхээр хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцохыг ойлгоно. Өмгөөллийн үйлчилгээ авах эсэх талаар хохирогч өөрөө шийдэх буюу түүнд тулгаж болохгүй.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг дараах байдлаар эдэлж болно.

- Өмгөөлөгчид шууд хандаж хэлцэл хийх, эсхүл Хуульчдын холбоонд хүсэлт гарган тус холбооны өмгөөлөгчдийн болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагаанаас сонголт хийх замаар өмгөөллийн үйлчилгээ туслалцаа авах боломжтой.
- Иргэн, хуулийн этгээдийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь өмгөөлөгч болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагаа өгч болно.
- Хуульчдын холбоо өмгөөлөгч, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн нэрсийн жагсаалтыг нийтэд нээлттэй болгож, хэвлэн нийтэлнэ.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг байгууллагууд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч нь эмэгтэй хүн бол мэргэшсэн байгууллагууд эмэгтэй өмгөөлөгч авахыг зөвлөх
- Ер нь өмгөөлөгчийн төлөөлөл байх албагүй боловч гэмт хэргийн тухай мэдээлэл өгөхөөс өмнө зайлшгүй өмгөөлөгчөөс хуулийн зөвлөгөө авахыг зөвлөх
- Үүний дараа л хохирогч өмгөөлөгчийн туслалцаатай хуулийн процедурыг сонгох
- Хохирогчийн эдлэх эрхүүдийг танилцуулах, мэдээлэл өгөх
- Гэр бүлийн хүчирхийлэл гэмт хэрэг учир эрүү, зөрчлийн хуулиар заавал хариуцлага тооцдог, хуулийн ажиллагаа хохирогчийг хамгаалах үүрэгтэй, өөрт нь буруу байхгүй гэдгийг ойлгуулах

Мэргэшсэн өмгөөлөгчтэй хамтран ажиллахын давуу талууд!

- Хохирогчийн эрх, нэмэлт эрхүүд болон нэн тэргүүнд шаардагдах аюулгүйн байдал, сэтгэл зүйн хамгаалалт авах эрхүүдээ эдлэх боломжтой
- Хууль зүйн мэдээлэлтэй болно
- Хүчирхийлэл үйлдэгчтэй өмгөөлөгчөөрөө дамжуулан хэлэлцээ хийх сануулга өгөх боломжтой
- Шүүх хуралдаанд оролцохгүй байх боломжтой
- Сэтгэл санааны хохирол буюу эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрт тооцон нэхэмжлэх эрхийн мэдлэгтэй, иргэний шүүхэд хохирогч өмгөөлөгчийн хамт нэхэмжлэх ажиллагаанд оролцох боломжтой
- Шүүхэд үнэлэгдэх нотлох баримттай болно (Жишээлбэл: эмчилгээ хийсэн төлбөрийн баримт, унааны зардалд зарцуулсан төлбөрийн баримт гэх мэт тухайн гэмт хэргийн үр дагаврыг арилгах зорилгоор хохирогчийн зүгээс төлбөр төлсөн баримтууд орно).

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ 2. ЭМЗЭГ БҮЛГИЙН ХОХИРОГЧИЙГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХОЛБОН ЗУУЧЛАХАД ЗӨВЛӨГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА, САЙН ТУРШЛАГА

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрх ашгийг өмгөөлөгч төлөөлөх эрх зүйн үүрэг байхгүй. Хэрэв өмгөөлөгч зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хохирогч хүсэлтээ Монголын хуульчдын холбоонд бичгээр гаргана. Эсвэл тухайн чиглэлээр ажилладаг төр, иргэний байгууллагуудад хандан хүсэлтээ илэрхийлж болно. Хэрэв тухайн хэрэгт хууль зүйн олон асуудал шийдвэрлэх тохиолдолд өмгөөлөгчтэй байхыг зөвлөх нь зүйтэй. Хэрэв хохирогч нь бага орлоготой бол өмгөөлөгчийн зардлыг эрүүгийн хэрэг хянах үед хохирлын хэмжээндээ мөнгөн хэлбэрээр тусган цаашид нэхэмжлэлд оруулж болно.





Үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн үндэс

- Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үүргийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 34.3.1.6. “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа” гэж хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилготой аливаа үйл ажиллагааг” хуульчилж өгсөн нь Өмгөөлөгчийн Шүүхэд төлөөлөх эрхтэй хуульч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үндэслэл болж байна.
- ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажилладаг байна (ГХХТХ. 2013).

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч буюу хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь энэ тухай Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авна.

МЭДЛЭГИЙН САНД!

«Виктимология» гэдэг нь Victim гэдэг латин гаралтай хохирогч гэсэн утгатай үг, грек гаралтай Logos буюу Сургаал гэсэн үгнээс үүдэлтэй бөгөөд энэ нэр томъёо нь өнөөдөр Хохирогч гэж хэн болох, хохирогч гэмт этгээд хоёрын харилцаа, хохирогчийн зан төлөв, үйл хөдөлгөөн, гэмт хэрэг гарахад хэрхэн нөлөөлсөн, ямар хүмүүс хохирогч болох магадлалтай, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх арга замыг судалдаг Криминологийн шинжлэх ухааны бие даасан салбар, судлагдахууны нэр болсон байна.

Виктимологийн судлах асуудалд:

- Гэмт хэргийн хохирогчийн сэтгэл зүйн хувийн онцлог (гэмт хэрэгт өртөхөд хүсэл зориг, сэтгэл хөдлөл, зан төлвийн ямар шинж чанар нөлөөлсөн)
- Гэмт хэрэгтэн ба хохирогчийн хоорондын харилцаа (гэмт хэрэг үйлдэгдэх урьдчилсан нөхцөлийг бий болгоход, үйлдэгдэхэд энэ харилцаа хэрхэн нөлөөлсөн, гэмт хэргийн сэдэл)
- Хохирогчийн гэмт халдлагад өртсөний дараах зан үйл (өөрийн эрхийг нөхөн сэргээх арга хэмжээ авч байгаа эсэх, хуулийн байгууллага болон шүүхэд өөрийн эрхийг хамгаалуулахаар хандаж байгаа эсэх, тэднээс үнэн зөвийг тогтооход саад болж буюу эсвэл тусалж байгаа гэж үзэх)
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, юуны өмнө хохирогчийн эрүүл мэндийг нөхөн сэргээх боломж, арга замууд ордог

34 Төрийн мэдээлэл эмхтгэл, №11, (2012)



ТОВЧЛОЛ

ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГХХТХ	Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
ЗТХ	Зөрчлийн тухай хууль
ИХ	Иргэний хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ХЭХТ	Хүүхдийн эрхийн тухай хууль
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ЭЗНСОУП	Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт
ЭАУБХУИК	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенц





НОМ ЗҮЙ

- А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг (2008) Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь, УБ
- В.Бэрцэцэг (2019) Урлагийн сэтгэл засал, УБ
- НҮБ-ын Хүн амын сан, ЖҮХ (2018). Жендэр ба бодлого төлөвлөлт. Модул сургалтын материал, УБ
- НҮБХАС (2018) Жендэрт сууррилсан хүчирхийлэл - гэр бүлийн хүчирхийллийн гинжийг тасал. УБ
- Каяа Талвихару. (2002). Нийгмийн ажлын зөвлөгөө өгөх арга зүй. Хэвлэгдээгүй
- Ор, П. П. (2007). Байгалийн гамшгийн дараа хүүхдэд урлагийн сэтгэл заслын эмчилгээ хийх нь: Агуулгын шинжилгээ. Сэтгэл заслын эмчилгээ дэх урлаг, 34(4), 350-361.
- ҮСГ (2018) Хүчирхийллийн нүцгэн үнэн, УБ
- Brooke, S. L. (1995). Art therapy: An approach to working with sexual abuse survivors. *The Arts in Psychotherapy*, 22, 447-466.
- Bonnie Thomas, 2009-Creative Coping Skills for Children,
- Canadian Art Therapy Association (n.d.) what is art therapy? Retrieved on June 5, 2017, from <http://www.canadianarttherapy.org/what-is-art-therapy/>
- Eaton, L. G., Doherty, K. L., & Widrick, R. M. (2007). A review of research and methods used to establish art therapy as an effective treatment method for traumatized children. *The Arts in Psychotherapy*, 34(3), 256-262.
- Emotional Support through Arts and Crafts Activities Bonnie Thomas
- Foundation of Art therapy, Glenda Needs, 2013
- Judith A Ruth, 2010, Art Therapy - An Introduction, 2nd edition,
- Kaiser, D., & Deaver, S. (2009). Assessing attachment with the Bird's Nest Drawing: A review of the research. *Art Therapy: Journal of the American Art Therapy Association*, 26(1), 26-33.
- Kamal, G., Ray, K. & Muniz, J (2016) Reduction of cortisol levels and participants' responses following art making, *Art Therapy*, 33, 2, 74-80, DOI:10.1080/07421656.2016.1166832.
- Kimport, E. R., & Robbins, G. (2012). Efficacy of creative clay work for reducing negative mood: A randomized controlled trial. *Art Therapy: Journal of the American Art Therapy Association*, 29(2), 74-79.
- Kramer, E. (1993). *Art as therapy with children*. Chicago: Magnolia Street Publishers.
- Malchiodi, C. (2012). *Trauma-Informed Expressive Arts Therapy*.
- Peacock, M. E. (1991). A personal construct approach to art therapy in the treatment of post sexual abuse trauma. *American Journal of Art Therapy*, 29(4), 100-109.
- Pifalo, T. (2002). Pulling out the thorns: Art therapy with sexually abused children and adolescents. *Art Therapy: Journal of the American Art Therapy Association*, 19(1), 12 – 22.
- Pifalo, T. (2006). Art therapy with sexually abused children and adolescents: Extended research study. *Art Therapy: Journal of the American Art Therapy Association*, 23(4), 181-185.
- Proulx, L. & Winkel, M. (2015). Art therapy with families in Canada In C. Kerr (Ed.) *Multicultural Family Art Therapy*, (pp. 22-33). New York, NY: Routledge.
- Using Expressive Arts to Work with Mind, Body and Emotions Theory and Practice Mark Pearson and Helen Wilson
- Using Storytelling to Build Emotional, Social and academic Skills across the Primary Curriculum Jennifer M. Fox Eades
- Warson, E. (n.d.) *Visual Journaling: Promoting wellness through the arts*.



